



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-13
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	14-104

1.Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	17-21
2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	21-23
3.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	23-68
4.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	68-78
5.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	78-83
6.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 2 гишүүн 2024.04.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	83-90
7.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 13 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	90-99
8.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	99-101
9.Баталсан Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсох	103

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 03-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 10 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Н.Алтанхуяг, Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Б.Бейсен, С.Бямбацогт, С.Ганбаатар, Н.Ганибал, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Д.Өнөрболор, Б.Саранчимэг, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, Б.Чойжилсүрэн, Т.Энхтүвшин, Ж.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Д.Батлут, Б.Баярсайхан;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ж.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар, Ш.Раднаасэд;

Тасалсан: Х.Болорчулуун, Ж.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр;

Хоцорсон: Г.Ганболд- 01 минут, Б.Жавхлан- 4 цаг 22 минут, Г.Мөнхцэцэг- 46 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Т.Доржханд нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Т.Доржханд нар үг хэлэв.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлын дарааллын 4 дүгээрт хэлэлцүүлэх гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 22

Бүгд: 37

40.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.10-т заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	23
Бүгд:	37

37.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх санал хураалтыг хүчингүйд тооцов.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Д.Ганбат, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Г.Занданшатар: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.10-т заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	16
Бүгд:	37

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Соёлын дэд сайд П.Баттөр, Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Г.Батхуяг, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Батцэцэг, Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Ц.Чулуунбат, Ая зохиогч, продюсер Д.Өлзий-Орших, “В production”-ийн захирал Д.Болд, Монголын анимейшний холбооны гүйцэтгэх захирал Э.Тамир, “М мюзик” ХХК-ийн захирал Д.Батмагнай, “Өмгөөллийн Төгс энд Ко” ХХК-ийн захирал Г.Төгсбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундррам танилцуулав.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, /цаашид тохиолдол бүрт нийцүүлэн өөрчлөх/, 12.4 дэх хэсгийн “нөхцөл,” гэсний дараа “системийн мэдээллийг бүрдүүлэх этгээдэд тавих шалгуур,” гэж нэмж, 12.9 дэх хэсгийн “төрөөс” гэснийг болон 12.10 дахь хэсгийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай “12.8” дахь хэсэг нэмэх:

“12.8.Энэ хуулийн 12.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллага нь Оюуны өмчийн тухай хуулийн 17.2-г заасан объектын төрөл тус бүрийн зохиогчийн эрх эзэмшигчийн олонхыг нэгтгэсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	12
Бүгд:	37

67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.3-12.6” гэснийг “12.3, 12.5, 12.7” гэж, 12.9 дэх хэсгийн “бүтээгдэхүүний зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн чиглэлээр” гэснийг “асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллага нь” гэж өөрчилж, 12.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.6, 12.7 дахь хэсэг болгох:

12.6.Энэ хуулийн 12.3-г заасан систем хөгжүүлэлтийг гүйцэтгэх этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

хуулийн дагуу шалгаруулна.

12.7.Соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдол бүрийг бүртгэх, хянах системийн мэдээллийг бүрдүүлэх, хэрэглэх чиг үүргийг хамтын удирдлагын байгууллага, эсхүл энэ хуулийн 7.4-т заасан үндсэн чиглэл тус бүрийн мэргэжлийн нэгдсэн холбоо гүйцэтгэж болно. Холбогдох этгээдийг энэ хуулийн 12.4-т заасан шалгуурын дагуу сонгох, санхүүжүүлэх, хяналт тавих чиг үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	10
Бүгд:	37

73.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, мөн газрын Хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Ариунням, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн гэрээ, эрх зүйн мэргэжилтэн М.Уранбилэг, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, мөн захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 13 цаг 15 минутаас 13 цаг 26 минутад хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, Ч.Ундрэм, Ж.Чинбүрэн, Д.Сарангэрэл, Х.Баделхан, Г.Дамдинням, Г.Амартүвшин, Ж.Батжаргал, Т.Аубакир, Б.Энх-Амгалан, Б.Баттөмөр, М.Оюунчимэг, Ц.Мөнхцэцэг, Т.Доржханд нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Д.Сарангэрэл, Ж.Батжаргал, Т.Доржханд нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хотын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Нийслэлийн хотын албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон “Хот байгуулах

тухай”, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 8

Бүгд: 38

78.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаас ирүүлсэн Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай албан бичгийг танилцуулж, Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаарх мэдээллийг хойшлуулав./14:35/

Дөрөв.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, мөн газрын Хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Ариунням, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн гэрээ, эрх зүйн мэргэжилтэн М.Уранбилэг, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, мөн захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Г.Ганболд, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Н.Энхболд нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Монгол Улсын “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 17

Бүгд: 37

54.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Д.Баасандамба, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын референт Г.Нямсүрэн, Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 15 цаг 25 минутаас 15 цаг 30 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Энх-Амгалан нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 2 гишүүн 2024.04.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Г.Ганболд, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, С.Одонтуяа, Ш.Адьяа нар үг хэлэв.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 5 өдрийн завсарлага өгөв./16:01/

Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 14 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Жаргалсайхан, “Юзисан партнерс” хуулийн фирмийн зөвлөх хуульч Н.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын референт Г.Нямсүрэн, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Б.Баттөмөр, Т.Аубакир нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 16 цаг 24 минутаас 16 цаг 34 минутад хуралдааныг даргалав.

С.Одонтуяа: Байнгын хорооны саналаар Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 18
Бүгд: 37
51.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Одонтуяа: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ц.Сандаг-Очир, Х.Булгантуяа /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн нэрийн “, өөрчлөлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн 4 дүгээр зүйлд, доор дурдсан агуулгатай 4.1.5 дахь хэсэг” гэснийг “хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт” гэж, 4.1.5 дахь заалтын дугаарыг “4.1.6” гэж тус тус өөрчлөн, мөн заалтыг төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт:

4.1.6.чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус.

Тайлбар: “төрөл бүрийн ундаа, ус” гэдэгт үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар ашиглах байгалийн гаралтай өтгөрүүлсэн шүүс, нунтаг баяжмал хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 7 дахь заалт:

7	Чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус	1 литр
---	--	--------

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг:

6.9.Энэ хуулийн 4.1.6-д заасан чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл		Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/
--	--	--	--

Д/д		Биет нэгж	2027 он	2028 он	2029 он ба түүнээс хойш	
1	Чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус	100 мл-г агуулагдах чихэр, чихэр орлуулагч 0-5 гр	1 литр	0	0	0
		100 мл-г агуулагдах чихэр, чихэр орлуулагч 5 гр-с дээш	1 литр	500 төгрөг	525 төгрөг	550 төгрөг

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөн, мөн зүйлийн “2024 оны” гэснийг “2027 оны” гэж өөрчлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Баталсан Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:46/

Уг асуудлыг 16 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийн мэндчилгээ дэвшүүлж, үг хэлэв.

Мөн Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх болон Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хянан шалгах үүрэг бүхий Улсын Их Хурлын хянан шалгах түр хороодыг нээлттэй сонголт явуулах, үйл ажиллагаагаа идэвхжүүлж ажиллахыг үүрэг болгож, үг хэлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 9 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 40 минут үргэлжилж, 72 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
11 цаг 10 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлье.

Өөрсдөө алга байгаа учраас болилоо.

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

2 дугаарт, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрөөтэй 2 саналтай, 2 саналтай байна.

Ингээд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэх эсэх,

5 дугаарт, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал,

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх,

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх,

Ахмад настны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

8 дугаарт, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл. Төрийн байгууллагын үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига, хүнд суртлын бууруулах “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар Ерөнхий сайдын мэдээлэл сонсоно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу чуулганаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх, горимын санал гаргах бол үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Бөхчулууны Пүрэвдорж, Тогмидын Доржханд нараас тус тус албан бичгүүд ирүүлсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Өнөөдөр бол Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр. Бүх хэвлэлийн байгууллагад ажилладаг сэтгүүлч, сурвалжлагч бүх салбарт ажилладаг Та бүхэндээ АН-ын нэрийн өмнөөс Хэвлэлийн эрх чөлөөний баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Тэгээд үүнтэй зэрэгцүүлээд манай намын зүгээс энэ хэвлэлийн эрх чөлөөг хадгалах, хамгаалах талаар өнгөрсөн хугацаанд тийм сайн ажиллаагүйд бас уучлалт хүсье. Яагаад гэвэл өнгөрсөн 8 жилийн туршид манай хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтээр 80 байраар ухарсан. Өөрөөр хэлбэл хэвлэлийнхний эсрэг үйл ажиллагаа явуулдаг ийм төр засагтай болсныг дэлхий даяар хараат бус байгууллагууд үнэлж, энэ дүгнэлтийг гаргасан байгаа. Энэ бол Монгол ялангуяа энэ ардчиллаас ухарч байгаа томоохон зүйл болж байна. Хэвлэлийнхээ эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө алдана гэдэг бол энэ Монгол энэ ардчиллын диваажин гэдэг энэ нэрээсээ татгалзах ийм үндсэн шалтгаан болж байгаа.

Өнгөрсөн хугацаанд мэдээж АН-ынхан сөрөг хүчний үүргийг хангалттай сайн биелүүлж чадаагүй боловч яг энэ үүрэг дээр манай хэвлэлийнхэн, манай энэ чөлөөт сошиал талбар дээр үзэл бодлоо илэрхийлдэг тэр хүмүүс бидний өмнөөс сөрөг хүчин болж ажиллаж байсанд маш их талархаж байгаа.

Тийм ч учраас өнөөдөр сөрөг хүчин болсныхоо төлөө олон олон сэтгүүлч нар цагдаа, прокурор дээр мөрдөгдөж, яллах дүгнэлт авч яллагдагч болж, нийтдээ 30 орчим сэтгүүлч яллагдагч болж байгаад үнэхээр харамсаж байгаа. Энэ бол бидний хийх ёстой ажлыг тэр хүмүүс хийсний ял нь тэд нар дээр очиж байгаа л гэж би үзэж байгаа.

Тийм учраас энэ хэвлэлийн эрх чөлөөг дээдлэх талаар манай Монголчууд нэн шаардлагатай ажиллах ёстой. Бид нар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө алдах юм бол, хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө алдах юм бол, чөлөөт бизнес эрхлэх тэр эрх чөлөөгөө алдах юм бол манай Монгол орон дарангуйллын орон болж хувирна.

Тийм учраас энд Хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр энэ эрх баригч нар энэ хэвлэлийнхний эсрэг явуулж байгаа энэ харгис үйл ажиллагаагаа зөөллөх ёстой

гэж би үзэж байгаа. Тийм учраас энэ сэтгүүлч нар бол мэдээж дарга нарыг шүүмжилж таарна. Тэр дарга нар шүүмжилсэн тэр зүйлдээ бүгдийг нь аваачиж, тэр сэтгүүлч нарыг цагдаа, хууль хүчний байгууллагад өгч шийтгүүлж байгаа нь үнэхээр хариуцлагагүй байгаа.

Өнгөрсөн хугацаанд мэдээж би бас яг энэ бусдын нэр хүндэд халдах, түүгээр нь далимдуулж энэ үзэл бодлоо илэрхийлсэн хүмүүсийг торгодог, хорьдог энэ заалтын эсрэг хууль өргөн барьсан. Харамсалтай нь Их Хурал хэлэлцэхгүй байгаа.

Тэгээд та бүхэндээ дахиад сайн тэмцээрэй. Сайн цаг ирнэ ээ. Хэвлэлийн эрх чөлөө сайхан бий болсон тэр нийгэмд бид нар амьдрах болно гэдгээ хэлье.

Тэгээд ингээд эцэст нь хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Ашигт малтмалын тухай хуульд Энхтүвшин гишүүн бид 2 өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсан. Энэ хуулийг хэлэлцэх асуудлын 4 дүгээрт оруулж өгөөч ээ гэсэн хүсэлт гаргаж байна. Энэ талаар манай гишүүд дэмжиж бас яг микрофон дээр хэлэх боломжгүй байна. Тэгээд та бүхэнд бас хувийн шалтгаанаа хэлье гэж хүсэж байна. Тэгээд та бүхэн дэмжиж өгөөрэй. Баярлалаа, та бүхэндээ.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн. Улсын Их Хурлын гишүүн, ХҮН намын дарга.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр дэлхий дээр өнөөдөр 200 улс байна. 200 улсын тал нь ардчилсан улс байна, тал нь харин авторитор дэглэм рүү бол хэлбийж байгаа. Тэгээд үүнээс хамгаалдаг зүйл бол ардчилсан парламент байна. Үүнээс хамгаалдаг зүйл бол ардчилсан сонгууль байна. Үүнээс бас хамгаалдаг хамгийн хүчтэй зэвсэг бол энэ хэвлэл мэдээлэл, хэвлэн нийтлэх энэ эрх, эрх чөлөө энэ салбарынхан байна.

Тэгээд өнөөдөр Дэлхийн хэвлэлийн өдөр байна. Тэгээд ХҮН намын зүгээс, ХҮН намын даргын зүгээс өнөөдөр энэ өдөр Монголын ардчиллын төлөө үг хэлээ зоригтой дуугарч, өнөөдөр сөрөг хүчний үүргийг бас бодитой биелүүлж байгаа сэтгүүлчдэдээ талархал дэвшүүлж, энэ өдрийн мэндийг хүргэж байна.

Тэгэхээр ХҮН намын зүгээс бид бол сөрөг хүчнийхээ үүргийг нэр төртэйгөөр биелүүлсэн гэж үзэж байгаа. Тэгээд энэ хугацаандаа бид парламентын түвшинд бол маш олон шүгэл үлээсэн байдаг. Тухайлбал, Хөгжлийн банкны сонсгол хийе ээ, Түр хороо байгуулъя гэдэг санал санаачилгыг гаргаж явсан. Мөн АН-ын бас энд байгаа Ганбат гишүүнтэй бид нар анхлан бас энэ санаачилгаа яриад, үр дүнд нь бас Түр хороо байгуулагдсан байдаг.

Тэгээд Монгол Улсын нийт иргэдийнхээ өмнө гурван 7 хоног үндэсний телевизээрээ дамжуулж холбогдох бүх бодит мэдээллүүдийг бол түгээсэн байдаг. Үр дүнд нь Монголын түүхэнд болоогүй, урьд хожид үзэгдээгүй 80 ийм яллагдагч бүхий энэ асуудал шүүх, прокурорын байгууллага руу шилжсэн байдаг. Энэ бол бодитой үр дүн, 1.

2 дахь нь нүүрсний том хулгайн асуудал гарч ирсэн. Энэ асуудлын нийт хохирол нь 40 их наяд юм байна. Энэ 10 жилийн хугацаанд бид нар ийм хэмжээний орлогоо алдсан байна.

Дээрээс нь оптик гэрээний асуудал байна 18 их наядын асуудал байна. Үүнийг бол ил болгох нь зүйтэй гэдэг энэ санал санаачилгыг гаргаж, нийгэмдээ шүгэл үлээсэн парламентын түвшинд.

Мөн анхны ерөнхий хяналтын сонсголыг бол зохион байгуулсан. Мөн нэг жилийн дараа бол нүүрсний сонсгол хийгдсэн. Хэдийгээр хууль, шүүхийн байгууллагын түвшинд хэрэг замхарсан ч гэлээ гэсэн өнөөдөр үр дүнд нь биржээр нүүрс арилжаалагддаг болсон, үр дүнд нь

эдийн засгийн бодит өсөлтүүд бас бий болж байгаа нь энэ бол үр дүн юм.

Үүний хажуугаар маш том бас нийгэмд цочрол өгөхүйц ийм асуудал асуудлыг манай нийслэлийн ХҮН намын бүлэг бол гаргаж тавьсан. Энэ бол цавчаа ногоон буюу энэ ногоон автобусны хулгайн асуудал байгаа. Үүнтэй холбоотойгоор өнөөдөр Түр хороо байгуулагдаад явж байгаа.

Тэгээд би бол Түр хорооны гишүүнээр ажиллаж байгаа. Тэгээд энэ Түр хороо байгуулах асуудлыг бол бүх түвшиндээ ингээд дэмжээд явсанд талархаж байдаг. Манай АН-ын бүлэг бас үүнийг дэмжээд, санаачлаад, Ардын намын гишүүд, мөн Улсын Их Хурлын дарга бас дэмжээд Түр хороог хуралдуулахыг ингээд шийдвэрлээд явж байгаа нь бол сайн. Гэхдээ өнөөдөр Түр хороо маань ирц хүрэхгүй байна, Их Хурлын дарга аа. Ийм болохоороо Их Хурлын гишүүд ялангуяа ажлын хэсгүүдэд уриалга өгмөөр байна. Чиглэл өгмөөр байна. Өнөөдөр маш олон иргэд энэ ногоон автобусны хулгай юу болсон юм бэ. Энэ чинь ганцхан худалдан авалт байхгүй юу. Үүнтэй холбоотой асуудлыг мэдэх ийм хүлээлт бол байна. Сонгуулиас өмнө энэ асуудлыг мэдээллийг нь бодит мэдээлэл өгөх хэрэгтэй.

Өчигдөр хотын дарга байсан Сумъяабазар бас маш ноцтой асуудлуудыг хөндөж тавьж байна. Тийм болохоор ногоон автобустай холбоотой Түр хорооны нотлох баримтын хүрээнд хуралдах энэ хурлыг нээлттэйгээр, яаралтай зохион байгуулах шаардлагатай байгаа.

Тэгээд эцэст нь гээд хэлэхэд бид бол цаашид энэ хулгайн асуудлыг ил болгохоо зогсохгүй, сонгуулийн дараа бид нар хариуцлага тооцох асуудлыг ХҮН намын зүгээс бол тууштайгаар ажил хэрэг болгож явах болно. Шаардлагатай тохиолдолд дахин нүүрсний түр хорооны хурлыг хийнэ ... /минут дуусав/

Г.Занданиатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Энэ Түр хороод, ямар санал билээ, нөгөө ашигт малтмалын хууль уу.

Тогтохсүрэн дарга аа. Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна.

Ашигт малтмалын тухай хуулийг хэлэлцэх асуудлын дарааллын 3-д оруулъя гэсэн санал гаргасан. Санал хураалт явуулъя. Адьшаа гишүүн ээ.

Горимын санал дэмжигдсэнгүй. Дарааллаараа явлаа.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас санал хурааж шийдвэрлэсэн 2 дугаар саналын найруулга,

нэришлийг анхаарах чиглэл өгсний дагуу судалгааны грант гэж найрууллаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д зааснаар хуралдаан даргалагчаас нэг саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Байнгын хороо гүйцээн боловсруулж, санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Тус Байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын хуралдааны чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ундрам саналын томьёоллын эрдэм шинжилгээний байгууллага гэдэгт их сургуулиудад хамрагдаж байгаа эсэх талаар асуулт асууж, саналын томьёоллыг дэмжлээ. Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлтийг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага захиалах, судалгааны нэгдсэн чиглэлийн хүрээнд мэргэжлийн маягаар гүйцэтгүүлэхийг дэмжиж байгаагаа бас илэрхийллээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авч, саналыг хуулийн төсөлд тусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулга хуулийн төсөл болон зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг хийсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Өнгөрчихлөө.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрөөтэй нэг санал байгаа.

Асуулт байхгүй.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу хураалгах санал.

1. Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.10-т заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй.” Санал гаргасан Боловсрол, Соёл ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт.

Энэ дэмжсэн, дэмжээгүй л үг хэлж болно. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Ном дүрмийнхээ дагуу явж байна.

Тэмүүлэн гишүүн, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Энэ Шинжлэх ухаан, технологийн тухай хууль дээр анх өргөн баригдсан Засгийн газраас орж ирсэн, яамнаас орж ирсэн энэ хуулийнхаа төсөл дээр шинжлэх ухаантай холбоотой аливаа төсөл болоод суурь судалгаанууд бол суурь судалгаанд тендерийн хууль хамаарахгүй ээ гэдэг заалт байгаагүй. Анх өргөн баригдсандаа.

Тэгэхээр би Улсын Их Хурал дээр, Байнгын хороо дээр ажлын хэсгээс болоод энэ аливаа энэ шинжлэх ухаан, технологийн байгууллагатай хамааралтай тендерийн асуудлууд, тендерийн энэ үйл ажиллагаанд нь тендерийн хууль үйлчлэхгүй гэж ерөөсөө орж болохгүй. Би зарчмын хувьд.

Урьд нь Төсвийн тухай хууль дээр бас орж ирэх гэж үзсэн. Өмнө нь дахиад нэг орж ирж үзсэн. Энэ 3 дахь оролдлого нь болж байна. Тэгэхээр угаасаа бид нар энэ төсвийн сахилга бат болоод хяналт, хариуцлагыг сайжруулах үүднээс төрийн мөнгийг, ард түмний мөнгийг бид нар зөв зүйтэй, сахилга баттай, хариуцлагатай зарцуулах үүднээс Тендерийн хууль дээр энэ хатуу зохицуулалтыг хийж өгсөн юм. Аливаа төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд бүгд заавал ч үгүй Тендерийнхээ хуулиар явна.

Тэгэхээр энэ дээр би зарчмын хувьд үүнийг дэмжиж болохгүй заалтыг өчигдөр Улсын Их Хурлын даргад чиглэл өгсөн. Дахиад ажлын хэсэг Байнгын хороон дээрээсээ дахиж ингэж орж ирж байгаа нь би буруу байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр бид нар ямар нэг байдлаар энэ хүрээлэнгүүдийг тендерт оролцох боломжийг нь Тендерийн хуулиар хязгаарлаагүй шүү дээ, 1 дүгээрт.

2 дугаарт, ер нь зүгээр зарчмын хувьд хувийн хэвшлийн хийж гүйцэтгэх энэ ажлыг төрийн байгууллага хийх, өрсөлдөхгүй гэдэг бодлого явж байгаа чинь би зарчмын хувьд буруу гэж хараад байгаа юм. Тэгэхээр юу гэдэг юм дураараа

ингээд л юу гэдэг юм, 1 гэрээ байгуулаад л, судалгаа хийлгээд л тендер хамаарахгүйгээр гэрээ байгуулж ажил хийнэ гэдэг чинь нэг талдаа ингээд л мөнгө угаах ч юм уу, ямар ч хяналтгүй л явах асуудал болно шүү дээ. Тэгэхээр өрсөлдөх гэж байгаа бол өрсөлд. Гэхдээ зарчмын хувьд өрсөлдөх нь буруу гэж хараад байгаа юм.

Ер нь татвар төлөгчдийн болоод энэ аливаа энэ төсөв тендертэй холбоотой асуудал бол төсвийн мөнгө төгрөг дээр заавал ч үгүй байх ёстой асуудал. Ингэж байж бид нар цаашидаа үүнийг нь сахилга бат, хяналт, хариуцлагыг хийх ёстой.

Дээрээс нь бүх тендер худалдан авалттай холбоотой, төрийн мөнгөтэй холбоотой, төсөв хөрөнгө оруулалттай холбоотой асуудал бол заавал ч үгүй тендерийнхээ хуулиар явна. Энэ анхдагч хууль нь. Түүнээс салбарын хууль дээр зааж өгч, ингэж Тендерийн хууль хамаарахгүй гэж нэг хуулийгаа үгүйсгэдэг, анхдагч хуулиа үгүйсгэдэг ийм салбарын хууль байж болохгүй гэж харж байгаа юм.

Тэгэхээр би үүнийг бол зарчмын хувьд дэмжихгүй асуудал байна. Би Төсвийн байнгын хорооны даргын хувьд, эргээд энэ бид нарын том эргээд том хариуцлагатай холбоотой асуудал учраас ийм зүйл ерөөсөө байж болохгүй.

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Хариулчихъя. Энэ байна шүү дээ. Үүрэг чиглэл өгсний дагуу тодотгол хийгээд, Засгийн газар төрийн өмчийн хуулийн этгээд энэ хуулийн 3.1.10-д заасан судалгааны үндсэн чиглэл гэж байгаа юм. 3.1.10 гэдэг нь Инновацын тухай хуулийн 3.1.9 гэж байгаа юм. Тэгээд 1 ийм шинжлэх ухааны ололт гаргаад, түүнийгээ техникийн зүгшрүүлэлт хийхийн тулд туршилт зүгшрүүлэлтийн ажлыг тендер зарлаж хийхгүй шууд хийж болно л гэсэн санаа. Тэгэхгүй бол энэ эрдэмтэд чинь тэр туршилт зүгшрүүлэлтийн ажлаа дэлхий нийтийн

жишиг тийм байгаа. Лабораторийн туршилт зүгшрүүлэлт юу ч байлаа гэсэн энэ чинь юу зарлаад хийгээд байх тийм бололцоогүй гэсэн агуулгаар Инновацын хуулийн 3.1.9 нь бол судалгаа зүгшрүүлэлтийн ажлын туршилтыг хэлж байгаа.

Ийм агуулгаар учраас ер нь тэр, харин ч манай энэ шинжлэх ухааны энэ яг бодитой ажилд дэмжиж байгаа дэмжлэг байхгүй мөртөө энэ дээрээ ийм хүндрэл учруулаад яах вэ гэж байгаа юм. Ер нь технологийн туршилт, зүгшрүүлэлтийг л гэж лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болох технологийн баримтжуулалт хийх үйл ажиллагааг л хэлж байгаа юм. Тийм учраас энэ нарийн процесс, патенттай холбоотой ийм процессын юмыг нь бас эрдэмтэн судлаач.

Ингээд саналаа хураах уу? Ганбат гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Өөр юмгүй.

Д.Ганбат: Энэ Шинжлэх ухаан, технологийн хууль маш чухал хууль. Уул нь бол. Тэгээд бид нар нэлээн устай хууль баталж байна л, батлах гээд явуулах гээд ингээд л байж байх шиг байна гэж ойлгож байна.

Энэ инновац, шинжлэх ухаан, технологи гэдэг юм чинь бол дэлхий нийт аялал жуулчлалын 4 дүгээр хувьсгал гээд ингээд шал өөр болчхоод байна шүү дээ. Тэгээд бид нар бараг 19, 20 дугаар зууны үе дээрээ л явж байгаа юм шиг ийм л хуулиуд яриад, батлах гээд ингээд ярилцаад сууж байна. Үүний ганц цаад талын зорилго нь болохоор баахан нэг тендер шалгаруулж, хэдэн мөнгө төгрөг цохих гэсэн иймэрхүү л юм үүний цаана нуугдаад байна л даа.

Нөгөө талаар би бас нэгэнт үг хэлж байгаагийнх. Энэ хэвлэл мэдээллийн байгууллагын талаар бас хэлсэн нь дээр байх. Хэвлэлийн эрх чөлөөний өдөр хэдэн

барайсан хүмүүс ингээд л барайсан байдалтай угтаж байна. Уул нь хэвлэл бол 4 дэх засаглал гэж явдаг, ардчилсан улс оронд бол. Манайд ч тийм юм байхаа байчхаж л дээ. Энэ Ардын намын 8 жилд засаг барьж байгаа сүүлийн 3 жил ажиллаж байгаа энэ Засгийн газрын үед харж байхад бол эсвэл үгэнд ор, хэвлэл мэдээ, сэтгүүлчдийг бол, эсвэл шоронд ор гэдэг л болсон байна. Энэ юугаар илэрч байна вэ гэвэл энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний индексээр бол энэ 8 жилд бол 80 байраар ухарсан байна шүү дээ, даруй. Энэ дээр эрх баригчид сайн дүгнэлт хийх хэрэгтэй, бодох ёстой.

Энэ аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал гарчихсан. Үүний дагуу явж байна. Дунд сургуулиас хүүхдүүд код бичиж сурч байна. Ийм байхад бол энэ нэг хуулийг гаргаад хэдэн тендер цохих гэсэн ийм устай хууль болж байна шүү гэдгийг бас анхааруулъя.

Нөгөө талаар бол энэ залуу эрдэмтдээ дэмжиж байгаа юм юу байна вэ? Дэлхий нийтийн нэр хүндтэй сэтгүүлд өөрийнхөө эрдэм шинжилгээнийхээ материалыг хэвлүүлсэн энэ тэр гээд л олон зүйл заалт байдаг л даа. Түүнийг шагнах, урамшуулах, өөрийнхөө Монгол Улсдаа газрын хөрсөн дээр буусан тийм эрдэм шинжилгээний бүтээл туурвих, шинжлэх ухаан, технологи, инновац чинь өөрөө бид хаана ч байхгүй, бид нар нэг онцлог зүйлүүд байна шүү дээ. Бэлчээрийн МАА байна. Энэ нь бэлчээрийн МАА маань өнөөдөр яг ямар янзтай яаж явах ёстой юм тийм ээ. Тэр амьдрал дээр буусан тэр зүйлийг энэ шинжлэх ухааны байгууллага хиймээр байгаа байхгүй юу. Энэ талаар бол маш их хоцрогдож байна шүү дээ. 800, мянган жилийн өмнө МАА ямар байсан тэр чигээрээ байна.

Энэ манай бэлчээр чинь хэчнээн малын даацтай юм, малчин хүн яаж амьдрах ёстой юм. Өнөөдрийн инновацыг яаж ашиглах юм. Зарим газар чинь ерөөсөө хиймэл оюун ухаан энэ робот энэ тэр бий болоод энэ инновац чинь шал өөр байдалд оруулж байна шүү дээ. Олон

ажлын байр байна, байхгүй болж байна. Хиймэл мах хүртэл бий болгож байна.

Г.Занданшатар: Тийм, Ганбат гишүүн ээ, та бас олон жил парламентад суусан туршилагатай гишүүн. Энэ чинь хэлэлцэх эсэх дээр яригдах асуудлууд. Хэлэлцэх эсэх шийдээд анхны хэлэлцүүлэг хийгээд, анхны хэлэлцүүлэг дээр та бас асуултууд асуугаад, одоо эцсийн хэлэлцүүлэг дээр зөвхөн Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлттэй л холбогдуулж асууна шүү дээ.

Байнгын хорооны санал, дүгнэлт бол саяын энэ 31.4-тэй л холбоотой ганцхан дүгнэлт хэлсэн. Тэгээд яах вэ, Ганбат гишүүн цөөнх гэж хүндэтгээд хариулт Баттөмөр гишүүн товчхон хариулчих. 2 минут. Хариулах ч юу байх вэ дээ, санал хэлэх маягаар.

Б.Баттөмөр: Сая Их Хурлын дарга энэ зүгшрүүлэлттэй холбоотой асуудлыг маш тодорхой хэлчихсэн. Нэг эрдэмтэн нэг хэсэг эрдэмтэд лабораторид хийсэн туршилтаа зүгшрүүлэлт хийхийн тулд л нэг тендер зарладаг, хүн ордоггүй, ажил нь саатдаг ийм л юм. Энд их олон сая төгрөгийн юм ерөөсөө байхгүй, маш тодорхой хэлчихлээ. Энэ дээр. Энэ хувийн хэвшлийн энэ тэр юмыг энд булаасан юм ерөөсөө байхгүй шүү дээ. Харин Тендерийн хуулийнхаа тэр нүх сүвийг бид нар хаах ёстой юм байна лээ шүү гэдгийг хэлье.

Энэ хууль дөнгөж сая орж ирээд хийчихсэн юм биш. Энэ Их Хурлын даргын байнгын анхааралд би яг энэ асуудлаар би Их Хурлын даргатай 5 удаа уулзаж ярьж ингэсэн. Байнгын анхааралд нь явж байж энэ хууль ингэж гарч ирж байгаа юм шүү. Энэ дээр манай Засгийн газраас бол бас нэлээн их сайн санаануудыг оруулж ирсэн. Эрдэмтэд энэ дээр их санаанууд яасан. Ер нь Монголын ШУА бүх эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэд энд маш сайн оролцсон.

Дээрээс нь энэ асуудлыг бол би ажлын хэсгийн ахлагчийн хувьд Их

Хурлын даргад хэд хэдэн удаа танилцуулж, зөвлөгөөнүүдийг нь авсан. Энэ бол маш сайн хууль болж ингэж батлагдаж ирнэ ээ.

Бид энэ шинжлэх ухаан гэдэг юмаа л их сайн ярих ёстой юм байгаа юм. Энэ шинжлэх ухаан гэдэг юм чинь хөгжлийг түргэсгэдэг ийм л зүйл. Тийм учраас энэ хуулиар бас шинжлэх ухаандаа хуваарилах мөнгөний хэмжээ нь бол нэмэгдэж байгаа. Эрдэмтдийн хийж байгаа шинэ санаа энэ нээлт маань бол өөрөө мөнгө олох энэ эрх зүйн орчныг нь бүрдүүлж байгаа. Ийм их олон талын ач холбогдолтой маш сайн хууль өнөөдөр батлагдаж байна. Энэ хууль Монгол Улсын хөгжилд бол үнэхээр шийдвэрлэх ач холбогдолтой ийм хууль болно. Тэр сая Ганбат гишүүний асууж байгаа тэр залуу болон дунд бүх шатын эрдэмтэд бол энд тэд нарын ажлыг дэмжсэн тэр заалтууд нь бүгд орсон байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Одоо санал хураалт явуулна. Төслийн уншаад танилцуулчихсан. Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

Ганбат гишүүн, Адьшаа гишүүн суу. Санал хураалтыг битгий үймүүлээд бай.

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.10-т заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй.” Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт.

Гишүүд суугаарай. Адьшаа гишүүн ээ, Адьшаа гишүүн ээ суудалдаа суу. Дамдинням гишүүн. Санал хураалт.

Санал хураалт.

56,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлж байна.

Ер нь энэ манай энэ шинжлэх ухааны тогтолцоо чинь социализмын үеийнхээрээ ШУА-тай улс ОХУ, манай 2 л улс яг ийм бүтэц тогтолцоотой байсан. ОХУ өөрчилчихсэн. Шинжлэх ухааны чиг хандлага бүр дэлхий дээр куадрупл хеликс буюу дөрвөлжин зангилаа, хувийн хэвшлийн оролцоотой шал өөр болчихоод ингээд шинэчлэл реформ хийгдэж байна шүү дээ. Тэр хэдхэн сая төгрөгийн л асуудал байна.

11.39 цаг

Дараагийн асуудал.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна. Индэрт урьж байна.

Энэ хуулийг шуурхайлчихаад Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиа хэлэлцэцгээе.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас зарчмын зөрөөтэй саналын томъёоллын 8, 9 дүгээр саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах, тохиолдол бүрийг бүртгэх, хэрэглэх чиг үүргийг хэрэгжүүлэх, хамтын удирдлагын байгууллагад тавих шаардлагуудыг тодорхой болгож, систем хөгжүүлэлтийг гүйцэтгэх этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулахаар найруулж, томъёолон санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Тус Байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг системийг гүйцэтгэх этгээд нь Засгийн газрын эрхлэх асуудалд хамаарах нь оновчтой эсэх талаар асууж, хариулт авсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулга,

хуулийн төсөл болон зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооноос гарсан зарчмын зөрөөтэй 2 санал байгаа. 2 саналаар санал хураалт явуулъя.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслөөр гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн. Хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу гүйцээн боловсруулсан.

1. Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, /цаашид тохиолдол бүрт нийцүүлэн өөрчлөх/, 12.4 дэх хэсгийн “нөхцөл,” гэсний дараа “системийн мэдээллийг бүрдүүлэх этгээдэд тавих шалгуур,” гэж нэмж, 12.9 дэх хэсгийн “төрөөс” гэснийг болон 12.10 дахь хэсгийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай “12.8” дахь хэсэг нэмэх:

“12.8.Энэ хуулийн 12.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллага нь Оюуны өмчийн тухай хуулийн 17.2-т заасан объектын төрөл тус бүрийн зохиогчийн эрх эзэмшигчийн олонхыг нэгтгэсэн байна.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 67,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.3-12.6” гэснийг “12.3, 12.5, 12.7” гэж, “12.9 дэх хэсгийн “бүтээгдэхүүний зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн чиглэлээр” гэснийг “асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллага нь” гэж өөрчилж, 12.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.6, 12.7 дахь хэсэг болгох:

12.6.Энэ хуулийн 12.3-т заасан систем хөгжүүлэлтийг гүйцэтгэх этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулна.

12.7.Соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдол бүрийг бүртгэх, хянах системийн мэдээллийг бүрдүүлэх, хэрэглэх чиг үүргийг хамтын удирдлагын байгууллага, эсхүл энэ хуулийн 7.4-т заасан үндсэн чиглэл тус бүрийн мэргэжлийн нэгдсэн холбоо гүйцэтгэж болно. Холбогдох этгээдийг энэ хуулийн 12.4-т заасан шалгуурын дагуу сонгох, санхүүжүүлэх, хяналт тавих чиг үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Суугаарай гишүүд, санал хураалт.
Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 73 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар шилжүүлэхийн өмнө протоколд тэмдэглэх зорилгоор ажлын хэсгийг бас танилцуулах ёстой, энэ чинь.

Чинбатын Номин Соёлын сайд, Соёлын дэд сайд Пүрэвсүрэнгийн Баттөр, Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Цэрэндоржийн Чулуунбат, Ая зохиогч, продюсер, дуу бүтээгчдийн үндэсний төвийн гишүүн Дашийн Өлзий-Орших, В продакшны гүйцэтгэх захирал Доржсүрэнгийн Болд, Монгол анимэйшний холбооны гүйцэтгэх захирал Энхсайханы Тамир, М мюзик ХХК-ийн захирал Дашнямын Батмагнай, Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Готовцэрэнгийн Батхуяг, Соёлын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Содномжамцын Батцэцэг, Ганжуурын Төгсбаяр Өмгөөллийн Төгс энд Ко ХХК-ийн захирал.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг. Соёлын дэд сайд Пүрэвсүрэнгийн Баттөр гээд эхэнд танилцуулчихсан.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлж байна.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

11.46 цаг

Дараагийн хуульд орно.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг, суудалдаа сууцгаагаарай.

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм хүндэт нийслэлчүүд ээ, Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Манай Засгийн газар байгуулагдсан цагаасаа олон жил тулгамдсан суурь реформын асуудалд голлон анхаарлаа хандуулсаар ирлээ. Суурь асуудал хэрвээ шийдэгдэхгүй бол түүнээс улбаалсан нь зовлон хэзээ ч арилахгүй нь тодорхой билээ. Та бид хамтдаа цар тахлыг даван туулж, олон жил маргасан өргөн, нарийн царигийн маргааныг эцэслэн боомтын боомийг тайлж чадлаа.

Авлигын олон асуудлыг ил тод болгож, шүүхийн шатад шилжүүлж бас чадлаа. Хөгжлийн банкны бондыг өөрийн эх үүсвэрээр нь бүрэн төлүүлж, Эрдэнэт үйлдвэр, Хөтлийн цемент, Дархан төмөрлөгийн үйлдвэрийн хууль бус асуудлыг цэгцэлж, Оюутолгойн 2,3 тэрбум ам.долларын өрийг тэглэж, нүүрсний худалдааг биржээр нээлттэй арилжиж эхэлснээр далд эдийн засаг ил болж -4,6 хувьтай байсан эдийн засаг 7 хувийн өсөлтөд хүрсэн нь бүхэлдээ 10 гаруй функтээр өссөн үзүүлэлт юм.

Эдийн засаг 2 дахин тэлж, валютын нөөц 5 тэрбум ам.долларт хүрч нэг хүнд ноогдох ДНБ сүүлийн 2 жил дараалан 1000 ам.доллороор өсөж, өнөөдөр 5875 ам.долларт хүрсэн байна. Нэг үгээр хэлбэл эдийн засгийн нөхцөл байдал 2012 оны эдийн засгийн сэргэлтийн цаг хугацаатай ижил түвшинд ирж байна гэж ойлгож болно. Гол нь бид нар гаргасан алдаагаа дахин алдахгүйн тулд хамтдаа хичээх ёстой. Өнгөрсөн хугацааны алдааг засах гэж бүтэн 10 жил буюу нэг декэдийг бид нар зарцуулагддагийг өнгөрсөн цаг хугацааны сургамжаасаа суралцаж, ийм алдааг дахин давтахгүйг хичээх ёстой юм.

Авлигын эсрэг тэмцлийн үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдаж, эдийн засаг иргэн бүхэнд хүртээмжтэй болох суурь нөхцөл хэрэгжиж эхлээд байна. Баялгийн сангийн хуримтлалын санд төвлөрүүлэх энэ жилийн орлогыг ипотекийн зээлийн эх

үүсвэрт нэмэгдүүлснээр 10 гаруй жилийн дараа авахаар дараалалд байсан 10 гаруй мянган иргэдийн орон сууцын асуудал бүгд нь шийдвэрлэгдэж чадна гэдэг бол бидэнд ямар их хэмжээний боломж байсны энгийн нэг жишээ бол энэ юм.

И-Монголиа цахимжилт амжилттай хэрэгжиж, шилэн ажиллагааны хүрээнд төрийн үйлчилгээ гар утсанд шилжиж, аливаа ашиг сонирхлын асуудал хэн нэгнээс хамааралгүй ил тод болсоор байна. Нийгэм ч өөрөө авлигыг үл тэвчих, авлигыг үзэн ядах сэтгэл зүйтэй болон төлөвшлөө. Энэ нь өнгөрсөн цаг хугацааны тэмцлийн хамгийн чухал үр дүн юм.

Бид хүрсэн ёс зүйн өндөрлөгөөсөө доош унахгүйгээр харин цааш тэмүүлж чадвал авлигагүй нийгэм бүрэлдэн бий болох цаг хугацаа хол биш байна.

Дүр эсгэсэн хуурамч байдал өдрөөс өдөрт хүчгүйдэж, бодит прагматик шийдлийн мэтгэлцээн нийгэмд өрнөж эхэлдэг болсон байна.

Үндсэн хуулийн өөрчлөлтөөр парламентын 126 гишүүн бүхий сонгуулийн холимог тогтолцоонд шилжиж, хүйсийн тэгш байдлыг бүрдүүлэхэд томоохон алхмыг хийж, нийгмийн салбар төлөөлөл парламентад дуу хоолойгоо илэрхийлэх бодит боломж бас бүрдлээ. Дэлхий дахинд манай энэхүү дэвшилийг сайн загвар болон судалж байна. Бид сонгодог парламентын засаглалыг төлөвшүүлэхийн төлөө цаашидаа ч хичээх учиртай.

Монгол Улс Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлоготой болж, салангид 560 орчим бодлогын баримт бичгүүдийг бүгдийг нь нэгтгэж чадлаа. Энэ мөн л олон улсад үнэлэгдэж, улс орнуудын сайн туршилага болон судлагдаж байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал амилж, сонгуулийн тойрог анх удаа бүсчлэгдэн томорлоо. Тухайн үед биелэгдэшигүй мэт сонсогдож

байсан ч эргээд харахад ард нь гарч чадсан Шинэ сэргэлтийн бодлогын реформыг Засгийн газраас оруулж ирсэн бодлогыг дэмжсэн Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэндээ Ерөнхий сайдын хувьд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Давшгүй даваа хэмээн сонсогдоно. Хэрхэн давах вэ хэмээвээс хэрхэн давах хэмээн бүү сэтгэ, давъя хэмээвээс давна гэдэг өвгөдийн маань сайхан сургаал бий. Өнгөрсөн хугацааны олон зүйлүүд ч гэсэн тухайн үед сонсоход хялбар байгаагүй. Энэ удаа Монгол Улсын Засгийн газраас хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд 20 минутын хотын концепцыг хэрэгжүүлэх эрх зүйн цогц реформыг Улсын Их Хуралд ийнхүү өргөн барьж байна.

Энэхүү эрх зүйн реформд Хот, тосгоны эрх зүйн байдал, нутаг дэвсгэрийн нэгж, зарим шинэ хотуудын эрх зүйн орчин, Улсын Их Хурлаас гаргах тогтоолд санхүүгийн эх үүсвэрийн зарим тогтоол багтаж байгаа болно.

Бид бүхэн бүгдээрээ мэднэ. Монгол Улс нийслэл Улаанбаатар хотын засаг захиргааны бүтцэд 1960 оны 07 дугаар сарын 06-ны өдөр 4 районтойгоор өөрчлөлт хийж байсан. Түүнээс хойш 32 жилийн дараа 1992 оны 01 дүгээр сарын 13-нд шинэ Үндсэн хууль өөрчлөгдөж байх үед 9 дүүрэгтэйгээр өөрчлөн зохион байгуулагдаж байсан. Тэр цагаас хойш өнөөдөр мөн 32 жилийн хугацаа өнгөрчээ. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл нийслэл Улаанбаатар хотод эрс мөн цогц реформ хийх цаг хугацаа нь болсныг харуулж байгаа юм.

Нийслэл Улаанбаатар хот Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0,3 хувь ч нийт хүн амын 50 гаруй хувь нь төвлөрөн амьдарч байна. Нийслэлд ДНБ-ий 63 хувь үйлдвэрлэгдэж, худалдаа, үйлчилгээний 84 хувь, ААН-үүдийн 70 хувь, их, дээд сургуулиудын 90 хувь, бүртгэлтэй автомашины 84 хувь нь зөвхөн нийслэлд байна.

Нийслэлийн 35206 га эдэлбэр газрын ердөө 700 га газар буюу Их тойрууд төрийн 140 байгууллага, Төрийн ордны байрлаж байгаа бидний эргэн тойрны Бага тойруу буюу 86-хан га талбайд Монгол Улсын хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын эрх мэдэл бүхэлдээ төвлөрч байна.

Засаглал бүхэн харилцан хяналт тэнцэлтэй байхын тулд эрх мэдлийн байршил салангид байх учиртай нь олон улсын нийтлэг жишиг байдаг билээ. Ингэж байж сайн засаглал бүрдэх, эрх зүйт төр төлөвших суурь зарчим хангагдахаас гадна аюулгүй байдал, мөн хэт төвлөрлийн асуудал бүрэн шийдвэрлэгдэнэ.

Товчхондоо Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд нийслэлийн хэт түгжрэл бол эрх мэдлийн хэт төвлөрөл гэдэг улс төрийн дүгнэлт хийж байна. Нийслэлд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд асуудлын илэрч буй шинж тэмдэгт төвлөрөх бус харин асуудлыг үүсгэгч шалтгаанд төвлөрөх нь хамгийн чухал байна.

Нийслэлийн асуудал шийдэгдэхгүйгээр улсын асуудал шийдэгдэх боломжгүй. 11-11 төвд ирж байгаа нийт гомдлын 70 гаруй хувь зөвхөн нийслэлтэй холбоотой байсаар байна. Нийслэлийн асуудал бол Улсын Их Хурал, Засгийн газрын асуудал биш гэж галаас зугтсаар байвал та бид асуудлаа бүр л илүү хуримтлуулсаар байх болно. Нийслэл Улаанбаатар хот асуудлаа бие даан шийдвэрлэх эрх мэдэл ч, эрх зүйн боломж ч, төсөв ч байхгүй байсныг бид хүлээн зөвшөөрөх ёстой.

Нийслэлийг харах ойлголтоо өөрчлөхгүйгээр бид асуудлыг нь бүтэн шийдэж бас чадахгүй. Нийслэлчүүд нийслэлийн маань иргэдийн маань хувьд ч асуудлыг харж шүүмжлэхээс илүүтэйгээр асуудлын уг үндэс дээр нийгмийн мэтгэлцээн өрнүүлэх нь нэн чухал юм.

4 дэх засаглал болсон хэвлэл, мэдээллийн байгууллагууд ч үүн дээр онцгой анхаарал хандуулахыг хүсье. Мөн өнөөдөр хэвлэл, мэдээллийнхэндээ Олон улсын хэвлэлийн эрх чөлөөний өдрийн мэндийг дэвшүүлье.

Нутаг дэвсгэрийнхээ 0,3-хан хувийг хот, бусдыг нь хөдөө гэж нэрлэхээр нийслэлийн иргэн байх гэсэн энгийн сэтгэл зүйн өрсөлдөөн ч иргэдийн дунд байсаар ирсэн нь нууц биш юм. Тиймээс бид ойлголт, хандлага, оюуны түгжрэлээ тайлж байж, нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийн асуудлыг тайлж чадна.

Хүндэт нийслэлчүүд ээ, Улс төрийн намын эрхэм удирдлагууд аа, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Засгийн газрын өнөөдрийн өргөн барьж буй 20 минутын хот эрх зүйн цогц реформ хэлэлцэн батлагдсанаар дараах асуудлууд шийдвэрлэгдэх болно.

1 дүгээрт, энэ асуудал шийдэгдсэнээр нийслэл Улаанбаатар хотоос гадна Хөшигийн хөндий, Шинэ Зуунмод хот, Шинэ Хархорин, Дархан, Эрдэнэт, Багануур, Налайхыг нийслэл Улаанбаатар хоттой адилхан улсын зэрэглэлтэй хот болон хөгжүүлэх боломжийг гаргаж байгаа юм. Мөн цаашид бүсийн төвүүд түлхүү хөгжиж байгаа томоохон боомтууд улсын зэрэглэлтэй хот болох эрх зүйн боломжийг өнөөдрийн өргөн барьж байгаа хуулиар нээж байгаа гэж ойлгож болно.

2 дугаарт, энэхүү хууль батлагдсанаар нийслэл Улаанбаатар хотыг 14 хотод хуваан бие даан хөгжүүлнэ. Энэ хотуудад Хан-Уул хот, Яармаг хот, Буянт-Ухаа хот, Сонгинохайрхан хот, Толгойт хот, Баянхошуу хот, Өнөр хот, Баянгол хот, Чингэлтэй хот, Сэлбэ хот, Сүхбаатар хот, Дарь-Эх хот, Баянзүрх хот, Амгалан хот зэрэг болно. Эдгээр хотуудад иргэн бүр төрийн үйлчилгээг 20 минутын дотор авахаар их өгөгдөлд тулгуурласан цахим

төлөвлөлт бүхий нэгдсэн стандартыг тогтоох юм. Нэг үгээр хэлбэл цаашидаа аливаа асуудлыг зөвхөн цахим өгөгдөлд тулгуурласан байдлаар 20 минутын стандартын дагуу төсөв тавигддаг болно гэсэн үг юм.

3 дугаарт, нийслэлийн 204 хороог 42 нэгж болгон, орон нутгийн статустай хот болгон томсгох. Ингэснээр манай хороодын удирдлагууд шууд төсөв захиран зарцуулах эрх мэдэлтэй болно гэсэн үг юм. Нэг үгээр хэлбэл өнөөдөр нийслэлд байгаа зарим эрх мэдлүүд зөвхөн дамжуулагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тийм учраас дамжуулагчийн үүргийг эцсийн шийдвэр гаргадаг нэгж болгох эрх зүйн реформ энэ хуулиар орж ирж байна гэсэн үг. Эрүүл мэнд, боловсрол, онцгой, цагдаа, нийтийн тээвэр, нийгмийн хөгжил, соёлын цогц үйлчилгээ, үүн дотроо явган замын стандарт, дугуйн замын стандарт, усан бассейн, фитнес клубээс эхлээд амьдралын чанарын бүхий л үйлчилгээнд 20 минутын дотор заавал очих байдлаар шинэчлэн зохион байгуулах. Энэ шаардлагатай хөрөнгийг улсын төсвөөс үе шаттай шийдвэрлэх, мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд энэ асуудалд хөрөнгө оруулалт хийсэн ААН-үүдийг дэмжих эрх зүйн цогц реформ мөн энэ хуулийн хүрээнд тусгагдсан байгаа юм.

4 дүгээрт, Бага тойруугийн төвлөрсөн эрх мэдлийг задлахын тулд Засгийн газрын харьяа байгууллагуудыг Хөшигийн хөндийд шилжүүлэн байрлахаар мөн оруулж ирж байна. Бага тойруугаас Хөшигийн хөндийг дүүжин гүүр болон туннелээр шууд холбож, 20 минутын дотор Төрийн ордны Чингисийн хөшөөнөөс Чингис хаан нисэх онгоцны буудалд шууд очдог болох гүүрэн байгууламжийг хийх хөрөнгө оруулалтын асуудлыг мөн оруулж ирж байна.

Энэхүү холбоос гүүрийг байгуулснаар хотын төв онгоцны

буудалтайгаа шууд холбогдох боломжтой болно. Энэхүү холбоос гүүрийг gov.Монголиа буюу Өөдлөн тэмүүлэх Монгол гэж нэрлэхээр Засгийн газрын шийдвэр гарсан. Энэ хуулийн хүрээнд энэхүү гүүрэн байгууламж Засгийн газрын баталгаа гаргах болон эрх зүйн бусад асуудлуудыг хамт тусгасан болно.

5 дугаарт, энэхүү хууль өргөн баригдаж батлагдсанаар аймгийн төвүүдийг орон нутгийн чанартай хот болгон өөрчлөх, томоохон суурин газруудыг хотын статустай бие даан хөгжүүлэх асуудал мөн энэ хүрээнд тусгагдсан.

Энэхүү хууль батлагдсанаар дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх хүрээнд хөрөнгө оруулалт, татварын таатай орчин бий болно. Энэхүү хууль батлагдсанаар тээвэр логистикийн нэгдсэн төвийг байгуулж хөгжүүлснээр орон нутаг, бүс, олон улсын логистик болон дэд бүтцүүд сайжирна. Энэхүү хууль батлагдсанаар орон сууцжуулах төсөл хэрэгжүүлэх нийслэлээс иргэд шилжин суурьших, төрийн байгууллага, их, дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны байгууллагуудыг нүүлгэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого болон Шинэ сэргэлтийн бодлогын хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд Засгийн газраас өргөн барьж буй шинэ хотууд байгуулах 20 минутын хотын стандартад шилжих эрх зүйн цогц реформыг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданиатар: Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд баярлалаа.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга

Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлаас 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгон, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж өөрчлөн найруулсны дагуу цаашид өнөөгийн хот, тосгоны эрх зүйн байдалтай холбоотой харилцааг зохицуулж буй хуулийг шинэчлэн батлах үндэслэл бүрдсэн гэж үзэж, хууль санаачлагч Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна.

Өнөөдрийн байдлаар манай улсад 1 саяас дээш хүн амтай хот 1 Улаанбаатар, 70 мянгаас 110 мянган хүн амтай хот 2 Дархан, Эрдэнэт, 20 мянгаас 70 мянган хүн амтай хот 16, 10 мянгаас 20 мянган хүн амтай хот 8, нийт 10 мянгаас дээш хүн амтай төвлөрсөн хот суурин газар 27 болж, хотжилтын түвшин 70,7 хувьд хүрээд байна.

Хот, суурин газрын хүн амын механик өсөлт, эдийн засаг, нийгмийн хөгжил, бусад холбогдох аж үйлдвэрийн үйл ажиллагаа нэмэгдсэнээр нутаг

дэвсгэр, хүн амын нутагишилт, суурьшлын тогтолцоонд томоохон өөрчлөлт орж, хотжилтын түвшин эрчимтэй өсөж, хотын асуудлыг тухайлан зохицуулах, иргэдэд хотын хөгжлөө хүртээмжтэй болгох шаардлага бий болсон гэж үзжээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах нийтлэг журам, хотын зэрэглэл тогтоох шалгуур, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон ААН байгууллага, оршин суугчдын харилцах харилцааг зохицуулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын зэрэглэлтэй болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн хот, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээр нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харилцаанд оролцох эрх зүйн үндэс бүрдэж, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт хэрэгжиж, хууль хоорондын уялдаа хангагдаж, хэрэгжилтийг нэг мөр хангах нөхцөл бүрдэнэ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар суурин газруудыг улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгон болгон байгуулах асуудлыг дэс дараалалтай хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Улсын зэрэглэлтэй 5 Дархан, Эрдэнэт, Шинэ Хархорин, Багануур, Налайх хотыг, орон нутгийн зэрэглэлтэй 44 хотыг нийслэлд 14, аймгуудад 30, аймгийн төв 19 хот, Замын-Үүд, Тосонцэнгэл, Ханбогд, Цогтцэций, Хөтөл, Мандал, Байтаг богд, Хатгал, Бор-Өндөр, Бэрх хот, мөн дагуул 3 Агро сити, Багахангай, Шарын гол хотыг байгуулж бие даан хөгжүүлнэ.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас тодорхойлсон бүсчилсэн хөгжлийн болон Шинэ сэргэлтийн

бодлого хэрэгжиж, хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзжээ.

Дээрх хуулийн төсөл иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын Ди парламент.мн цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн хуулийн төсөл Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцэж байгаа эсэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг хотуудад шилжүүлэхтэй холбогдсон харилцааг хэрхэн шийдвэрлэсэн, Хархорум хотын төлөвлөлт орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн байдлыг хэрхэн тодорхойлсон талаар, хотуудын эдэлбэр газрыг хэрхэн тогтоох, хуулийн хэрэгжих хугацааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг хот байгуулах дэд бүтцийг хэрхэн шийдвэрлэх, хуулийн төслийг боловсруулахад БХБЯ-ны оролцоо саналыг тусгасан эсэх талаар, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгасан улсын болон орон нутгийн зэрэглэлд 52 хотыг хэрхэн байгуулах талаар, хот байгуулах олон улсын туршилагыг судалсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Доржханд хотуудыг байгуулахдаа газар нутаг эдийн засгийн үр өгөөжийг харгалзан үзсэн эсэх, хууль, тогтоолын төслүүдийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганболд хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэрэгжих хугацаа, хотын захирагч зөвлөлийн сонгох асуудлыг хэрхэн зохицуулсан, хотын төсөв, санхүүжилтийг хэрхэн бүрдүүлэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх

олонх буюу 72,7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найрлагын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, худалдаа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо, толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хотын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга, нийслэлийн хотын албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон “Хот байгуулах тухай”, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хишгээгийн Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан I дүгээр орлогч Пүрэвийн Сайнзориг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн

газрын шинжээч Бат-Эрдэмийн Төрбат, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цогтын Баярбат, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Дагвадоржийн Билэгсайхан, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хот байгуулалтын газрын Хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Энх-Амгалангийн Ариунням, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Дорждэрэмийн Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга Дугардоржийн Амгалан, Жуковын Алдаржавхлан Хан-Уул дүүргийн Засаг дарга, Мөнхөөгийн Батбаяр Хөшигтийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Баатарын Гүнболд Хөшигтийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны ерөнхий менежер, Цогтгэрэлийн Батгэрэл Нийслэлийн захирагчийн ажлын албаны төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Мөнхбаярын Уранбилэг Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн гэрээ, эрх зүйн мэргэжилтэн, Дэмбэрэлийн Баялагцэнгэл Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, Сумъяасүрэнгийн Энхжаргал Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж, асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлье.

Пүрэвдорж гишүүн явахаа больчихсон юм уу. Хүрэлбаатарын Булгантуяа. Сайд нар асуулт асуухгүй. Энэ олон хүн байгаа учраас ерөөсөө хуулиа явуулахын тулд. Ийм горимын саналаар санал гаргаад гишүүд гараа

өргөчих. Тэгээд дэмжүүлье. Сайд нар асуулт асуухгүйгээр тохирлоо.

Ширнэнбандын Адьшаа гишүүн. Сайд нар асуулт асуухгүй.

Ш.Адьшаа: Их Хурлын гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Засгийн газраас энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хуралд оруулж, өнөөдөр хэлэлцэж байна.

Оюун-Эрдэнийн Засгийн газар сүүлийн жилүүдэд энэ авлига, хээл хахууль түүнчлэн энэ байгалийн баялгийн асуудлаар бас зарчмын ард түмний эрх ашгийн төлөө олон сайн санаачилгуудыг гаргаж ажиллаж байсан гэдгийг үгүйсгэхгүй. Гэхдээ өнөөдөр сүүлийн энэ сар гаруй хугацаанд яаралтай горимоор олон хуулийг Засгийн газраас орж ирж хэлэлцүүлж байна. Бид ойлгож байна. Сонгууль болох гэж байна. Ард түмэнд бас оноо авах асуудал байна. Гэхдээ ингэж Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдсөн ийм хуулийг бид өнөөдөр оруулж ирж хэлэлцүүлмээргүй байна.

Их Хурлын гишүүдээ жоохон чимээгүй болчихмоор байна, Тогтохсүрэн дарга аа.

Энэ Үндсэн хуулийн 57 дугаар зүйл зүйл гэж байгаа. Энэ 57 дугаар зүйл дээр нийслэл дүүргүүдэд хуваагдана гэж энэ Үндсэн хуульд чинь заагаад өгчихсөн байна. Гэтэл өнөөдөр Улсын Их Хурал, Засгийн газар өнөөдөр Үндсэн хуульд заасан энэ асуудлын тухай асуудлыг энэ Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх нь зөв юм уу? Ер нь тэгээд энэ асуудлыг зөвхөн хот биш Монгол Улсын засаг захиргааны нэгжийнхээ асуудлыг өнөөдөр авч хэлэлцмээр байна. Өнөөдөр хөдөө, орон нутагт сурах хүүхэдгүй сургуулиуд байна. Эмчлэх хүнгүй эмнэлгүүд байна. Энэ сумуудаа нэгтгэх ийм асуудлыг оруулж ирж болдоггүй юм уу. Зөвхөн өнөөдөр хот гэдэг ийм нэрийдлийн доор

өнөөдөр шинэ дарга, шинэ бүтэц бий болгох ийм асуудал орж ирж байна л гэж ойлгож байгаа. Хархорин хотыг өнөөдөр хот болгохыг зөвшөөрнө. Гэтэл дүүргүүд гэдэг юмыг чинь хот болгоно гэдэг энэ асуудал чинь энэ Үндсэн хуультайгаа зөрчилдөж байгаа энэ асуудлыг яах вэ гэдэг энд нэг хариулт авмаар байна. Хариулт авмаар байна.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайдад асуултад хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Хотын асуудлыг Улсын Их Хурал ингээд цогц байдлаар ерөөсөө хэлэлцэж байгаагүй юм байна лээ шүү. Хотын асуудлыг. Тэгээд Улсын Их Хурал болохоор яах вэ, энэ нийслэлийн асуудал гээд ингээд орхичихдог. Засгийн газар нь болохоор бас яах вэ, энэ нийслэлийн асуудал гээд. Ингээд нийслэлд шийдэх эрхийг нь ерөөсөө өгдөггүй. Тэгээд парламент дээр болохоор орон нутгийн гишүүд нь дандаа олонх байдаг.

Ингээд төсвөө болохоор орон нутагтаа илүү их ингээд тавиад яваад байдаг. Ийм байдалтайгаар Улаанбаатар хот явсаар байгаад өнөөдөр ингээд шийдэл хийх мөнгө ч байхгүй, шийдлээ гаргах эрх мэдэл ч байхгүй. Тэгээд 1 ийм байдалтай л ингээд болчихоод байна л даа. Одоо яг ийм байдлаар цогц реформ хийхгүйгээр цаашаа явбал Адьшаа гишүүн ээ, энэ Бага тойрууд байгаа 86 га дотор байгаа эрх мэдэл тэсэрнэ ээ, энэ дийлдэхгүй. Өнөөдөр 86 га дотор шүүх, хууль тогтоох, гүйцэтгэх байгууллага түүний харьяа гол байгууллагууд бүгд 86 га дунд байна. Үүнийг бид задлахгүйгээр хотын түгжрэлийн асуудлыг шийдвэрлэнэ гэж байхгүй.

Тэгэхээр би бас парламентын гишүүддээ уриалж байна. Одоо сонгууль гээд нэг ингэж юмыг харж яримааргүй байгаа юм. Сонгууль бодсон бол ийм эрсдэлтэй галтай юмыг оруулж ирж яах юм, ямар өөртөө гай тарих гэж байгаа

биш. Тэгээд л ингээд үүгээр энэ удаа шийдэхгүй. Тэгээд дараа нь орон нутгийн сонгууль гээд шийдэхгүй. Тэгээд он гараад дараагийн сонгууль гээд шийдэхгүй. Ингэж бие биеэ хуурч явсаар байтал энэ асуудлууд чинь хуралдаад байна, эрхэм парламентын гишүүд ээ.

Тийм учраас хотын асуудлыг цогц байдлаар шийдэх дээр битгий бойкот хийгээч ээ, битгий зөвхөн, орон нутгаа урдаа тавиач ээ. Та ч бас хотод амьдарч байгаа хүн.

Тэгэхээр энэ дээр ингээд бойкот хийхгүй сонгууль гэж жижиг харахгүй. Том зургаар нь хараад энэ хотын хуралдсан асуудал дээр нь цогц реформ хийгээд өгчих хэрэгтэй.

Засгийн газрыг аваад Хөшигийн хөндий рүү би нүүе ээ гэж байгаа юм. Тэгэхгүй их, дээд сургуулиуд гар аа, бид үлдье ээ гээд байхаар хэн ч дагаж нүүхгүй. Тэр хүртэл Бага тойруугаас гүүр бариад шууд туннелээр цаашаа гарах ийм реформ хийе гэж байгаа юм. Энэ дээр бидний хувьд нэгдмэл байх хэрэгтэй. Яг сая Үндсэн хууль дээр нэгдмэл байсан шиг, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр бид нар нэгдмэл байсан шиг, хамтдаа ярилцаад хийвэл 1986 онд гарсан ТЭЗҮ юм байна лээ. Түүнээс хойш ерөөсөө үүнийг хийгээгүй. Яагаад гэхээр тэгээд л нэг ийм улс төржсөн. Яагаад гэхээр нэг ийм өдөр тутмын нөгөө нэг сонгууль гээд юмаа урд талдаа гаргачихсан.

Тэгээд одоо тэгээд шийдэлгүй хаачхав. Тэгэхээрээ суурь асуудлуудаа шийдчихье. Суурь асуудлууд дунд бусад асуудлууд дагаад тэр хот нь өөрсдөө шийднэ биз дээ. Энэ агуулгаараа парламентын гишүүн бас Хууль зүйн сайдаар ажиллаж байсан хүнийг хот руу тавьсан.

Тэгэхээр энэ хүрээндээ хэдүүлээ тэгээд олон жил яриад явсан. Одоо тэгээд шийдчихье л дээ. Болхгүй гэдэг зүйл зөндөө л сонсож явлаа. Одоо болгох талаас нь харчихъя. Эсвэл тэгвэл өөр

ямар хувилбар байгаа юм бэ гэдэг Б хувилбараа танилцуул л даа. Б хувилбар байхгүй байж А хувилбар болохгүй гэж явсаар байтал чинь энэ хот чинь баларлаа.

Тэгэхээр Улсын Их Хурал, Засгийн газар хотоо дэмжсэн шиг дэмжээд, хотын тусдаа асуудал гэж харахгүйгээр бүгдээрээ яг төвлөрөөд, асуудлуудыг нь шийдээд өгчихье. Тэгээд манай Адьшаа гишүүн ухаантай хүн асуудлыг том зургаар нь харж чадах байлгүй дээ гэдэгт бол итгэж байгаа шүү.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн 1 минут тодруулж асууна.

Ш.Адьшаа: Ойлгож байгаа. Ер нь зовлон их байгаа. Монгол Улсын зовлонгийн нэг бол Улаанбаатар хот гэдэгт гэдгийг ойлгож байгаа. Тэгэхээр энэ энэ сумуудын асуудал гэж байгаа. Монгол Улс чинь засаг захиргааны нэгжийн хувьд 370-аад сум байдаг тухай байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хөдөө, орон нутаг чинь хүүхэд сурах сургуультай хэрнээ суух сурах хүүхэд байхгүй байна. Эмнэлэгтээ байгаа хэр нь эмчлүүлэх өвчтөн байхгүй байна. Тэгэхээр энэ сумуудаа нэгтгэх, энэ төсвийн үрэн таран болсон энэ том нүсэр бүтэцтэй үүнийг хамт оруулж ирэх ийм боломж байсан уу? Энэ хотын зовлонг ойлгож байна. Ерөнхий сайд энэ шийдлээ нэгэнт гаргаад явна биз дээ. Одоо надтай, надгүй. Тэгэхдээ энэ ... /минут дуусав/

Г.Занданшатар: Аймгийн төвүүд бас хот болж байгаа шүү дээ, аймаг, сум чинь бас.

Хишгээгийн Нямбаатар сайд 1 минут тодруулж хариулъя.

Х.Нямбаатар: Их Хурлын эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Би сая Ерөнхий сайд үндсэндээ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, түүнийг

дагасан 34 хуулийн үндсэн агуулга, ач холбогдлын тухай сая Их Хурлын гишүүдэд хэллээ.

Би энэ дээр нэмээд нэг 2 зүйлийг хэлье. 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улс хот, суурин газрынхаа эрх зүйн байдлыг бүхэлд нь шийдэж чадалгүй энэ 30 жилийг ардаа үдсэн. Би маш товчхоноор ойлгуулж хэлэхэд намайг томилогдохоос өмнөх бүх үеийн Нийслэлийн Засаг даргын томилгоо хууль бус байсан. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар хотын захирагчийг ард иргэд нь шууд сонгох хуультай. Гэтэл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн даргыг дагуулж хотын даргыг томилдог ийм томилгоотой өнгөрсөн 32, 3 жилийг бид нар ардаа үдэж байгаа юм.

2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан ... /минут дуусав/

Г.Занданшатар: Чинбатын Ундрам гишүүн.

Ч.Ундрам: Энэ хуулийг бол дэмжиж байгаа юм. Ер нь ийм хотын асуудлыг, өнөөдрийн бий болсон бүх асуудлыг бас шийдэхэд нэлээн том хувь нэмэртэй ийм засаглалын том цогц реформ гэж харж байгаа. Тэгээд Дархан хот маань бас улсын чанартай хот болж байна. Зуунмод хот маань улсын чанартай хот болж байна. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот, Мандал хот, Хөтөл хот гээд. Ингээд орон нутгийн чанартай 3 хот болж байна. Иргэд нь хотынхоо, орон нутгийн чанартай хотынхоо даргыг өөрсдөө сонгоод ингээд явах нь зөв гэж бодож байна.

Энэ хууль дээр харин энэ тосгодын асуудал дээр яалт ч үгүй надад хэлэх зүйл асуух асуулт байна. Сэлэнгэ аймаг бол хамгийн олон тосгонтой, 6 тосгонтой. Үүний дараа Хэнтий аймаг 5 тосгонтой байдаг. Нямбаатар сайд өөрөө сайн мэдэж байгаа тийм ээ. Тэгээд энэ тосгод маань зарим аймгийн сумдаас олон хүн амтай. Тэгээд яг нөгөө сумынхаа төвөөс

алслагдчихсан ийм тосгод олон байдаг. 80 км, 100 хэдэн километрийн зайд, замгүй. Тэгээд төрийн үйлчилгээгээ нөгөө багийн статустай байдаг болохоор төрийн үйлчилгээгээ заавал тэр хол очиж, сумын төв дээр очиж шийдүүлдэг. Тэгээд энэ үнэхээр их хүнд суртал үүсгэдэг.

Энэ хууль дээр би бас нэлээн хэлэлцүүлгүүд явсан учраас тосгоны Захирагч нар маш их зовлон, жаргалаа та бүхэнд хэлэлцүүлгийн шатад хэлсэн гэж байна лээ. Гэтэл тэр зовлон жаргалтай холбоотой нэг ч асуудлыг энэ дээр тусгаагүй байна. Энэ хуулийг харахаар нэг 8 чиг үүрэг яг л нөгөө багийн Засаг даргын чиг үүргүүд энэ дээр байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тосгодоо бид нар сумын статустай болгоод иргэдэд үйлчилгээг нь ойртуулмаар байна. Энэ дээр анхаарч өгөөч ээ гэж хүсмээр байна, Нямбаатар сайд аа.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд, Нийслэлийн Засаг дарга.

Х.Нямбаатар: Ундрам гишүүний асуултад хариулъя. Яах вэ, ер нь бид нар энэ хуулийн энэ 30 гаруй хуулийн агуулгыг бүхэлдээ нэг зүйлээр бид нар ойлгох хэрэгтэй. Та сая үгэндээ хэллээ. Сэлэнгэ аймаг хамгийн олон тосгодтой гэж байгаа. Өөрөөр хэлбэл Сэлэнгэ аймаг хамгийн олон суурин ийм хот, тосгоны зохион байгуулалтаар хөгжиж ирсэн. Харамсалтай нь бид нар хот, тосгодод таны яг хэлж байгаачлан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг шилжүүлж чадаагүйн улмаас хот, тосгод нь хот, тосгодын байдлаараа хөгжиж чадаагүй. Суурин газарт нэн шаардлагатай ариутгах татуурга, халаалт, дулаан, цэвэрлэх байгууламж, цаашилаад хог боловсруулах үйлдвэр эдгээр ерөөсөө огт шийдэгдэж ирээгүй нь бид нар өнгөрсөн 30 гаран жилийн хугацаанд хот, тосгодод засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг шилжүүлж 1 дүгээрт, чадаагүй.

2 дугаарт, хот, тосгод, суурин газарт байх эдийн засгийн хөшүүргүүдийг

бид нар бий болгож чадаагүй нь бид нарын энэ суурин газрын хөгжилд тааруу, нэг төвт хот руу шилжих том үндэслэл болсон.

Таны хэлж байгаа асуудлыг энэ хуулийн төсөл дээр бид нар ингэж бичиж байгаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хот, тосгодод гэрээний үндсэн дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг буюу саяын таны хэлж байгаа сумдын чиг үүрэг, тэдгээрт байдаг төрийн үйлчилгээний чиг үүргүүдийг хамтад нь шилжүүлэх энэ боломжийг нээж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл, тэр хот, тосгон өөр өөрийнхөө онцлогоос шалтгаалаад зарим нь өөр дээрээ тухайн сумынхаа төрийн үйлчилгээний бүх чиг үүргүүдийг шилжүүлж авч болно л гэсэн ийм агуулгаар орж ирж байгаа. Дагаж байгаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд нь.

Г.Занданшатар: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотой хэдэн зүйл хэлье гэж бодож байгаа юм.

Ер нь манай энэ отгон парламент бид бол бас Монгол Улсын хөгжлийн түгжээ болж байгаа хуулийн түгжээг тайлах бас олон зүйлүүдийг хийж чадлаа. Тухайлах юм бол Үндсэн хуульд бид нэмэлт, өөрчлөлт оруулж, 76 гишүүн биш 126 бүсчилсэн хөгжлийг тодорхойлж чадсан ийм том өөрчлөлтийг хийж чадсан. Үүний үргэлжлэл бол энэ Хот, тосгоны тухай энэ хууль орж байна гэж би бас ойлгож байгаа. Тухайлах юм бол манай БЗД чинь 500 гаруй мянган иргэдтэй. Тэгээд 1 дүүргийн статустай яваад байдаг. Тэгтэл хүн амын тоогоороо ер нь Монгол Улсдаа нийт хүн амын 10-аас их хувийг эзэлчихсэн, дүүрэг битгий хэл хэд хэдэн хот болох ийм хэмжээнд

болчихсон байгаа нь бас яг энэ хуулийн төслөөрөө бол 3 хот болохоор орж ирж байгаа нь бас их зохимжтой зүйтэй санагдаж байна.

2-т, бас нэг хэлэх гэж байгаа зүйл бол Ерөнхий сайдын хэлж байгаа яг төрийн үйлчилгээг 20-25 минутын радиуст авах боломжтой гэдэг зүйл бол үнэхээр иргэдийг, иргэддээ үйлчилдэг төр, иргэддээ үйлчилдэг хот болох үндсэн гол концепц гэж харж байгаа. Энэ концепц дотор харин нэг дутагдаж байгаа зүйлийг би зориуд энэ хууль санаачлагчдаас асуумаар байгаа юм. 12 дугаар зүйл дээр хотын нийтлэг чиг үүрэг гэдэг дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ерөөсөө дурдаагүй байгаа юм. Энэ чиг үүрэг дотор ер нь энэ төрийн тусламж үйлчилгээний дотор хамгийн түрүүнд бид баримтлах ёстой зүйл бол эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шүү.

Тэгэхээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээ орхигдуулан хотын нийтлэг чиг үүрэг дотор хот нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ гэдэг дотор хотынхоо иргэдийн эрүүл мэндийг хамгаалахгүй юм уу, тусламж үйлчилгээ үзүүлэхгүй юм уу? Бид 23 онд баталсан Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль баталлаа. Ард иргэдээ өвчнөөс хамгаалдаг болохыг зориод байдаг. Өвчнөөс урьдчилан сэргийлээд, өртөг зардал багатай байдлаар иргэдээ эмчилдэг байя. Сайн эмчилдэг байя, үр дүнтэй байлгая. Жишээлбэл өрхийн эрүүл мэндийн статус энэ тэр бол тодорхойгүй байдлаас болоод өнөөдөр бид төсвийг нь нэмээд, 2 дахин нэмээд байхад л өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ иргэддээ оновчтой болж чадаж байна уу.

Бид 100 мянга гаруй иргэддээ нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байя л даа. Өнөөдөр Улаанбаатар хотод байгаа дүүргийн эмнэлгүүдийн байдлыг харахад аймгийн эмнэлгийн статусаас доор байгаад байгаа байхгүй юу. Аймгийн Эрүүл мэндийн төвүүд нь эмнэлэг нь ээжүүдээ жирэмсэн эмэгтэйчүүдээ хүртэл төрүүлээд чадаад

байдаг, гэмтлээ аваад байдаг. Тэгтэл баахан төрөлжсөн эмнэлгүүд рүү Улаанбаатар хотын нэг захаас нөгөө зах руу зөөх болох гээд байна шүү дээ.

Тийм учраас энэ асуудал дээр энэ Улаанбаатар хотын нийтлэг чиг үүрэг дотор, хотын нийтлэг чиг үүрэг дотор энэ заавал зүйлийг оруулахыг бас та бүхнээс нэгд санал сонсьё. 2-т үүнийг асуудлыг оруулах тал дээр үргэлжлүүлэн ажиллаасай гэж хүсэж байна.

Г.Занданшатар: 3.
Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ яагаад 20 минутын хот гэдэг ийм асуудлыг Засгийн газраас гаргаж ирж тавив. Энэ дотор эрүүл мэндийн үйлчилгээ яах вэ гэдэг. Энэ ингэнэ гэсэн үг. Одоо 9 дүүрэгтэй ингээд байгаад байхаар Баянзүрх, Сонгино ч юм уу ийм том дүүргүүд төрийн үйлчилгээ дүүрэг дээрээ ингээд үзүүлэхээр, хүн ам нь өсөөд байхаар ингээд хүрэхээ больчихоод байгаа юм. Би БЗД-ийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргаар ажиллаж байсан. Тэгээд тухайн үед байгаа хүн ам тухайн үед Эрүүл мэндийн төвүүд үзүүлж байсан, нэгдсэн эмнэлэг үзүүлж байсан үйлчилгээ одоо бол ингээд харьцуулахад бүр тэнгэр, газар шиг ялгаатай болчихсон байгаа.

Хороод дээр хороодын Засаг дарга нар төрийн үйлчилгээ үзүүлэх гэж өнөөдөр хичээгээд байгаа. Гэтэл хороодын дарга нарт төсвийн эрх мэдлийг хуулиар өгөөгүй. Хороодын дарга нар бол төрийн нэрийн өмнөөс иргэдэд ийм бухимдал гаргадаг л нэг ийм мешок болчихоод байгаа юм. Ингээд хэсгийн ахлагч гээд тэгээд 1 хүмүүстэй. Тэгээд асуудал яригдаад байдаг, асуудлыг шийдэж чадахгүй. Тэгэхээр энэ эрх зүйн реформын хүрээнд хотууд болгож байгаа маань юу вэ гэхээр нэгж бүхэн эрх мэдэлтэй байна гэсэн үг. Эцсийн шийдвэр гаргах эрх мэдэлтэй. Дамжуулагч эрх

мэдлүүдийг бүгдийг нь байхгүй болгоно гэсэн үг. Дамжуулагч, тайлагнадаг эрх мэдлүүдийг бүгдийг нь байхгүй болгоно.

Нийслэл Улаанбаатар хотын нийслэл гэдэг статустай эрх мэдлийг анхан шат руу аваачна гэсэн үг. Дандаа дүүргүүдээсээ бүртгэл аваад, төв яам руу өгдөг ийм эрх мэдлүүд байгаа. Дахиад энэ Бага, Их тойрууд дунд байгаа. Тэгэхээрээ үүнийг бид нар энэ давхардсан бүтцийг задалж анхан шат руу эрх мэдлийг аваачна.

Дээрээс нь Чинбүрэн гишүүний ярьдаг тийм ээ, эрүүл мэнд, боловсрол, сургууль, цэцэрлэг, тэгээд тэнд байх үйлчилгээний төвүүд, соёлын үйлчилгээ, кино театр гээд бүх зүйлүүд яг Толгойт, Дарь-Эх гэдэг ч юм уу тэр орон нутаг дээрээ 20 минут дотор заавал үйлчилгээ авахад төвлөрнө гэдэг стандартыг л тавьчихна гэсэн үг. 20 минутад хүрэхгүй байвал тэнд сургууль, цэцэрлэг нэмж барина. 20 минут нь илүү гараад байвал тэнд баригдахгүй. Нэг үгээр хэлбэл их өгөгдөл дээр тулгуурласан ийм төлөвлөлтийг хийнэ. Түүнээс биш хүн өөрөө төлөвлөхгүй гэсэн үг.

Тэгэхээрээ бид нар яг тэр стандартынхаа дагуу л хийнэ. Тэнд явган хүний зам, гүйлтийн замаас авхуулаад бүх зүйлүүдийг нэг стандартаар бий болгоно. Төв бүхэн дээр хүний хөгжлийн төвүүд байгуулагдана. Хүний хөгжлийн төвүүд төрийн авах тийм ээ, 7-9 үйлчилгээ заавал байна гэж стандартчилж өгнө гэсэн үг. Ингэснээрээ хотын төв рүү орохгүй байх боломжийг гаргаж байгааг л 20 минут .../ минут дуусав/

Г.Занданшатар:

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн тодруулъя. 1 минут.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр энэ 12 дугаар зүйлийн хотын нийтлэг чиг үүрэг дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг бүр чиг үүрэгт нь оруулаад өгчих л ийм л зүйл байх нь чухал

л гэж бодоод байгаа юм. Тэгэхдээ энэ дээр та бүхэн анхаараач ээ л гэж хэлье.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч хариулна. 3 номер.

Х.Нямбаатар: Чинбүрэн гишүүн ээ, ийм байгаа юм. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг, хот, тосгоны хот нийтийн аж ахуйн чиг үүрэг гэдэг 2 зүйлийг хот, тосгон гэдэг зүйлд нийлүүлбэ ээ гэдэг ийм концепцтой хууль. Тэр утгаараа энэ хуулийн төслийн 27 дугаар зүйлд хот, тосгодод засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу одоогийн дүүрэгт байгаа, хотод байгаа эрүүл мэндийн чиглэлийн чиг үүргүүдийг шилжүүлэх ийм процесс хамтдаа явагдах юм. Тэр утгаараа бид нар тусад нь ингэж бичиж болохгүй чиг үүргийн шилжилт хийх учраас хуулиараа нэгдсэн нөгөө хуулийн бичилт, техник, хууль зүйн техник талаасаа 27 дугаар зүйлээрээ нэгмөсөн чиг үүргийн шилжилт хийнэ ээ гэдэг ийм агуулгаар бичигдэж байгаа юм.

Тэгээд би дахиад хэлье. Энэ 2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулийн 57.2-т хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг шилжүүлнэ ээ гэсэн энэ Үндсэн хуулийн суурь зарчмаас улбаатай өнөөдрийн энэ хууль тогтоомжийн өөрчлөлт бүхэлдээ орж ирж байгаа юм.

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн. Алга байна, хаслаа.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг бүрэн дэмжиж байгаа. Ерөнхий сайд үндэслэлүүдийг нь бол тодорхой хэлчихлээ. Би өөрийнхөө өнцгөөс хэлье гэж бодож байгаа юм.

Манай улс 3,5 сая хүн амтай, цорын ганц хоттой. Тэгээд залуу улс, залуу иргэнтэй, залуучууд олонтой. Залуу хүний хүсэл мөрөөдөл хот, суурин газар амьдрах бас тийм бодол бий. Тэгээд түрүүн дарга хэлсэн 0,3 хувь газар нутгийнхаа Улаанбаатар хот маань эзэлж байгаа. Тэндээ ингээд 1,6 долоон сая хүн нь ингээд амьдарч байгаа юм. Тэгээд өнөөдрийн энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Улаанбаатар хотын өмнө тулгамдаад байгаа томоохон асуудлуудыг шийдвэрлэх ийм үүд хаалга нь юм билээ. Би хуулийн төсөлтэй сайн танилцсан. Энэ түгжрэл, төвлөрөл, агаарын бохирдол, үйлчилгээнууд, тог цахилгаан, дулаан дийлэхээ больж байгаа шүү дээ.

Тэгээд хамгийн энгийн жишээ 2016 онд анх Хан-Уул дүүрэгт нэр дэвшиж байхад 104 мянган хүнтэй байсан юм. Одоо 260 гаруй мянган хүнтэй. 10 гаруй хороотой байсан, 25 хороотой. Дахиад хороо нэмэх шаардлагатай болж байгаа юм. Нийтдээ 204 хороотой. Тэлээд байдаг. Түрүүний хэлээд байгаа асуудлууд нь шийдэгдэхгүй улам бүр төвлөрөл бий болоод байгаа юм.

Тэгэхээр энэ хуулиар өөрөө нийслэлийн өмнө тулгамдаж байгаа, улс орны өмнө тулгамдаж байгаа томоохон асуудлуудыг шийдвэрлэх ийм гарц нь юм билээ. Жишээ авъя, манай хорооны Засаг дарга нар эрх мэдэл байхгүй. Ер нь их сайндаа нэг тодорхойлолт л хийж өгдөг хүмүүс болоод хувирчихсан. Иргэд нь тэнд бухимдлаа гаргадаг. Тэгвэл хорооны дарга нар маань бие даасан эрх мэдэлтэй, санхүүжилттэй, иргэдийнхээ асуудлыг шийдээд өгчихдөг ийм боломж хамгийн энгийнээр бүрдэх юм билээ.

Ер нь нийслэл маань үндсэндээ мухардалд орчхоод байгаа шүү дээ. Ямар нэгэн зүйлийг хийхгүй бол цаашаагаа энэ маягаараа явах боломжгүй болсон нь хүн болгонд тодорхой. Яах вэ, мэдээж хэрэг хэлэлцүүлгийн явцад, ажлын хэсгийн түвшинд ярилцах зүйлүүд гарна байх. Бүгдийг урьдчилж хараад тод

томруунаар хийчихэд хэцүү. Энэ хэлэлцүүлгийн түвшинд бол зарим зүйлүүд өөрчлөгдөж болох байх. Бүхэлдээ хамгийн гол нь нийслэлийн өмнө тулгамдаж байгаа гол гол асуудлуудыг шийдвэрлэх л ийм хуулийн төсөл учраас би энэ хуулийн төслийг бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа хэлж байгаа юм.

2 дугаарт, миний нэг хэлэх гээд байгаа зүйл би Нямбаатар даргадаа, энэ нийслэлийнхэндээ их талархаж байгаа. Залуучууддаа бид нар урам өгөх ёстой. Тухайлбал энэ Ботаникийн хүрээлэнгээс Улиастай руу хүртэх тэр замыг хэчнээн сайхан тавьж байна, иргэд маш баяртай байна. Драгоны бүтээн байгуулалт нүдэнд үзэгдэхүйц, гарт баригдахуйц ийм бүтээн байгуулалт болж байна. Дарга хүн 4 хананы дунд байгаад байдаггүй, газар дээр нь очиж асуудлыг бодитоор харж, бодитоор шийдвэрлэх энэ үлгэр жишээг манай Нямбаатар дарга багтайгаа хамт үзүүлж байгаа. Бид нар нэг наадмын өмнөхөн замуудын цагаан шугамыг нэг цагаанаар буддаг юм. Хачин юм болно доо. Зам хаагаад л, түгжрэл үүсгээд л, иргэдийг бухимдуулаад л. Цагаан шугамын тухай асуудал биш бүхэл бүтэн замын асуудлыг шуурхай шийдвэрлэж чадаж байна. Ингэж ажилламаар байгаа байхгүй юу.

Тэгээд энэ баг өнөөдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх юм байна лээ. Тийм учраас би итгэж байгаа. Нийслэлийн өмнө, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын өмнө тулгамдаж байгаа тэр асуудлуудыг шийдвэрлэх тийм баг бүрдсэн юм байна гэж бодож байгаа.

Ингэснээрээ бол зөвхөн сонгуультай холбоотой биш Монгол Улсын нийслэлийн өмнө тулгамдаад байгаа, иргэдийг олон жил бухимдуулж байгаа түгжрэл, утаа, түрүүний миний хэлээд байгаа энэ дулааны хангамж, тог цахилгаан гээд олон олон асуудлуудыг шийдвэрлэнэ. Хамгийн гол нь иргэд үйлчилгээгээ 20 минутын дотор амьдарч

байгаа газраасаа авах ийм боломж бүрдэх юм билээ.

Хуулийн төслийг бүр бүрэн дүүрэн дэмжиж байна.

Г.Занданшатар: Үг хэллээ.

Хавдисламын Баделхан гишүүн.
Хавдисламын Баделхан гишүүн асуулт асууна.

Х.Баделхан: Баярлалаа. Хуулийн төслийг бол бүрэн дэмжиж байгаа. Өмнө ч гэсэн бас энэ хуулийг шинэчлэх шаардлагатай гэж бид нар өргөн барьж байсан. Өнөөдөр цагаа олсон гэж бодож байгаа.

Хамгийн гол нь Үндсэн хуулийн өөрчлөлттэй нийцүүлээд улсын чанартай, орон нутгийн чанартай дагуул хот гэсэн 3 группээр хуваарилаад оруулж ирж байгаа юм байна л даа.

Тэгэхээр энэ дотроо зарим нэг сумууд, багууд орон нутгийн чанартай хот болоод, зарим нь бол ер нь ороогүй хасагдсан байдаг юм байна. Би нэг ганцхан жишээ асуухад энэ манай аймагт бараг сумын дайтай багууд байгаа. Тухайлбал Улаан хус сум гэхэд чинь Улаан хус Ногооннуур сум бол 10 мянган хүн амтай. 1 баг нь бараг 4000 хүн амтай. Тэр чинь сургуультай, эмнэлгийн салбартай. Ер нь тэд нар цаашидаа ямар зохион байгуулалтад орох юм бэ. Манай нэг Элбэгдорж Ерөнхийлөгч 1 Алтай Таван богд руу очихдоо эхлээд нэг даваа даваад энэ ямар сум бэ гэсэн чинь Улаан хус сум гэсэн юм байна. Дараа нь нэг хөтөл даваад энэ сум ямар сум бэ гэсэн чинь энэ сум биш баг гэж, тэнд чинь сургуультай асар том газар байхгүй юу. Тэнд бол ерөөсөө иргэд төрийн үйлчилгээ авч чаддаггүй.

Тийм учраас үүнийг цаашидаа ямар зохион байгуулалтад шилжүүлээд, иргэд төрийн үйлчилгээг яаж авах юм бэ гэж, 1.

2 дахь нь сая Нямбаатар сайд хэллээ. Хот, тосгон гэсэн 2 ойлголтыг нэгтгээд 1 ойлголттой болж байгаа гэж. Манай аймагт бол Цагааннуурын тосгон гэж тосгон байгаа. Монгол Улсад анх хил тогтооход тэр тосгон байгуулагдсан. Цагааннуур луу харьцаж байгаа баруун бүсийн гол тосгон. Тэндээ цэргийн анги байгаа, маш том тосгон. Сургууль байгаа. Цэцэрлэг байгаа. 100 жилийн түүхтэй. Өнөөдрийн байдлаар бол баруун бүсийн Ази Европыг холбож байгаа баруун бүсийн босоо тэнхлэгийн гол зам. Тэр тосгон нь цаашидаа ямар статустай болох юм бэ?

Нөгөө талын Хятадад залгасан талыг нь Байтаг богд орон нутгийн чанартай хот гэж байгуулсан байна лээ. Оросын талдаа залгасан Цагаан нуур тосгон маань энэ ямар ч юун дээр нэр байхгүй, орон нутагт ч байхгүй, дагуул хотод ч нэр байхгүй. Энэ цаашидаа яаж хөгжих юм бэ? Тухайлбал яг үүнтэй адилхан Хатгалыг Хөвсгөлийн. Хатгал хот болгосон байна лээ.

Тийм учраас энэ дээр нэг онцгой анхаараад өгөөч ээ гэж. Нэг ёсондоо тэр баруун хил дээр байгаа 100 жилийн түүхтэй Цагаан нуур тосгоныг Цагаан нуур хот болгож өгөөч ээ л гэсэн тодорхой саналыг би оруулж байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч хариулна. 3 номер.

Х.Нямбаатар: Би Баделхан гишүүний асуултад хариулъя. Баделхан гишүүн ийм байгаа. 2000-аас доошгүй хүн амтай бол угаасаа тосгон зохион байгуулалтаар энэ хууль дээр ингэж туссан. 30 мянгаас дотогш хүн амтай бол орон нутгийн зэрэглэлтэй хот байя. Төлөвлөлтөөрөө 100 мянга, 100 мянгаас дээш хүн амтай бол улсын зэрэглэлтэй хот байя л гэдэг ийм статус гаргаж ирж байгаа.

Тэгээд таны хэлж байгаа тэр Цагаан нуур бол одоогийн энэ бид нарын өргөн барьж байгаа төслийн хүрээнд хилийн боомт, тосгон байдлаар орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Хилийн боомтуудаас Замын-Үүдийг орон нутгийн зэрэглэлтэй хот байлгахар бас оруулж ирж байгаа. Ингээд энэ бол энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль батлагдаад хэрэгжээд явсан тохиолдолд цаашид тухайн орон нутгийн иргэд хүсэлтээ гаргаад орон нутгийн засаг захиргааны гаргасан хүсэлтийг Засгийн газар хүлээж аваад, тухайн хот, тосгон өөрөө бие дааж оршиж хөгжих боломж нөхцөлийг нь харгалзан үзээд, хот, тосгон шинээр ингээд нэмж байгуулах ийм эрх зүйн үндэслэлүүд бүрдэж байгаа л гэж ойлгож болно.

Хот, тосгод байгуулж байгаагийн гол агуулга бол Хот, тосгоныхоо захирагчийг тухайн суурин газрынх нь иргэд өөрсдөө шууд сонгодог байя. Ингэж байж хот, тосгодод наад захын, хот нийтийн аж ахуйн тэр стандартуудыг бий болгоё. Суурин газрууд өөрсдийнхөө олсон орлогыг өөр дээрээ төвлөрүүлж авч, дэд бүтцийг хөгжүүлэх сантай болъё гэдэг ийм агуулгатай л зүйл.

Өнөөдөр Монгол Улс 330 сумтай. Харамсалтай нь 330 сумаас хогоо шатаах үйлдвэртэй 1 ч бараг сум байхгүй. Нэлээд нэлээдгүй хэсэг нь ариутгах татуурга байхгүй байгаа. Улаанбаатар хот хүртэл өөрөө цэвэрлэх байгууламжийн хувьд иж бүрэн цэвэрлэх байгууламж өнөөг хүртэл шийдээгүй л байж байгаа.

Тэгэхээр бид нар энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн гол үндсэн агуулга нь Улаанбаатар хотын төвлөрөл, түгжрэлийг сааруулахаас гадна Улаанбаатар хотоос гадна 21 аймаг, энэ 330 сумд, суурин соёл, суурин иргэншил, хот, нийтийн аж ахуйн соёлыг бий болгох эрх зүйн үндэс, түүнийг дэмжсэн төсвийн бодлогыг бий болгоё л гэдэг л ийм агуулгаар орж ирж байгаа. Тэр дундаа Цагаан нуурыг бол тосгон, магадгүй орон нутгийн зэрэглэлтэй хот

болгон энэ хэлэлцүүлгийн шатад томъёолж оруулж ирэхэд бол татгалзах зүйлгүй. Манай зэргэлдээ боомтууд нь бүгд Хот, тосгоны хэлбэртэй байдаг. Манайх ямар ч зохион байгуулалтгүй байгаад байдаг байхгүй юу.

Тэгээд харьцах гэхээр боомтын нөгөө бие даасан харилцаа үүсэж өгдөггүйг бид нар бас энэ ажлын хэсэг дээр хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг ажиллаж байхдаа ер нь бүх боомтуудыг хот, тосгон байдлаар одоо энэ Их Хурлын тогтоолоор томъёолж оруулж ирье. Ингэвэл зэргэлдээ боомтууд харилцан шууд харилцах, гадаад харилцаа хөгжих, хот, суурин хөгжих ийм боломжууд бүрдэнэ ээ гэж үзсэн.

Цагаан нуурыг хэлэлцүүлгийн явцад та санал оруулбал ажлын хэсэг дээр шийдэх боломжтой гэж ойлгож байгаа.

Г.Занданшатар: Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Энэ ёстой нэг удаан хүлээж байсан хууль ороод ирлээ, ашгүй. Засгийн газар ингээд нэг зориг гаргаад томоор нь бариад ороод ирж байгаа нь маш сайн байна. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг тэсэн ядан хүлээж байгаа аймгуудын нэг бол манай Дархан хот. 1992 оноос хойш аймаг гэдэг статустай яваад байгаа. Энэ уг нь хот юм байгаа юм. Анхнаасаа хот. Одоо ч манай Дарханчууд өөрсдийгөө хотынхон гэж ярьдаг. Тэгээд яах вэ, олон жил яригдлаа. Бид нар 2020 оны сонгуулиар бас улсын чанартай хот болно л гэж ярьсаар байгаад л тэгээд нэг энэ 24 оны сонгуулийн өмнө энэ маань энэ хуулиар шийдэгдэх нь ээ. Дарханчууд маань их баярлаж байгаа. Үүнийг сонсоод.

Энэ Дархан улсын чанартай хот болох дээр зэрэг нэг 2 асуулт ургаж гарч ирээд байгаа юм. Бид нар өнгөрсөн жилүүдэд яах вэ манай гишүүд бид нар нийлж байгаад Дархандаа нэмж хүн авахад хангалттай байх дэд бүтэц, цахилгаан дулааны эх үүсвэр,

магистралууд, цэвэрлэх байгууламжууд, замууд гээд эд нар бол хангалттай хийчхэж байгаа юм.

2 асуудал үүсээд байгаа юм.

1 дүгээрт, энэ газрын асуудал байгаад байгаа юм. Дарханд маань жишээ нь гэхэд газар байхгүй. Тэгэхээр энэ хуулиар газрыг яаж шийдэх вэ? Сая бид нар бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Сэлэнгэ аймгийнхантайгаа, Төв аймгийнхантайгаа бүх сумдаар нь ороод уулзаад яриад явж байна. Тэгээд манай Дарханд асуудал үүсээд байдаг юм бол энэ газрын асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр хот маань улсын зэрэглэлтэй хот маань бий болохоор энэ газрын асуудлыг яаж шийдэх вэ, нэмж газартай болох уу яах вэ, 1.

2 дугаарт, ажилгүйдлийн асуудал асар их байгаа. Хүний төвлөрөл бий болоод ирэхээр. Ажилгүйдлийг шийдэх асуудал бол хөрөнгө оруулалтыг татаж, бизнесүүдийг бий болгох, татварын орчныг бий болгох ийм л зохицуулалт хэрэгтэй. Тэгэхээр улсын зэрэглэлтэй хотууд Дархан, Орхон гээд, Эрдэнэт гээд хуучны хотууд энэ хэдэн хотууд бий болох юм байна. Энэ хотууд маань өөрсдөө татварын хөнгөлөлт үзүүлдэг, хөрөнгө оруулалтыг татдаг орчныг бий болгодог, өөрсдийнхөө татвараар асуудлаа шийддэг ийм эрх зүйн орчин бүрдэх үү? Энэ хуулиар.

3 дугаарт, энэ Төсвийн хуулиар бас энэ асуудлууд нь шийдэгдэх үү? Яагаад би үүнийг асууж байгаа вэ гэхээр Дархан-Уул аймгийн Дархан сумын 2 дугаар багийн иргэд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутаг дэвсгэр дээр байдаг Ширээ нурууны иргэд гээд байдаг юм. Газар нь Сэлэнгийнх, иргэд нь Дарханых. Тэнд нийгмийн дэд бүтэц бид нар хийж чаддаггүй. Төсвийн хуулиар тэнд төсөв тавьж болдоггүй. Би 1г цэцэрлэг тавиад тэндээ бариулж чадахгүй байх жишээний тийм ээ.

Тэгэхээр ийм асуудлууд чинь 1 дүгээрт, шийдэгдэх үү? Тийм. Ийм 3 асуулт байна. Дараа нь энэ Мандал гээд Сэлэнгэ аймгийн Мандал, Дарханы Шарын гол, тэгээд л Зуунмод, Сүхбаатар хотууд хот болох юм байна. Дагаад энэ Сэлэнгийн нэг 6 тосгон байгаа юм, бас. Сэлэнгийн 6 тосгон байгаад байгаа юм. Энэ тосгод сумдаасаа том. Дулаан хаан, Хэрх, Түнхэл гээд том том тосгод байгаа байхгүй юу. Эд нар сум болж зохион байгуулалтад орох уу? Энэ хуулиар. Хүнийхээ тоонууд бол таны түрүүний хэлж байсанд орчхоод байх шиг байгаа юм.

Тэгэхээр энэ Засгийн газрын сүүлийн үед авч хэрэгжүүлж байгаа төвлөрлийг бууруулах бодлого их эрчимтэй зөв хэрэгжиж байгааг сая энэ орон нутгаар уулзалт хийгээд явж байхад ялангуяа хэлж байна. Цалинг суманд очоод ажиллах юм бол 40 хувь нэмээд, аймагт очоод ажиллах юм бол 20 хувь нэмээд, нийгмийн баталгааг нь сайжруулаад ингээд явчхаж байгаад орон нутгийн иргэд маш талархалтай байгаа юм. Тэгээд ер нь сүүлийн 34 жилийн хугацаанд Улаанбаатар хотод хүн нэмэгдэх хэрээр улам тэр хүмүүсийг татах бодлого хийж байснаа зогсоож, орон нутаг руу чиглэсэн ийм бодлого явж байгаа хууль орж ирж байгаад бол талархалтай байгаа шүү дээ. Энэ хэдэн асуултад хариулж өгөөч.

Г.Занданиатар: Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга хариулна.

Х.Нямбаатар: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж дээр Дархан хот байгуулагдаж байгаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийнх нь чиг үүрэг бүхэлдээ шилжиж байгаа. Үүнтэй зэрэгцээд Дархан-Уул аймгийн газар нутаг дэвсгэр нутаг байдлаар Дархан хот руу бүхэлдээ шилжиж байгаа. Энэ удаагийн өргөн барьсан төслийн хүрээнд зэрэгдээх аймаг орон нутгаас засаг захиргаа, нутаг

дэвсгэрийн нэгж, хилийн цэсэд өөрчлөлт оруулах тогтоолын төсөл өргөн баригдаагүй. Энэ асуудал бол нээлттэй. Тийм. Газрын хууль дагаж бас удахгүй багц хууль өргөн баригдах байх. Зүгээр энэ удаа хот, тосгод болгож байгаагийн гол агуулга нь хот өөрийнхөө татварыг авч болно, хот өөрөө татвараа төвлөрүүлээд дахин хуваарилна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд байдаг бүх чиг үүргүүд шилжиж очиж байгаа. Өөрийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөө тодорхойлно, өмчөө хувьчилна, шинээр татварын төрлүүд бий болгоно.

Цаашилаад Дархан хот өөрийнхөө тэргүүлэх чиглэлүүдээ татварын хөнгөлөлтүүд үзүүлэх боломжууд бүрдэж байгаа юм. Тухайлах юм бол ХАА-н тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх, тухайн гарч байгаа тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх энэ боломжууд бас давхар бас нээгдэж байгаа. Өөрөөр хэлбэл хот өөрөө хэрхэн яаж хөгжих вэ гэдэг нь тухайн тэр хотын зөвлөл, хотын захирагч дэвшүүлж байгаа мөрийн хөтөлбөрөөрөө иргэддээ танилцуулж, сонгогддог ийм тогтолцоо руу шилжиж байгаа юм.

Дээр нь нэмээд Дархан хот өөрийнхөө нийт нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хажуудаа байсан Шарын голоо дагуул хот байдлаар хөгжүүлэх, нөгөө хажуу талынх нь Хонгорыг тосгон байдлаар хөгжүүлэх энэ боломжууд бүрдэж байгаа.

Нэмээд та сая Сэлэнгэтэй холбоотой асуултыг асуулаа. Сэлэнгэ аймгийн хэд хэдэн томоохон тосгод бий. Би түрүүн хэлсэн нөгөө Ундром гишүүн хэлээд байсан. Маши олон суурин газруудтай. Яагаад гэвэл энэ нөгөө эрт суурьшууд явагдсан. Тэгэхээр эдгээрт яг үнэн нэг зүйл дутагдаад байгаа нь энэ нөгөө засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргүүдийг энэ тосгодод жишээлбэл Хэрх тосгонд шилжүүлж өгмөөр байгаа байхгүй юу. Энд өөрийн гэсэн сумын дайтай, магадгүй зарим

сумаас том ийм тосгод байгаа. Тэгэхээр энэ удаагийн Хот, тосгоны энэ эрх зүйн байдлын тухай хуулиар тэр 27 дугаар зүйлээр гэрээний үндсэн дээр тэр тосгодод, сумдад байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргүүдийг шилжүүлэн өгч болно. Энэ нээлттэй үлдэж байгаа. Ингэж байж тэр хот, тосгод заавал хажуу талынхаа сумаас очиж үйлчилгээ авах биш тухайн тосгондоо, тосгоныхоо хот, нийтийн аж ахуйн үйлчилгээг ч аваад, хажуудаа засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн буюу төрийн үйлчилгээг авах энэ боломжуудыг бид нар давхар бүрдүүлж байгаа.

Г.Занданшатар: Ганибалын Амартүвшин гишүүн асуулт асууна.

Г.Амартүвшин: Баярлалаа. Би Ерөнхий сайдаас асууя. Хөшигийн хөндийг яаж хөгжүүлэх гэж байгаа вэ? Энэ хуулийн төслөөрөө бол Аэро сити, Шинэ Зуунмод ингээж Улаанбаатар хотын маш чухал дагуул хот үүсэх юм байна. Тэгэхээр аливаа дагуул хот үүсэхэд бол эдийн засгийн бүтцийг нь шийдэх нь маш чухал. Түүн дотор бол мэдээж хэрэг дэд бүтцийн асуудал байгаа. Би нэг жишээ дурдъя. Амстердамын Сипхол олон улсын онгоцны буудал нь бол жилдээ 1,6 сая тонн эйр карго ачаа тээвэрлэдэг. Үүнийг тойроод маш Европын хамгийн том логистикийн төв үүссэн байдаг. Жилдээ дунджаар 60-70 мянган хүн ажилладаг ийм том. Тэгээд хэрвээ энэ шинэ хот байгуулагдах юм бол Улаанбаатар хоттойгоо яаж холбогдох юм бэ? Одоо байгаа замаараа холбогдох юм бол энэ чинь хамгийн хурдтай нь 45 минут, тэгээд түгжрэлтэй үед бол 1-2 тэр цаг хотын төвөөс явж очдог тийм байришил байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлыг яаж шийдэх вэ гэдгийг би асууя.

2 дугаарт, энэ Төв аймгийн нутаг дэвсгэртэй яаж уялдах юм бэ? Одоо шинэ онгоцны буудал чинь бол Төв аймгийн нутаг дэвсгэрт байгаа. Тэгэхээр энэ

нутаг дэвсгэрийн зааг хязгаарыг яаж шийдэх вэ гэж асууя.

2 дугаарт, би Нямбаатар даргаас бас асууя. Энэ Хан-Уул дүүргийн Богд Хан уулын Дархан цаазат газрын харьяанд орсон Зайсан, Яармаг болон бусад Богд уулын амуудын газар нутгийн асуудал яаж шийдэгдэх вэ? Шийдэгдэхгүй юу? 1 дүгээрт.

2 дугаарт, энэ чинь бид нар чинь жил болгон бараг сонгуультай болох юм уу? Их Хурлын сонгууль болно. Нийслэлийн Захирагчийн сонгууль болох юм байна. Тэгээд нийслэлийн зөвлөлийн сонгууль. Тэгээд шинээр байгуулагдаж байгаа хотууд чинь бас иргэдийн төлөөлөгчтэй болоод бас сонгуультай болох юм уу?

Тэгэхээр энэ жоохон ойлгомжгүй байна шүү. Үүнийг нэг тодруулж өгнө үү гэж асууя.

Хороодыг бол хороодын Засаг дарга нарыг эрх мэдэлтэй болгоно гэдэг чинь зөв өө. Мэдээж хэрэг нөгөө талд нь нөгөө нэг эдийн засгийн болон төсвийн орлоготой болох нь чухал. Зүгээр энэтэй холбоотой хэрвээ эрх мэдэлтэй болох юм бол дахиад нөгөө газрын наймаа чинь замбараагүй болох юм биш үү. Нийт Улаанбаатар нийслэл хотын төлөвлөлтийн дагуу хөгжихгүй, хороо тэгээд нөгөө орон нутгийн шинж чанартай хотууд чинь өөр өөрсдийнхөө төлөвлөлтийн дагуу хөгжөөд, газрын наймаа замбараагүй байшин барилга баригдаад явах юм биш үү гэдэг тийм болгоомжлол байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Эхлээд Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт, Шинэ Зуунмод хот гэж нэрлэнэ. Энэ бол манай Төв аймгийнхны санал гэж ойлгож байгаа.

2 дугаарт, Төв аймаг Төв аймгаараа л байна. Төв аймгийн газар нутагтай холбоотой ямар ч асуудал гарахгүй. Төв аймгийн газар нутаг дээр улсын чанартай хот байгуулагдана л гэсэн үг. Одоо байгаа аймгийн төв дэд бүтцийн хувьд илүү өргөжин тэлнэ. Илүү мэргэжлийн хүмүүстэй хамтарч ажиллах ийм боломж гарна гэсэн үг.

Дээрээс нь Шинэ Зуунмод хот гэж яагаад нэрлэж байгаа вэ гэхээр онгоцны буудал хавь нь аймгийн төвөөсөө илүү хөгжчих гээд байгаа учраас байгаа одоо аймгийн төвийг орхигдуулахгүй байх гэж ингэж нэрлэж байгаа. Тэгэхээр манай Төв аймгийнхны хувьд бол өнөөдрийн энэ хууль бол Төв аймаг хөгжлийн цоо шинэ шатад гарч байгаа ийм эрх зүйн орчин бүрдэж байна гэж ойлгох нь чухал юм.

Яаж онгоцны буудалтай нийслэл Улаанбаатар хотыг холбох вэ гээд. Энэ дээр төлөвлөгдөж байгаа зүйлүүд Цэцэрлэгт хүрээлэнгийн хажуу талаас Туул гол дээгүүр гүүр тавина, гүүр тавигдана гэсэн үг. Хотын төвийн хамгийн урсгалтай 3 цэгээс гүүр лүү гүүрээ хүрсэн ийм томоохон замын байгууламж хийгдэнэ гэсэн үг. Энэ гүүр шууд яваад Хүрхрээгийн амын хажууд ирээд ингээд туннелээр шууд Богд уулын цаана буюу Номтын ам руу гарна гэсэн үг.

Ингээд аймгийн төв энэ туннелээр гараад ерөөсөө л 1,5км-т байгаа. Ингээд онгоцны буудал руу шууд очно гэсэн үг. Энэ туннелийн бүтээн байгуулалт дээр манай Оюутолгойд ажиллаж байгаа инженерүүд зөвлөгөө өгч ажиллаж байгаа, ажиллахаар болж байгаа юм. Үүнийг удирдлагуудтай нь ярьсан. 10 мянган метрийн гүнд дэлхийд 4-д тооцогдох ийм том байгууламжийг манай инженерүүд хийж чадсан. Энэ бол том бүтээн байгуулалт. Одоо энэ чадвараа нийслэлийн түгжрэлийг бууруулахад нийслэл Улаанбаатар хотын төвийг шууд Хөшигийн хөндийтэй холбох ийм туннелийн том байгууламжийг бидний хувьд бол хийнэ гэсэн үг. Энэ бол

нэг 23-25 орчим километр үргэлжилсэн ийм туннел хийнэ.

Тэгэхээр хотын төвөөс Хөшигийн хөндий хүртэл шууд 1 гүүрээр гараад туннелээр дамжаад л очно гэсэн үг. Яармагаар тойрохгүй, тойрч болно л доо. Сонголт нь байгаа. Энэ агуулга өнөөдрийн хуулиар бас ингээд тогтоол болж орж ирж байгаа юм.

Тэгэхээр Шинэ Зуунмод хот байна. Бие даасан улсын чанартай хот байна. Шууд гүүр болон тунелиэр дамжиж холбогдоно. Энэ дээр Оюутолгойн бас туршлагатай гадна дотнын инженерүүд ажиллаж байгаа. Өнөөдөр Засгийн газрын баталгаа болон санхүүгийнх нь эх үүсвэрүүд давхар орж ирж байгаа гэж ойлгож болно. Энэ бол Бага тойрууд байгаа энэ 100 га доторх эрх мэдлийг задална. Хүмүүс бас Төв аймгийн нутаг руу Засгийн газар нүүж болохгүй гэдэг ийм зүйл яриад байгаа юм. Богдхаан уул бол өөрөө дархан цаазтай уул. Богд хаан уулд Их тэнгэр цогцолбор байдаг. Их тэнгэр цогцолбортой яг адилхан нөгөө талдаа л ийм гарах ийм боломж бас байгаа гэсэн үг. Тэгэхээр Төв аймгийн газар нутаг дээр очих гэдэг ийм агуулга бол биш.

Нөгөө талаараа ер нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу улсын түвшинд үйл ажиллагаа хийж байгаа аль ч байгууллага улс орныхоо нутаг дэвсгэр дээр аль ч түвшинд ажиллах бол эрх зүйн хувьд бол нээлттэй. Тэгэхээрээ бид нар энэ агуулга дээр сая таны асуусан Хөшигийн хөндийн бүтээн байгуулалт, нийслэл Улаанбаатар хот болон Хөшигийн хөндийн хөгжил, Шинэ Зуунмод хот концепц яагаад Улаанбаатартай адилхан статустай 6 улсын чанартай хот байгуулагдаж байгаа вэ гэдэг асуултын гол хариулт бол ийм байна.

Тэгээд Нямбаатар дарга нэмж хариулах зүйл байвал хариулчих нь зүйтэй байх.

Г.Занданшатар: Хишигээгийн Нямбаатар Нийслэлийн Заасаг дарга хариулна. 3 номер.

Х.Нямбаатар: Амартүвшин гишүүний асуултад би хариулъя. 1-д, Төв аймгийн Сэргэлэн, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэр дээр 2012 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд 31 мянган га газрыг авсан. Энэ 31 мянган га газар нутаг дээр Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг боловсруулж оруулж ир гэдэг үүргийг энд суугаа Улсын Их Хурлын гишүүд 2020 онд Засгийн газарт даалгасан. Энэ даалгасан Улсын Их Хурлын тогтоолын дагуу өнөөдөр Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг оруулж ирж байгаа. Энэ шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль нь анх удаагаа өөр аймаг, сумын нутаг дээр нийслэл хот шинээр дагуул хот байгуулах, цаашилаад дагуул хотоос олсон татварын орлогын 20 хувийг Төв аймагт төвлөрүүлж өгөх, 80 хувийг нь нийслэл Улаанбаатар хот дагуул хотынхоо хөгжил, эдийн засгийн тэлэлтэд зарцуулах ийм агуулга бүхий корпорацын зарчим дээр суурилсан ийм хотыг Хотын эрх зүйн байдлын тухай хуулийг оруулж ирж байгаа. Таны дурддаг Амстердамын нисэх онгоцны буудлыг түшиглэсэн Хотын эрх зүйн байдлын хуультай нэлээд тийм төстэй байдлаар энэ хуулийн төслийг боловсруулсан гэж ойлгож болно.

Цаашид энэ Шинэ Зуунмод хот нь аялал жуулчлал, тээвэр логистик, төрийн захиргааны төв байгууллагууд, худалдаа, үйлчилгээний төв гэсэн ийм санхүүгийн төв гэсэн ийм 5 үндсэн тэргүүлэх чиглэлтэй. Эдгээрийгээ хөгжих татварын эрх зүйн хөнгөлөлттэй орчинтой ийм хот байхаар төлөвлөж оруулж ирж байгаа гэдгийг хэлье. 1 дүгээрт.

2 дугаарт, таны асуусан Богд хаан уулын дархан цаазат газарт байгаа энэ үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой харилцаан дээр ямар зохицуулалт оруулж

байгаа гэж та асуулаа. Богд хаан уулын дархан цаазат газарт 4215 га газарт 2420 иргэн, ААНБ-д түр буудаллах, отоглох ажиглах ... /минут дуусав/

Г.Занданшатар: Амартүвшин гишүүн тодруулж асууна. Ганибалын Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Би Нямбаатар гишүүн бас үргэлжлүүлээд хариулчихна биз. Тэр газрын 2 дугаарт, нөгөө одоо хотын даргаа бид нар нийслэлчүүд сонгохоор орж ирж байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр энэ олон сонгууль чинь ар араасаа явах юм биш үү гэдэг нь миний нэг асуулт байсан. Ерөнхий сайдын хэлж байгаагаар бол сая тэгэхээр энэ яамнууд маань Төв аймгийн нутаг дэвсгэр лүү Шинэ Зуунмод руу нүүнэ гэсэн үг үү? Үүнийг бас тодруулаад хариулаад өгөөч. Баярлалаа.

Г.Занданшатар: Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Засгийн газрын харьяа байгууллагууд нүүнэ. Ер нь нэг 100 га дотор яг Бага тойруу гээд 86 га дотор манай Ерөнхийлөгчийн институт, Улсын Их Хурал бүхэлдээ түүний харьяа байгууллагууд, Засгийн газар бүхэлдээ нэг байшин дотор байдаг ийм улс бол маш цөөхөн. Эрх мэдэл бүхэн салангид байх ёстой. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл хоорондоо заагтай байх учиртай. Манайх шиг Улсын Их Хурлын Тамгын газрын референт ЗГХЭГ-ын ажилтантайгаа хамт нэг өрөөнд суудаг, Улсын Их Хурлын дарга нь ЗГХЭГ-ын даргатайгаа дээр, доор давхарт суудаг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дээр Шадар сайд байдаг, доод талд нь Ерөнхий сайд байдаг. Ийм ийм ид шидтэй байшин гэж манайд л байгаа. Аюулгүй байдал талаасаа ч энэ бол энэ олон улсын нөхцөл байдалтай холбогдуулаад энэ бол шулуухан хэлэхэд бол болохгүй болчхож байгаа юм.

Нөгөө талаараа энэ бүх эрх мэдлүүд 86-хан га дунд байгаа нөхцөлд

бид нийслэлийн түгжрэлийг шийднэ гэдэг бол зүгээр л өөрсдийгөө хуурч байна гэсэн үг. 100 га дунд бид нар юу давхарлаж барих юм, хэдэн гүүр хаагуур нь давхарлаж барих юм. 100 га гэдэг чинь өөрөө метроны нэг л буудал. Тэгэхээрээ энэ 100 га дунд л бид нар түгжирчхээд байгаа юм. Бид нарын эрх мэдэл түгжирчхээд байгаа юм.

Тэгэхээрээ үүнийгээ л бид нар задлах ёстой. Тийм учраас энэ эрх зүйн орчны хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу 126 парламентын гишүүнтэй болж байгаа учраас энэ ордон бол парламентын ордон болж үлдэнэ ээ гэсэн үг. Засгийн газар Төв аймгийн нутаг дэвсгэр дээр биш Богд хаан уулын цаана байгаа Номтын аманд очно гэсэн үг. Тийшээ хотын төвтэй туннелээр холбогдоно. Ингээд ААН-үүд Засгийн газрын холбогдох яамнуудтай хамт тийшээ нүүхийг уриална гэсэн үг. Тэнд шинэ орон сууцын хороолол төрийн албан хаагчдын ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмж өгнө гэсэн үг.

Тэгэхээрээ 1 үгээр хэлбэл 2 таталцлын төвтэй хот болно гэсэн үг. Нэг нь одоогийн нийслэл, нөгөөдөх нь Хөшгийн хөндийн хавь. Энэ зүйл рүү бид нар шийдэж байж ойрын ирээдүйн 3-4 жилийн дотор нийслэлийн түгжрэлийг шийднэ. Өөр нэг ч гарц байхгүй. Бусад нь бол бүгдээрээ тийм гал унтраасан, аргацаасан ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ерөнхий сайд гүйцээж хариулъя, нэмж.

Л.Оюун-Эрдэнэ: Тэгэхээр би үгийнхээ эхэнд бид Үндсэн хуулийг хамтдаа өөрчилсөн. Тухайн үед хэцүү байсан. Гишүүдийн тоог нэмнэ гэхэд бараг боломжгүй юм шиг. Эхний уулзалт дээр манай гишүүд шантарчихсан ийм нөхцөл байдалтай байсан. Тухайн үед ковидтой, бухимдалтай, юун ийм зүйлийн дундуур гишүүдийн тоо нэмэх тухай яриад байгаа юм бэ. Гэхдээ хийгдсэн. Түүний үр дүнд өнөөдөр маш их олон улс төрийн намууд сонгуульд оролцохоо

илэрхийлж байна гэдэг бол идэвхжил өөр болсон. Парламентад зөвхөн 2 нам биш олон намууд суудалтай болох боломж бүрдэж байгаа юм. Жагсаалтаар нийгмийн төлөөлүүд орж ирэх ийм боломж бүрдэж байгаа юм. Энэ хийгдсэн.

Бүсчлэл маш их олон жил яригдсан. Болохгүй л гэж байсан. Өнөөдөр бид нар бүсчлэгдчихсэн байна. Бүх сэтгэл зүй бүсчлэгдэж байгаа тухай ярьдаг болсон байна. Хөдөө орон нутагт, гишүүд бүс гэж тойрч байна. Цагаан сарын золголт хүртэл бүс гэж хийгдэж байна.

Баялгийн сангийн хууль хийгдчихлээ. Мэдээж хэрүүл маргаантай байна. Гэхдээ олон жилийн хугацаанд яригдсан энэ асуудал хийгдсэн. Хууль хэрэгжиж эхлээд 10 мянган айлын ипотекийн зээлийн эх үүсвэр шууд энэ жилийн эх үүсвэрээр шийдэгдэх боломж бүрдэж байгаа. 10 жилийн дараа тэр залуучууд мөнгөө авах байсан бол одоо 10 хоногийн дотор авах боломж бүрдэж байгаа юм. Тэгэхээр шийдэл хийж болбол болж байна гэсэн үг.

Яг үүнтэй адилхан би бас нийслэлчүүддээ ч гэсэн хандаж хэлэхэд, улс төрийн намууддаа ч гэсэн хандаж уриалахад, бидэнд өөр дорвитой том шийдэл байхгүй. Бидэнд улсын чанартай б хот, түүн дотроо Хархорум зэрэг бүсийн төвүүд, Дархан, Орхон, өмнийн говийн ингээд баригдаж байгаа хотууд гээд. Гэхдээ хот сүндэрлэхэд хугацаа хэрэгтэй. Ойрын ирээдүйн 3-5 жилийн дотор нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бүтэн шийдэх цорын ганц концепт бол Хөшигийн хөндий рүү тэлэх. Тэгэхийн тулд Засгийн газар өөрөө манлайлах. Тэгээд тэнд очоод Засгийн газрын бүх үйлчилгээнүүд авагдах. Мэдээж энд Гадаад яам, БХЯ, ХЗДХЯ гээд үндсэн яамдууд үлдэж болно. Гэхдээ л үе шаттайгаар энэ 86 га дундаас гүйцэтгэх засаглал өөрөө гарч байж, хувийн хэвилийнхэн итгэнэ, гарч байж иргэд итгэнэ. Гарч байж их, дээд сургуулиуд нүүх тухай бодож эхэлнэ. Ингэж байж

бид нар энэ 86 га-ийн төвлөрсөн эрх мэдлийг задална.

Маш товчхондоо энэ хуулийн ерөнхий концепт бол 86 га дунд байгаа энэ эрх мэдэл хороон дээр очно гэсэн үг. 3 институт салж нэг институт нь Богд уулын цаана гарна гэсэн үг. Ингэж байж Хөшигийн хөндий хөрөнгө оруулалтын хувьд амьдарна. Ингэж байж 2 дахь том хот Хөшигийн хөндий хавьд цогцолно. Өөр газрууд бид нар зөндөө ирсэн. Онгоцны буудал барьчихаад бид нар тэгээд өөр газар хайж тэгж цаг алдаад яах вэ дээ, тийм ээ. Онгоцны буудал дангаараа бас хот болохгүй нь ойлгомжтой. Тэгэхээр зах зээлийг нь өгөх учиртай ингээд болчихож байгаа.

Тийм учраас ийм томоохон шийдлүүд гаргаж ирж байгаа юм. Тэгээд энэ бол яах вэ, бас би Их Хурлын даргад ч бас санал тавьсан. Ирэх 7 хоногт энэ нийслэлийнхээ хүрээнд манай нийслэлийн гишүүд маань, манай Төв аймгийн гишүүд маань улс төрийн намууд ч гэсэн бас энэ дээр нэлээн зөвшилцөөсэй. Яагаад гэхээр энэ бол өөрөө суурь шийдэл. Маш их хэмжээний олон юмнууд өөрчлөгдөнө. Гэхдээ яах вэ, шийдэлгүй ингээд байгаад байх биш энэ бол үндсэн шийдэл болно. Хэрвээ үүнийг шийдчихвэл аяндаа л бусад бүх асуудлууд дагаад шийдэгдэнэ ээ гэсэн үг гэдэг агуулгаар бас өнөөдөр орж ирж бас танилцуулж байгаа.

Яг л Үндсэн хуультай адилхан, бүсчилсэн хөгжилтэй адилхан, Баялгийн сантай адилхан энэ бол хэцүү сэдэв. Маш их маргаан дагуулна. Гэхдээ дахиад хэлэхэд үүнээс өөр шийдэл байхгүй. Үүнээс өөр Б хувилбарыг гаргаж ирвэл би хүлээж авахад бэлэн байна, бууж өгөхөд. Гэхдээ би ЗГХЭГ-ын даргаар тодорхой хэмжээнд ажиллаж яг энэ 2050 дээр ажилласан хүний хувьд, Ерөнхий сайдаар дээр 3 жил ажилласан хүний хувьд бид энэ дээр зориг гаргаж шийдэхээс өөр олон нийтийг уриалж, хамтдаа байхаас өөр сонголтгүй. Ингэж чадахгүй бол бид нар энэ 86 га дундаа бүр илүү түгжирнэ. Хэн ч хотын даргаар ажиллаж тогтохгүй

болно. Нийгмийн уур амьсгалд асар их сөрөг нөлөө бий болно. Ингээд яах вэ гэхээр зүү орох зайгүй чихчихсэн 1 минут ч хөдөлж чадахгүй хот 10 жилийн дараа гэхэд бий болно. Тэгэхээр тэр үеийн хүмүүст хэдүүлээ ачаа үлдээгээд яах вэ. Өөрсдөө галаа авъя. Тийм л зүйлд л би бас улс төрчдөө уриалмаар байна. Юу ч болдог бай шийдэлтэй байя.

Г.Занданшатар: Нямбаатар дарга. Хишгээгийн Нямбаатар дарга хариулъя. 3 номер

Х.Нямбаатар: Би Амартүвшин гишүүн, түрүүн нэмээд хариулчихъя. Энэ Богд хан уулын дархан цаазат газар нутагт нэг 4215 га талбайд 2500 орчим иргэн, ААН түр буудлага, отоглох байр, ажиглалт судалгааны төв зориулалттай үл хөдлөхүүд барьчихсан байгаа. Тэгээд үүний менежментийг хот авъя гэж байгаа юм. Ингээд менежментийг авъя гэдэг маань дэд бүтцээр хангах шаардлагатай бол хангая, эргээд үл хөдлөхийнхөө татварыг авъя. Нэмж 1 ч метр квадрат газар олгохгүй ээ гээд энэ хууль дээр бас биччихэж байгаа.

2 дугаарт, энэ экологийн гарц хийхгүй бол бид нар энэ Богд ууланд байгаа энэ байгаль, эко системд маш их хор уришгатай юм хийж байгаа. Тойруулаад битүү байшин барьчихсан. Энэ баруун тийшээ Аргалантын нуруу руу, Хустайн нуруу руу экологийн гарцтай болох ёстой. Урагшаа Төв аймгийн Сэргэлэн сум руу экологийн гарцтай болох ёстой. Үүнийг энэ хууль дээр Засгийн газар экологийн гарц хийнэ ээ гэдэг бас зохицуулалт давхар оруулж ирж байгаа.

Нэмж хариулах юм өөр юу үлдлээ. Энэ ерөөсөө гишүүд нэг зүйлийг ойлгоорой. Энэ бид нар шилжилтийн үеийн зохицуулалт гэж байна. Шилжилтийн үеийн зохицуулалт дууссанаас хойш энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид зөвхөн хотын дарга, хотын зөвлөл 2 л сонгогдоно. Цаасан дээр нөгөө засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж маань 1993 оныхоороо үлдэнэ.

Үүнээс хойш тухайн хотын дарга нар хотын даргаа иргэд нь шууд сонгодог. Хотын зөвлөлийн гишүүдээ иргэд нь шууд сонгодог хоёрдмол ийм сонгуулийн тогтолцоогүй шууд сонгодог ийм тогтолцоотой болохоор хуульд оруулж ирсэн.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг үзэл баримтлалынх нь хувьд нэлээн уншсан. Яах аргагүй бид нар энэ 92 оноос хойш ардчилал зах зээлийн харилцаанд шилжсэн. Гэхдээ нэг зүйлийг анзааралгүй явсан. Иргэдийн маань нэлээдгүй буюу тодорхой хэсэг нь нэг соёл иргэншилээс нөгөө соёл иргэншил рүү шилжсэн, түүнийг үл анзаарцаасан. Энэ нь магадгүй хөгжилд чөдөр болсон байхыг үгүйсгэхгүй.

Тийм учраас одоо бид тэр хэсгийнхээ хөгжлийг яаж хангах вэ гэдэг эрэл хайгуулд мордоцгоож энэ хуулийн төсөл босож ирж байна л даа. Босож ирж болно. Гэхдээ анзаарах ёстой зүйлүүд байгаад байдаг. Бид хэд Үндсэн хуультай эрх зүйт төрийг төлөвшүүлж байгаа улсууд. Гэтэл Үндсэн хуулийнхаа 57-г яаж нийцүүлж, энэ хуулийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх вэ гэдэг л юм байгаад байгаа юм. Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргаанд хуваагдана, энэ нь аймаг, нийслэл байна гээд хэлчихсэн. Засаг захиргааны нэгж дотор улсын болоод орон нутгийн зэрэглэлтэй хот байх тухай хэлчихсэн. Гэтэл энэ хуулийн үзэл санааг уншихаар зарим тохиолдолд параллельны хот, тосгон нэртэй засаг захиргааны нэгжүүд байгуулаад байгаа. Эрх хэмжээ нь ч тийм, дагасан хуулиудаар олгогдож байгаа эрх нь ч тийм. Үүнийг ер нь юу гэж ойлгоцгоогоод байна? Яаж зохицуулах ёстой вэ гэдэг нэг ийм зүйл байна гэж.

2 дахь зүйл. Бид уул нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн

байдлын тухай хууль, тэгээд Хот төлөвлөлт, хот байгуулалтын тухай хуулиараа л хотын харилцааг ер нь тэр чигт нь зохицуулж болох ийм багц хууль гарах ёстой гэж ингэж ойлгоод байгаа, би бол. Гэтэл тусгайлсан хуулиар зохицуулж байгаа хотуудыг юу гэж ойлгох юм бэ гэдэг асуудал гарч ирээд байгаа юм. Угаасаа улсын зэрэглэлтэй ч бай, орон нутгийн зэрэглэлтэй ч бай, яг энэ хэдэн хууль дотроо л захирагдаж, тэр хот юмнууд байгуулагдах тухай асуудал өөрөө тов тодорхой гарч ирж асуудал нь шийдэгдэх ёстой л гэж л ингэж л харагдаад байна. Үүн дээр ямархуу мэдээлэл өгөх вэ гэж.

Дараагийн нэг зүйл. Бид нэг төвтэй хөгжлийн бодлогоос олон төвтэй хөгжлийн бодлого руу шилжих тухай асуудал ярьцаасан. Үүнийг би зөв гэж ойлгодог оо. Гэтэл энэ орон нутгууд чинь бас гайгүй хөгжлийн боломжуудаа тодорхой нэг цэгүүд дээр гэдэг юм уу, төвлөрүүлсэн тэр боломж нь эргээд орон нутгийнхаа хөгжилд нэлээн том нөлөө үзүүлээд яваад байгаа. Гэтэл эдгээр нь улсын болоод орон нутгийн зэрэглэлтэй хот болоод, тэндээс бүрдэж байгаа төсвөө өөрөө захиран зарцуулдаг эрх хэмжээтэй болоод, тэгээд өнөө нутаг дэвсгэр дээр нь оршиж байгаа нэгждээ ямар дэм болох юм бэ? Энэ асуудал нь өөрөө нэлээн тийм бүрхэг болчихоод байгаа. Ийм зүйл байгаад байна. Үүн дээр нэг тодорхой хариулт өгье өө.

Дараагийн нэг зүйл. Би тусдаа хэлэлцэгдэж байгаа гэж ойлгоод байгаа. Тэр Шинэ Зуунмодын хуулийг, төслийг бол тусдаа энэнийхээ дараа хэлэлцэгдэх юм байна гэж ингэж ойлгоод байна шүү дээ. Тийм учраас түүнийг бол яг тэр тухайн үе дээр нь тодруулж асууя гэсэн ийм бодолтой байна. Нэг ийм хэдэн зүйл дээр тов тодорхой хариу авмаар байна.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Оюун-Эрдэнэ сайд. Дараа нь Нямбаатар дарга нэмж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Батжаргал гишүүн их чухал асуудлыг хөндлөө. Нутаг дэвсгэрийн нэгж бол газрыг хувааж байгаа ийм эрх зүйн ойлголт тийм ээ. Газар дээр ямар ч хот, хэдэн ч хот байгуулагдаж болно. Үүнийг л бидний хувьд ингээд ойлгочихмоор юм. Энэ ингээд олон улсын нийтлэг жишиг. Тэгэхгүй бид нар нөгөө хот гэхээр заавал тэр өөрийн газартай байлгах гээд үүнээсээ болж маргалдаад хотоо барьж чаддаггүй. Хот бүр аймаг дамнаж байж болно. Жишээ нь Дархан, Сэлэнгийг дамнасан их хот сүндэрлэж болно. Тэр өөрийнхөө хотын эрх зүйн хувьдаа тухайн хотынхоо өдөр тутмын ажлыг л хот хариуцна. Хот заавал газар нутагтай байх ёстой биш. Хот аль ч аймгийн газар нутаг дээр бие дааж байж болно.

Тэгэхээр үүнийг л бид нар ойлгохгүй бол манайх нөгөө одоо энэ, сүүлийн өнгөрсөн бас энэ цаг хугацаанд ерөөсөө маргаан тэр байсан. Жишээлбэл, яагаад бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал төдийлөн сайн хэрэгжиж чадаагүй вэ гэхээр яг л энэ маргаан байсан. Бүсчилнэ гэхээр нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд өөрчлөлт хийх гээд байгаа юм байна гэж ойлгоод аль аймгийг хэнтэй нэгтгэх юм бэ гэдэг асуудал яриад л гацсан байхгүй юу. Гэтэл одоо бид нар тойргоо бүсчилчхэж байгаа юм. Аяндаа Их Хурлын гишүүдийн бодлого концепц орон нутагтайгаа хамт бүсчлэгдээд харах хандлага нь өөрчлөгдчихөж байгаа болохоор бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал явж эхэлж байгаа нь тэр. Одоо дандаа аймгийн төвүүдийг хооронд нь холбох, тэгээд бүс бүхэн ямар боомттой байх вэ, эдийн засгийн тэргүүлэх чиглэл нь юу байх вэ гэдэг асуудал л яригддаг болсон байна лээ. Урьд нь бол зөвхөн манай аймгийн асуудал, хажуу аймаг яаж байна вэ хамаа ч үгүй байдаг байсан.

Тэгэхээрээ энэ бол их тийм зөв зүйл рүү явж байна. Яг энэ агуулга руу бид нар ойлголтоо өөрчлөх, ойлголтоо харах өнцгөө өөрчлөх ийм зайлиггүй шаардлага бас байна гэж бодож байгаа.

Дээрээс нь Үндсэн хуулийн үг, заалт бүхнийг бид нар сайтар судлах ёстой юм байна лээ. Жишээлбэл улсын нийслэл Улаанбаатар хот мөн. Нийслэлд төр захиргааны төв байгууллагууд байнга оршин байна гэдэг ийм заалт байдаг. Гэтэл Засгийн газар гэж юу вэ гэхээр Ерөнхий сайд кабинетын гишүүдтэй хуралдаж байгаа хуралдааны танхимыг л Засгийн газар гэж үзнэ. Салчихвал Засгийн газрын харьяа яамнууд. Яамнууд аль ч газар байхыг хуулиар хэзээ ч хаагаагүй. Гэтэл бид нар энэ агуулгаараа л энэ 100 га дундаа тайлбарлаж байсаар, түгжирсээр л ирсэн. Гэтэл хот маань улсын 0,3-хан хувь байдаг. Нийт нутгийн. Тэгэхээрээ бид нар харах өнцгөө өөрчлөх ... /минут дуусав/

С.Одонтуяа: 3 номерын микрофон Нямбаатар дарга нэмж хариулъя.

Х.Нямбаатар: Би Батжаргал гишүүний асуултад товчхон хариулъя. Бид нар 2019 оны 11 дүгээр сарын 14-нд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 57 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дараах нэмэлт, өөрчлөлт орсон. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага зохион байгуулалтын үндсийг хуулиар тогтооно гэсэн. Үүний дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг өнөөдөр 1 дүгээрт, органик хуулийн үүднээс оруулж ирж байгаа гэж ойлгож болно.

2 дугаарт, энэ 57.2-ын үргэлжлэлд ийм өөрчлөлт орсон. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ ээ гэж байгаа юм. Тэгэхээр түүрүүн Ерөнхий сайд хэлсэн. Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хот, тосгон байгуулах асуудлыг бид нар өнөөдөр энэ 34 хуулийн хамт, Улсын Их Хурлын тогтоолын хамт оруулж ирж байгаа юм.

Төв аймагт та сая хэллээ. Хот, тосгод байгуулаад тухайн засаг захиргааны нэгжидээ ямар өгөөжтэй юм бэ гээд. Хүн амын төвлөрөл бий болохын хэрээр л тухайн орон нутгийн татварын бааз суурь нэмэгдэнэ ээ л гэж ойлгож болно.

2 дугаарт, бид нар энэ Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулиар анх удаагаа Төв аймгийн нутаг дэвсгэр дээр Шинэ Зуунмод хот гэдэг Улаанбаатар хотын дагуул хотыг бий болгоод, татварын бүрдлийнхээ 80 хувийг орон нутагт нь шууд шилжүүлж өгье. 20 хувийг, 80 хувиараа бид нар өөрсдөө тухайн дагуул хотоо тэжээж тэтгэж, хөгжүүлж шинэ эдийн засаг үүсгэе ээ л гэдэг л ийм агуулгаар л өнөөдрийн энэ хуулийг өргөн мэдүүлж байгаа. Үндсэн хуулийн эрх зүйн хувьд энэ органик хуулиа 1 дүгээрт, Засгийн газар өргөн барих ёстой. Үүнийхээ дагуу өргөн барьж байгаа.

2 дугаарт, энэ Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийнхөө хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дээр нь хот, тосгодыг бий болгоод, тэр засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийнх нь чиг үүргийг хот, тосгодод шилжүүлж ... /минут дуусав/

С.Одонтуяа: Батжаргал гишүүн тодруулъя. 1 минут.

Ж.Батжаргал: Тийм, яах аргагүй эрх зүй талаасаа нэлээн судалбал хууль хоорондын нийцэл хангагдаагүй юмнууд байгаад байгаа юм. Одоо энд манай Нямбаатар дарга юм ярьж байгаа юм. Өөр нэгжийн нутаг дэвсгэр дээр дагуул хотоо байгуулаад, татвар юмнуудынх нь 80 хувийг нь өөрөө авчхаад, 20-ийг нь тухайн нэгжид нь үлдээнэ гэж. Ямар ч эрх зүйн зохицуулалт байхгүй. Энэ бол зүгээр л амбиц байхгүй юу. Энэ орон нутгууд чинь угаасаа Татварын тухай хуулиараа ямар нэр төрлийн татварууд нь хаанаа орох ёстой вэ. Ямар нэр төрлийн татваруудынх нь ямар хэмжээ аль түвшиндээ очих ёстой вэ гэдэг юм нь

тов тодорхой заагдчихсан байхгүй юу. Гэтэл жаал эдийн засаг, санхүү боломж төвлөрсөн газрыг нь улсын зэрэглэлтэй гэдэг юм уу, орон нутгийн зэрэглэлтэй хот болгож байгаад, тухайн хот нь өөрийнхөө хөгжилд гээд бүх юмаа авчхаад, тэгээд өнөө орон нутаг ... /минут дуусав/

С.Одонтуяа: Нямбаатар дарга нэмж хариулъя.

Х.Нямбаатар: Батжаргал дарга таны гар өргөж батлалцсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд дагуул хотыг нийслэлийн болон бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, эс үгүй бол засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжид дамнан байгуулж болно гээд хэдүүлээ баталсан шүү дээ. Нийслэлийн эрх зүйн байдлын хууль. Үгүй ээ та Үндсэн хууль зөрчсөн эсэхийг та шийдэхгүй шүү дээ. Цэц шийднэ шүү дээ. Бид нар энэ хууль батлаад 3 жил болж байна.

2 дугаарт, энэ дагуул хот байгуулаад дамнан байгуулсан тохиолдолд татвараа ингээж хувааж хот байгуулж болно гээд. Ингээд бид нар Нийслэлийн эрх зүйн байдлын хуулийг батлаад 3 жил болж байгаа шүү дээ. Та ингээд ингээж шууд над руу яаж дайрч болохгүй. Би энэ хэдүүлээ хамт сууж байгаад л Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан. Одоо үйлчлээд 3 жил болж байна. Үүний дараа бид нар энэ тогтоол дагаж гарсан Их Хурлын тогтоолынх нь дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг хамтад нь оруулж ирж байгаа шүү.

С.Одонтуяа: Тлеуханы Аубакир гишүүн асууна. Алга байна. Уучлаарай. Тэнд суудаг шиг санаад. Аубакир гишүүн асуултаа асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Энэ цаг үеэ олсон зөв хууль орж ирж байгаа. Энэ Улаанбаатар хотын төвлөрлийг,

Улаанбаатар хот руу чиглэсэн хөдөөгөөс шилжсэн хөдөлгөөнийг тодорхой хэмжээнд сааруулахын тулд Хот, тосгоны тухай хууль ихэнх аймгууд дээр тосгод шинээр бий болж байгаа. Улаанбаатар хотыг тэлэх, энэ төвлөрлийг багасгах, дагуул хотуудыг хөгжүүлэх ийм үндсэн суурь хууль болж байна гэж үзэж байна. Үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа.

Энэ тосгоны асуудал дээр сая Баделхан гишүүн бас асуусан. Манай Баян-Өлгий аймгийн хувьд Сайнзориг дарга аа, Баян-Өлгий аймгийн хувьд ганцхан тосгонтой, 100 жилийн түүхтэй. Баян-Өлгий аймгийн хувьд зарим сумдын багууд нь 2-3 мянган хүнтэй багууд байгаад байгаа юм. Тийм ээ, Улаанхус сумын Хөх хөтөл баг, Согоох гэж баг байна. Сургууль, цэцэрлэгтэй. Зарим төрийн үйлчилгээгээ авахын тулд цаг гаруй бие давхар эхнэрээ сундлаад л сумын төвийн эмнэлэг рүү явдаг л даа. Өвлийн хүйтэнд ч бай. Энэ орон нутгийн иргэдээс тавьж байгаа хүсэлт нь эдгээр хүн амын төвлөрөл жилээс жилд нэмэгдэж байгаа энэ багуудыг тосгон болгож өгөөч ээ гэсэн асуудал тавигддаг. Хуулиараа аймгийн иргэдийн хурлаас шийдвэр гаргаад явуулах юм бол Засгийн газраас шийдчих бололцоотой. Гэхдээ энэ яг хуулийн хэрэгжилт нь үндсэндээ манай Баян-Өлгий аймгийн хувьд бол сүүлийн 10 жил энэ тосгон болгох хүсэлтээ тавьж байгаа. Засгийн газар дээр шийдэгддэггүй.

Тосгон дээр шийдэх ёстой асуудлууд их байгаад байгаа юм. Наад зах нь газрын даамлыг нь томилж өгөх. Сумаасаа газрын даамал нь ирдэг. Тосгон гэдэг чинь тодорхой хэмжээний өөрийн газартай, бэлчээрийн асуудал энэ эдэлбэр газруудын зохицуулалтын асуудлууд. Тэнд нэгэнт л 2000 иргэн амьдарч байгаа мөртөө сумтайгаа бэлчээрийн маргаантай, бэлчээрийн маргаан. Зуслан дээр та нар бууж болохгүй, намаржаан дээр бууж болохгүй зэрэг. Төсөв бүрдүүлэх асуудал нь бас л маргаантай явж байдаг. Орон нутгийнхаа давсан

хэсгээсээ төсвийг нь бүрдүүлж өгдөг. Энэ нь бас маргаантай.

Одоо яг энэ хууль дээр энэ зарим тосгоны зохицуулалтууд жосоохон учир дутагдалтай зүйлүүд бас байгаад байна. Энэ төрийн албан хаагчдыг яг хүрч ажиллах, тэр иргэдийг төрийн үйлчилгээг богино хугацаанд сая та бүхэн ярьж байна. Улаанбаатар хотын хаанаас ч очсон 20 минутын дотор төрийн үйлчилгээг авах нөхцөл бололцоог нь бүрдүүлж өгнө гэж. Яг үүнтэй адилхан тосгоны иргэд маань, тэр багийн иргэд маань сумын төвөөсөө авч байгаа энэ төрийн зарим ажил үйлчилгээг богино хугацаанд чанартай үйлчилгээ авах энэ боломжийг нь энэ хуулиараа яг яаж оруулж ирж байгаа вэ? 1 тосгоны захирагч гээд хүн байж байдаг. Тодорхой хэмжээний ойр зуурын асуудлыг ишийдчих ч хүртэл төсөвгүй нэг хүн гүйгээд л байдаг.

Тийм учраас яг энэ хууль дээрээ бас анхаарах зарим зүйлүүд бас байгаад байна. Хэлэлцүүлгийн явцад сайжруулах зүйлүүд байна. Энэ 8 дугаар зүйл дээр заасан энэ тосгоны ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт, хөшөө дурсгалын босгох, хүндэтгэлийн самбар байгуулах энэ тэр гээд. Яг үүнтэй адилхан зарим зүйлүүдийг тусгах шаардлагатай байгаад байна. Тосгон дээр яг ийм ийм төрийн үйлчилгээ үзүүлдэг, иргэд тэнд яг төрийн албан хаагчаар байнгын ажиллагаатай байна.

Дээрээс нь энэ эдэлбэр газраа тэр сумтайгаа яг яаж ашиглах юм. Энэ хилийн цэс энэ тэр маань энэ дээр яг яаж орж ирж байгаа вэ? Тийм учраас энэ тосгоныхоо зарим энэ төрийн үйлчилгээг сумынхаа төвөөс 40-60 км, 100 км ч байж байгаа Багийн төвүүд зөндөө байж байна шүү дээ. Төрийнхөө үйлчилгээг чанартай авч чаддаггүй. Эдгээрийг яг энэ тосгоныхоо энэ зохицуулалт дээр яаж цаашдаа оруулъя гэж бодож байгаа юм. Хэлэлцүүлгийн явцад гишүүдийн ажлын хэсгийн өгсөн саналаар оруулаад явах юм уу гэсэн ийм товчхон асуулт байна.

Г.Занданшатар: 4. Пүрэвийн Сайнзориг орлогч дарга.

П.Сайнзориг: Аубакир гишүүний асуултад хариулъя. Бид хэд бас тосгон гэдэг энэ статус бол бас Монгол Улсын Үндсэн хууль дээр дурдагдсан тодорхой бас ийм суурин газар байж байгаа. Яг таны хэлж байгаа шиг бас ийм нөхцөл байдлууд бол өнгөрсөн 30-аад жилд явсан байна. Хүн ам, суурьшил нэмэгдээд байгаа мөртөө яг тосгон дээр бас төрийн үйлчилгээ болон инженерингийн дэд бүтцийн үйлчилгээнүүд бараг байхгүй. Төсөвгүй. Иргэдийн асуудал шийдэгддэггүй, хамгийн ойр байгаа сум руугаа явж бусад үйлчилгээгээ авдаг ийм нөхцөл байдалтай ингээд байж байгаа.

Тэгэхээр энэ хуулиар бол үндсэндээ таны ярьж байгаа тэр Улаан хус сум дээрх Хөх хөтөл багийг жишээ нь тосгон болгох бололцоотой. Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийн дагуу бол тосгоны эдэлбэр газрын зааг өөрчлөх асуудлыг бол тухайн ИТХ-ын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэж байгаа юм.

Тэгэхээр магадгүй Баян-Өлгий аймгийн маань ИТХ бас тодорхой шийдвэрээ гаргаад Засгийн газар руу уламжлах юм бол Хөх хөтөл багийг тосгон гэдэг статусаар болгож хөгжүүлэх бүрэн бололцоо байгаад байна. Тэгэхээр энэ хүрээндээ бид хэд асуудалд хандана.

2 дугаарт, тосгон гэдэг статусыг авангуутаа зөвхөн хот нийтийн хөгжил ажиллагаанаас гадна тэр Улаан хус багийн сумын зарим чиг үүргийг шилжүүлж өгөх асуудал бас шийдэгдэх боломжтой, гэрээгээр. Өөрөөр хэлэх юм бол бас энэ хуулийг дагаад нэгжсийн хууль болон энэ холбогдох хуулиудад өөрчлөлт орж байгаа. Үндсэн хуулийнхаа тэр 57.2-т заасны дагуу яг байнгын төрийн ийм ийм үйлчилгээнүүдийг тосгон дээр бас ийм нэгжүүд ажиллаж байж үзүүлж болно гээд энэ асуудлыг тосгоны захирагчид бас гэрээгээр шилжүүлээд,

үүнтэйгээ холбоотой төсөв, хүний нөөцийн эрх мэдэл бас шилжиж очих бүрэн боломж бас энэ хуулиар нээгдэж байгаа.

Тэгэхээр та бас хуулийн төслүүдийг сайжруулах саналуудыг бид нар бол татгалзахгүй, хамтраад ажиллаж болж байна. Ер нь бол зохицуулалтын хувьд ингэж орсон байгаа гэдэг зүйлийг товчхон хариулахад ийм байна.

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна.

Б.Энх-Амгалан: Монгол Улсын Үндсэн хууль дээр нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд, аймаг нь суманд, сум нь багт хуваагдана гэсэн ийм засаг захиргааны нэгжийн хуваарилалтын ийм юм байгаа. Тэгээд 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр энэ 57.2-оор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлага, хот, тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Түүнийг Засгийн газар өргөн барьснаар Улсын Их Хурал шийдвэрлэнэ л гэж байгаа юм л даа. Түүнээс дүүргийг хот болгоно, хороог тосгон болгоно гэдэг юм бол байхгүй. Тэгэхээр энэ маань цаашаа хэлэлцэгдээд явахаараа Үндсэн хууль зөрчсөн ийм асуудал болоод Цэц дээр оччих вий гэсэн ийм болгоомжлол байна.

Тэгээд батлагдахгүй ингээд зогсоод, тэгээд дүүргээ хот болгочихсон чинь нийслэл нь дүүрэг, дүүрэг нь хороонд хуваагдана гэдэг. Энэ нь нөгөө нэгжийн ч юм алга болсон байна гээд. Ингээд Үндсэн хууль зөрчсөн зөрчил рүү явчих вий гэж нэг санаа зовж байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариу хэлээч.

2 дахь нь, таны саяын хэлдгээр хүн ам нь нэмэгдэж байгаа бол нэгж нь ч нэмэгдэх ёстой, нэгж нь нэмэгдэж байгаа бол төсөв нь ч нэмэгдэх ёстой, төсөв нь нэмэгдэж байгаа бол тосгоны статус хотын статус руу явж болно гэсэн юм

ярьж байна шүү дээ, тийм ээ. Гэтэл Улаанбаатар хот Монгол Улсын нийт газар нутгийн 0,3 хувь дээр байж байгаа юм. Хүн амынх нь 50 хувь ирээд суучихсан байж байгаа юм. Үйлдвэрлэл үйлчилгээнийх нь 85 хувь, их, дээд сургуулийнх нь 91 хувь, тэгээд хагас сая машинтай. Тэгээд агаарын бохирдол тэр л түгжрэл, усны бохирдол, хөрсний бохирдол гээд л ингээд л ерөөсөө их олон асуудалтай байна л даа.

Тэгэхээр ингээд нөгөөдүүлийгээ ингээд томруулаад хот болгочихоор энэ асуудал шийдэгдэнэ гэж би бол харахгүй байгаа байхгүй юу. Улаанбаатар хотыг задлах бодлого явуулж байж, хөдөөг дэмжсэн бодлого явуулж байж, зах хязгаараа эзэнтэй байлгаж байж л Монгол Улс бүрэн бүтэн байна л гэж харж байгаа юм. Түүнээс төсвийг нь нэмээд л, нэгжийг нь нэмээд л, нэрийг нь өөрчлөөд л ингээд л томруулаад байхаар энэ асуудал шийдчихнэ гэж би бодохгүй байна л даа.

Тэгэхээр үүнийг жишээлбэл хуулийн төсөл дээр яаж шийдэх гэж байгаа юм. Энэ ингэж хийгдсэнээрээ энэ чинь Улаанбаатар хот задрах бодлого явагдаад тэгээд цаашидаа ингээд дагуул хотууддаа очих гэсэн баталгаа нь юу байгаа юм. Одоо дагалдаж орж ирж байгаа 34 хуулиа харах юм бол бүгд л төвлөрүүлэх бодлого байгаа байхгүй юу. Төв рүүгээ татан төвлөрүүлэх, нийслэл рүүгээ татан төвлөрүүлэх, тэгээд тэндээсээ зарах.

Тэгэхээр энэ маань яг ингээд нөгөө бүс нутгийн хөгжлийн асуудал, зах хязгаарыг эзэнтэй байлгах асуудал, Монголчууд тарж байж байж ингэж газар нутгаа бүрэн бүтэн байлгах асуудал маань юу болж байна. Энэ 0,3 хувь дээрээ л энэ Богд уулынхаа урд хойно гараад л эсвэл Чингэлтэй уулынхаа урд хойно гараад л, эсвэл Налайх, Багахангай руугаа ингээд өргөжчихөөр л энэ бүх асуудал шийдэгдчихнэ гэвэл бас өрөөсгөл болох гээд байна л даа. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Г.Занданиатар: Пүрэвийн Сайнзориг Нийслэлийн Засаг даргын орлогч.

П.Сайнзориг: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Бид дүүргийг хот болгож байгаа асуудал байхгүй. Дүүргийн буюу энэ засаг захиргааны нэгж дээр хот байгуулж байгаа. Энэ хотдоо дүүргийн хэрэгжүүлж байсан чиг үүргүүдийг шилжүүлж гэж байгаа. Жишээ нь автоматаар СХД юм уу, БЗД-ийг 3, 3 хотод хуваагаад байгаа юм байхгүй. Магадгүй СХД-ийн хамаарч байсан 1 дүгээр хорооллын зарим хэсэг буюу арын дэнж хэсэг, магадгүй БГД-т харьяалагдаж байсан тэр төмөр замын Хархорин захын орчим хэсэг энэ тэрийг ч юм уу нийлүүлээд бид хэд яг л Өнөр хот гээд байгуулж байгаа. Энэ ч гэсэн бие биедээ таталцаж оришход хамгийн их хялбар бөгөөд түүн дээрээс төрийн үйлчилгээг жигд авах бололцоотой. Жишээ нь яг замын урд, хойноо гараад явчихаар сургуулиудын харьяалал өөрчлөгдчихөж байгаа юм. Яг 1 дүгээр хороолол дээрээ сургуулийн үйлчилгээ байгаад байдаг. Замын урд талд гарангуут Хархорин буюу БГД-тээ явчихаар цаашаа Сонсголон руу хүүхдээ зөөх, эсвэл БГД-ийн өөр хэсэг рүү хүүхдээ зөөх ийм чиглэл рүү ингээд явчхаж байгаа юм.

Тэгэхээр энэ дээрээсээ нөгөө иргэд маань төрийн үйлчилгээг авах бололцоо буюу сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн асуудал нь хүртэл хязгаарлагдмал болоод ирж байгаа ийм асуудлууд байгаа. Тэгэхээр энэ зүгээр би нэг л жишээ авахад ийм байгаа. Тэгэхээр дүүргүүд бол хэвээрээ үлдэнэ. Тэгэхдээ энэ дүүргүүдийн үндсэн чиг үүргүүдийн нэг хот руу шилжүүлэх байдалтай явах ийм байдалтай байгаа шүү гэдэг зүйлийг бас танд хэлье.

2 дугаарт, яах вэ, та бас их чухал асуудал хөндөж байна. Энэ Улаанбаатарын энэ асуудлыг зөвхөн 14 хот болгосноор шийдэгдэж байна уу

гэдэг. Илүү их хөдөө, орон нутгаа дэмжиж бас энэ чиглэлийнхээ сэргэлтийн асуудлыг анхаарч байж асуудал шийдэгдэх юм биш биз гээд. Энэтэй бол яг тантай санал нэг байна. Тийм ч учраас энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар бас энэ хөдөө, орон нутгуудын зарим томоохон суурин газрууд, энэ төвлөрлийг хот болгох, үүнийгээ дагасан төрийн болон хот нийтийн үйлчилгээ. Хот гэдэг бол цэвэр бас хүн амын төвлөрөл, дээрээс нь ажлын байр олох боломжтой, амьдралын чанараа дээшлүүлэх боломжтой. Үүнийгээ дагасан сургууль, цэцэрлэгийн ахисан түвшний үйлчилгээ авах. Магадгүй хөдөө, орон нутаг талдаа ч гэсэн татварын бааз сууриудыг нэмэгдүүлэх ч гэдэг юм уу. Ийм өргөн боломж бол бүрдэнэ гэж харж байгаа.

Нөгөө талдаа таны тэр бас алс хязгаар нутгууд бас эзэнгүйдэх ч гэдэг юм уу ийм зүйлүүд рүү бас анхаарах ёстой гэдэгтэй бол санал нэг байна. Тийм ч учраас бид нар бас энэ боомт хотууд буюу энэ хилийн орчмын суурин газруудыг цаашидаа хот, тосгоны статусаар бас хөгжүүлж гэдэг энэ зүйлүүдийг бас барьж байна. Энэ чиглэлдээ ч бас байж байж бас тэнд төрийн үйлчилгээ орж байж, тэнд амьдрах тэр юу гэдэг юм хүсэл зоригийг бас өгөх ёстой юм байна лээ. Түүнээс биш тэнд төрийн үйлчилгээ байхгүй учраас доор хаяж 50, 60 км ч байдаг юм уу, 100 км давхиж дараагийн сумд орж үйлчилгээ авдаг ийм зүйлүүд байхаар бас иргэд маань өнөөдөр бас амьдралын чанарыг хайж, хот, суурин газар луу явж байгаа энэ хөдөлгөөнийг бас хязгаарлаж чадах юм болов уу гэж бид нар үзэж байгаа. Тэгэхээр зүгээр баталгаа ... /минут дуусав/

Г.Занданиатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Энх-Амгалан: Санаа нь бол зөв өв. Тэгэхдээ яг ингээд харахаар зэрэг энэ 34 дагалдсан хууль чинь бол төсөв төвлөрүүлэх, нэгжийн төвлөрлийг бий болгох, хүн амыг төвлөрүүлэх нэг ийм

бодлого руугаа л яваад байна л даа. Тэгээд ингэхээр зэрэг хаана төсөв байна, хаана төвлөрөл байна, хаана хөгжил байна, хаана сургууль, цэцэрлэг, эмнэлэг, тэр төрийн үйлчилгээ байна, тэр лүүгээ л хүн татагдана. Тийм учраас энэ таталцал чинь арилахгүй, яваад л байх байхгүй юу. Тэнд үнэхээр Улаанбаатарт үзүүлдэг шиг эмнэлгийн үйлчилгээ тэр хөдөө хязгаарт байж байгаа бол хүн ирэхгүй л дээ. Тэгээд цалин пүнлүү нь өндөр, бүсийн нэмэгдэл энэ тэртэй байж байгаа бол. Төвлөрөл нь энд байгаад байх тусам л наашаа эргэж дуудаад байгаатай л яг адилхан ийм юм болох учраас үүнийгээ л цаашид нь их сайн анхаараарай. Дараа дараагийн яг эхний хэлэлцүүлгийн үедээ нэлээн сайн анхаарч цааш нь явахгүй бол болохгүй шүү л гэдэг ... /минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн алга байна. Хойшлууллаа.

Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууя.

Б.Баттөмөр: Нийслэл хотод асар их хэмжээний тулгамдсан асуудлууд тулгарсан. Магадгүй энэ хүмүүс хамгийн хүнд үед ажиллаж байгаа ч хүмүүс байж магадгүй байх гэж ингэж бодож байна. Нийслэлийн маш их олон асуудлууд байна шүү дээ. Утаа, түгжрэл, хөрс, агаарын бохирдол, өвчлөл, үер, ер нь тоолохын арга байхгүй л дээ, ийм л юм тулгарчихсан. Энэ бол юутай холбоотой вэ гэхээр энэ бодлогоо нийслэл хотыг хөгжүүлэх хэтийн бодлогыг ерөөсөө ярьж байгаагүй. Энэтэй холбогдуулаад ийм асуудлууд тулгарсан. Үүнийг шийдэхийн тулд л энэ асуудлуудыг оруулж ирж байна гэж ойлгож байгаа юм. Үүнийг бол сайн уншиж танилцаагүй байна. Өнөөдөр энэ ширээн дээр тавьсан байгаа. Үүнийг сайн уншиж танилцъя гэж бодож байгаа юм. 1 асуулт байна.

Энд эхний асуулт бол юу гэхээр энэ Хот, тосгоны эрх зүйн хууль, Аэро сити хот гээд. Ингээд үүнтэй эдийн засгийн тооцоо хийгдсэн үү? Энэ яагаад ингэж

байна гэхээр аливаа зүйл эдийн засгаар баталгаажиж байж амь сүнстэй болдог. Манай хийгдэж байгаа ажлууд маань яагаад амь сүнсгүй байна гэхээр эдийн засгийн тооцоо, судалгаа, санхүүжилт нь байдаггүй. Үүнийг 1 дүгээрт, хэлж өгөөч гэж.

2 дугаарт, нь энэ хилийн цэс тогтоох асуудлыг бол Засгийн газар санаачлаад Улсын Их Хуралд оруулж тогтоодог. Монгол даяар тэр чигээрээ хилийн цэсийн маргаан. Тэгээд энэ цэс тогтоох асуудлууд яаж орж ирэх вэ? Үүнийг хэзээ шийдэх вэ? Тухайлбал энэ манай Дархан-Уул аймгийн зүүн талаараа Сэлэнгийн Ерөө сумтай, хойд талаараа Сэлэнгийн Номгон, Хөтөл гээд тэр чигээрээ, ард иргэд зарим ард иргэд нь тэдний нутагт амьдардаг. Амьдралын шаардлагаар зарим нэг гэр бүлийн эхнэр, нөхөр 2, 2 газар бүртгэлтэй явдаг.

Тийм учраас үүнийг та нар энэ цэсийг яаж тогтоож хэзээ орж ирэх юм бэ? Жижиглэх тутам асуудал улам ихэсдэг шүү. Үүнийг бас тооцох ёстой гэж бодож байна.

Дараа нь юу гэхээр энэ сая ингээд хот, хот улсын чанартай хот, орон нутгийн чанартай хот гээд ингээд явчихлаа. Манай Дархан-Уул аймаг 4 сумтай. Дархан сум Дархан хот болоод явчихна. Шарын гол орон нутгийн тэр дагуул хот орон нутгийн хот болъё. Хонгор сум гэж байдаг 6800 хүнтэй, 253 мянган га газартай нутагтай, өнөөдөр сум байгаа. Одоо цаашидаа юу болох юм бэ. Сая тэр яриан дунд нэг баг болно гээд явчав уу, үгүй юу, тосгон болно гээд явчав уу, үгүй юу. Тосгод маань сум болно гэж явдаг. Тэгэхээр байсан сумыг бол тосгон болгож болохгүй байх.

2 дахь нь, энэ Хонгор Орхон сум гэж байдаг. Монголын газар тариалан, юу ногооны ихэнхийг нь үйлдвэрлэдэг, тарьдаг, хангадаг. Тэгээд 3500 хүнтэй, 47 мянган га газартай. Энэ 2 сумын та нар юуг төлөвлөж байгаа вэ? Тосгон болох юм уу? Арай үгүй байлгүй дээ. Юу гэж

оруулж ирж байгаа вэ? Ер нь энэ газар нутгийн энэ цэсийг их сайн шийдэхгүй бол тэр чигээрээ Дархан Сэлэнгэтэй, Орхон Булгантай, Говьсүмбэр Дорноговьтой бүх газар маргаан. Тэгээд үүнийг та нар юу гэж харж ингэж оруулж ирж байгаа вэ? Ийм асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: Пүрэвийн Сайнзориг.

П.Сайнзориг: Ерөнхийдөө бас мэдээж энэ хот, сууринг байгуулах гол нөхцөл үйл байдлууд дээр бас холбогдох тооцоо, судалгаанууд бол хийгдэж байгаа. Тухайлбал, Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалттай холбоотой ажлын алба ажиллаж байгаа. Энэ дээр хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө Засгийн газраар батлагдсан. Энэ хүрээндээ бас тодорхой хөрөнгө оруулалтууд улсын төсвөөс хийгдэж байна. 160-аад тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтууд явж байгаа.

Одоо дулааны станц болон цэвэрлэх байгууламжийн нэг тодорхой асуудлууд бол шийдэгдэхээр байгаа. Эрчим хүчний асуудал бол цаанаас Бөөрөлжүүтээс бас Сэргэлэн сумын дэд станц руу ингээд холбогдох ажил ингээд хийгдээд явж байна гэх зэрэг юу гэдэг юм тодорхой хотыг байгуулах бүтээн байгуулалттай холбоотой тооцоо, судалгаанууд бол хийгдээд явж байгаа. Энэ дээр бас Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хууль дээр илүү тодруулж ярьж болох байх.

Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар бол бид нар энэ засаг захиргааны шинэчлэлийн өөрчлөлтийг бол хөндөөгүй. Засаг захиргаа, нутаг нэгжийн хоорондох газар нутгийн хилийн цэсийн маргааныг асуудлыг бол бид шийдэх байдлаар орж ирээгүй. Үүнийг бол тусдаа Газрын багц хуультай хамт орж ирж шийдэгдэх ёстой. Өөрөөр хэлэх юм бол энэ газар, эргээд нэгж хоорондын үүсэж байгаа энэ хилийн цэсийн маргааныг хэрхэн яаж шийдэх вэ? Магадгүй аймаг дотроо 1 аймгийн 2 сумын хилийн цэсийн

маргааныг уг нь бол Засгийн газрын түвшинд ч гэдэг юм уу. Ингээд жоохон хялбар шийдэх ёстой юм байна лээ. Одоо бол аль аль аймгийнх нь саналыг үндэслэн Засгийн газраар дамжуулж Улсын Их Хурал шийднэ ээ гэгчхээр аль аль аймаг ч гэдэг юм уу тухайн нэгжүүд нь юу гэдэг юм дурамжхан гэдэг юм уу бас нэгдсэн санал, дүгнэлт хүрдэггүй учраас асуудал бол шийдэгдэхгүй байгаа юм.

Тэгэхээр бид хэд нэгдмэл улс л юм бол бас энэ асуудлыг тодорхой шийдэх тэр механизмыг бий болгох ёстой гэдэг дээр бол тантай санал нэг байна.

Хот, тосгон бол хилийн зааг буюу эдэлбэр газар л байгаа юм. Энэ нь тодорхой засаг даргын нэгж дээр байж болно. Хэд хэдэн засаг захиргааны нэгжийг дамнуулан байгуулах асуудал байж болох юм.

Хилийн цэсийн маргаантай холбоотой асуудал дээр би ийм тайлбар өгмөөр байна. Ер нь бол Засгийн газраас Газрын багц хуулийг өргөн барихдаа нэгдсэн байдлаар шийднэ.

Дархан-Уул аймгийн Хонгор сум, Орхон сум бол хотын хороо болж хөгжинө. Өөрөөр хэлэх юм бол статусын хувьд бол таны ярьж байгаа тэр сумын зүйлээс бол статус буухгүй, илүү их чиг үүрэгтэй, цаашидаа мэдээж ХАА-д суурилсан Дархан-Уул аймгийн юу гэдэг юм онцлогт ч байгаа, эдийн засгийн боломж нь бол мэдээж аж үйлдвэр ХАА-н салбар байгаа. Тэр дундаа эрчимжсэн МАА, газар тариалангийн асуудал байж байгаа. Үүнийгээ дагасан татварын бодлогууд ч гэсэн бүсийн хөгжлийг дэмжих татварын бодлогыг бас Сангийн яаман дээр манай бас судалгаанууд хийж байгаа. Өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар бас бүсийн татварын бодлогын асуудлуудыг бас ярилцсан.

Тэгээд ер нь нөгөө статусын хувьд бол мэдээж иргэдийнхээ тэр юу гэдэг юм эрх зүйн байдал гэдэг юм уу, амьдарч байгаа чанарыг бууруулахгүй байх,

төрийн үйлчилгээг авах энэ чанар, хүртээмжийг дордуулахгүй байх үүднээс хандана гэдэг зүйлийг хэлье. Тэгээд Дархан-Уул аймаг маань газар нутгийнхаа хэмжээгээр Дархан хот болно.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулъя. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ эдийн засгийн тооцоо, судалгаа энэ төсөлтэйгөө хамт явах ёстой шүү. Миний бие ажлын хэсэгт орж ажиллана. Тэгээд энэ эдийн засгийн тооцоонуудыг бол та нараас бас нэхнэ. Тооцоонуудаа та нар сайн хийгээрэй. Эдийн засгийн тооцоогүйгээр мөрөөдлийн юм бол бас ярьж болохгүй шүү дээ. Эдийн засгаар баталгаажсан байх ёстой. Яаж яаж с санхүүжүүлэх юм, гаднын зээл тусламжаар юу хийх юм, өөрсдөө төсвөөр юу хийх юм, орон нутагт юу хийх боломж байгаа юм, хувийн хэвшилээр юу хийлгэх үү гээд маш нарийн тооцоо байх ёстой.

Дараагийн асуудал энэ Монголд нэг тулгамдсан асуудал энэ газар нутгийн маргааны асуудал байгаа юм. Үүнийгээ энэтэйгээ хамт оруулж ирэхгүй бол энэ чинь бас их маргаантай байгаа шүү. Асар их, түрүүн ярьж байна шүү дээ. Нэг гэр бүлийн 2 хүн, 2 өөр газар амьдралын шаардлагаар иргэншилтэй болчихсон ийм юм. Одоо манай Дархан-Уул аймгийн Хонгор сумын улсууд нэг хэсэг нь Хонгорт, нэг нь Сэлэнгийн Баруунхараад. Ийм л байдал ... /минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Хариулах хүнгүй байгаад байна л даа.

4, Пүрэвийн Сайнзориг.

П.Сайнзориг: Баттөмөр гишүүний санаа зовж байгаа, анхаарах ёстой гэдэг дээр бид бүрэн ойлгож байгаа. Мэдээж энэ тодорхой хэмжээний бас мега, хот гэдэг бол үндсэндээ бизнес

төсөл болчихоод байгаа. Бусад орчин үеийн энэ бусад улс орнуудад. Эргээд энэ хөрөнгө оруулагч болон тэнд ажиллаж амьдрах хүмүүстэйгээ хамтран энэ бас энэ асуудлыг шийддэг, хөрөнгөө босгодог, засаглал нь ил тод байж байж энэ оруулж ирсэн хөрөнгө нь бас үр өгөөжөө өгдөг, ажлын байр бий болгодог, татварын бааз суурийг нэмэгдүүлдэг ийм зүйл болсон байна.

Тэгэхээр бид хэд энэ дээр бол анхааръя. Монгол Улсын Засгийн газар Даваасүрэн сайд сууж байна. Ер нь бол БХБЯ-наас хэд хэдэн мега, Шинэ Хархорин, Шинэ Зуунмод хот гээд бид хэдийг бас бүрэн бодлогоор дэмжиж ажиллаж байгаа. Ийм хэд хэдэн ажлууд явж байгаа. Энэ дээр бас тодорхой бүр Батбаяр даргаар ахлуулсан жишээ нь Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын ажлын алба ажиллаж байгаа. Энэ дээр тооцоо судалгаатай ингээд явж байгаа.

Ер нь газар нутгийн тэр хилийн цэсийн маргааныг шийдэх ёстой гэдэг зүйл дээр бол бүрэн санал нэг байна. Үүнийг бол Газрын багц зүйлтэй л хамтад нь нэг мөр шийдэх асуудлыг бас анхаарах ёстой юм болов уу гэж бодож байгаа. Бид нар бас цаашидаа бас энэ асуудлыг анхаараад явъя гэж бодож байна.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Хот, тосгоны эрх зүйн байдалтай холбоотой асуулт асууж, үг хэлэхээсээ өмнө бас Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийн мэндийг үзэг 1-т нөхдөдөө хүргэе гэж бодож байна. Тэгээд нөгөө Шүгэл үлээгчийн тухай хуулийн төслийн 9.9, 9.10 дээр бид нар хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн ажилтан нь бол нөгөө эх сурвалжаа нууцлах гэдэг заалтыг оруулахаар ажиллаж байгаа гэдгийг бас дуулгачихъя гэж бодож байна.

Тэгээд энэ хуулийг цогцоор нь оруулж ирээд Улаанбаатар хотод нэг бүр энэ эрс өөрчлөлт хийхгүй бол болохгүй

байна гэдэг энэ үзэл баримтлалыг бол тууштай дэмжиж байгаа, үнэн. Улсын Их Хурал төсөв хэлэлцэх болгонд яг Улаанбаатар хотын өмнө тулгарч байгаа энэ нийслэл Улаанбаатар хотын бараг сая 600 мянган хүний өмнө тулгарч байгаа хүндрэлтэй асуудал асар их байх. Уг нь энэ асуудлаа эхлээд шийдэх, хөрөнгө мөнгийг хангалттай тусгах байтал бид нар ихэнх нь орон нутаг руу юм уу эсвэл ингээд явчихдаг л даа. Сая л гэхэд бас зарим орон нутгийн гишүүд маань сумдыг яах юм бэ гээд л ингээд л барьцаад эхэлдэг. Гэтэл өөрсдөө Улаанбаатар хотод амьдарч байна. Улаан Улаанбаатар хотын хөрс, агаарын бохирдол үгүй ээ, ямар түвшинд хүрчээ, өнөөдөр амьдрахад хэцүү болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг шийдэх нь туйлын зөв, санал нэг байна. Харин энэ хууль өөрөө амьдралд хэрэгжих л хууль байх ёстой шүү. Тэгэхгүй бол бас тэгээд байна л даа. ХЗДХЯ-ны мундаг хуульчид маань ирээд баахан хууль боловсруулаад ороод ирлээ. Гэтэл энэ чинь хотын амьдрал, хотын ажил бол аж ахуйн ажил.

Тийм учраас аж ахуйг их сайн мэдэх, аж ахуй энэ яг бодит амьдрал дээр хэрэгжих тийм заалттай тийм бодит хөрстэй хууль өөрөө байх ёстой. Энэ 1986 онд боловсруулсан ТЭЗҮ-ээр өнөөдөр сая 600 гаруй мянган хүн амтай болчихсон Улаанбаатар хот явж байгаа учраас бид угаасаа зайлшгүй өөрчлөх хэрэгтэй гэдэг нь тодорхой байна л даа.

Тиймээс саяын хэлээд байгаа эдийн засгийн тооцоо, судалгаа, ТЭЗҮ-ээ маш зөв боловсруулаад уг нь яг энэтэйгээ цуг ийм ийм бодлогоор ингэж хөгжих юм, 53 зөвлөл нь ийм байх юм. Чингэлтэй хот, Сэлбэ хот гээд тэглээ гэхэд энэ хот нь дүүрэг дотроо ийм байрилаар байгаад, тэнд амьдарч байгаа хүн бүхэн Үндсэн хуулиар олгогдсон жигд төрийн үйлчилгээг ингэж авах юм. Тэгэхийн тулд энэ дэд бүтэц нь ингэж бүтэх юм. Эмнэлэг нь ингэх юм, сургууль нь ингэж ингэж явна гээд. Нэг тийм цогц баримт харахаар хийхгүй бол бид нар бас нөгөө яг

хуулийн хэрэглэлээр яриад байвал хүмүүс зарим нь ойлгохгүй байна л даа. Одоо над руу ингээд л бичиж, нөгөө чуулганыг үзсэн. Түрүүн ТББХ-г үзсэн манай ЧД-ийн Цэрэнбат, Уянга гэдэг хүмүүсээс ийм чухал хууль орж ирж байхад хэлэлцүүлэг яагаад явахгүй байгаа юм бэ, яагаад бидний хотын иргэдийн саналыг авахгүй байгаа юм бэ гээд л бичиж эхэлж байна. Үгүй ээ, хэлэлцүүлэг явж байгаа, саналыг нь авч байгаа гэдгийг бол хэллээ. Гэхдээ ингэж байна л даа. Тэгвэл төвийг нүүлгэчихлээ гэхэд энэ 40 мянгат юм уу, энэ хотын төвийн байшингуудад амьдарч байгаа хүмүүст маш хүндрэлтэй нэг зүйл тулгардаг болчихсон. Юу вэ гэхээр тэнд амьдардаг хүмүүс машинаа тавих ямар ч газар байхгүй. Харин тэнд энэ дүүрэгт ажиллаж байгаа хэр нь өөр дүүрэгт амьдардаг хүмүүсийн машин өдөржингөө тэнд байдаг. Тэнд хүүхэд тоглох, явган хүн зорчих ямар ч бололцоо байхгүй. Жинхэнэ түгжрэл гэдэг чинь тэнд бий болчихсон байгаа. Хамгийн хүндрэлтэй асуудал.

Тэгвэл энэ хууль хэрэгжээд эхлэхээр энэ төвлөрөл байхгүй болох уу. Яаж энэ зогсоолыг нь жишээлбэл зохицуулах юм. Энэ түрүүн хэллээ Ерөнхий сайдын уг нь 86 га газарт эрх мэдлийн төвлөрөл болчихсон гэж. Энэ бол туйлын үнэн. Тэгэхээр ингээд нүүлгээд нүүлгээд явчихлаа гэсэн хэр нь дүүрэг дотроо хот, хот дотроо хот бий болно гээд ингээд ярихад нөгөө түгжрэлийг бид яаж шийдэх вэ? Энэ төрийн байгууллагууд нүүж явчихлаа гэхэд энд оршин сууж байгаа 40 мянгат, 50 мянгатад юм уу, энэ ар талын МУИС-ийн их сургуулийн байр гэдэг шүү дээ. Тэнд амьдарч байгаа хүмүүс бас нүүх үү. Эсвэл тэр хүмүүс тэндээ амьдрахад тэр хүмүүсийн амьдарч байгаа зогсоол, тэр машин энэ тэр нь яах вэ тийм ээ. Энэ нөгөө орон зайн мэдрэмжтэй төлөвлөлт гэдэг манай Улаанбаатар хотын хувьд байхгүй болчихсоны хар гай яг энэ бүхэн үүсчихсэн л дээ.

Тэгэхээр цогцоор нь, бодлогоор нь оруулж ирж байгаа нь зөв. Харин саяын

энэ зүйлүүдийг яаж шийдэх вэ. Энэ дагуу хэлэлцүүлгүүд явах уу. Энэ асуултаар эхлээд авчихъя гэж бодож байна. ТЭЗҮ нь яг бэлэн болчихсон байна уу?

Г.Занданшатар: Пүрэвийн Сайнзориг.

П.Сайнзориг: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Маши чухал асуудлуудыг асууж байна. Бид бол уг асуудлаар бас нэлээдгүй хэлэлцүүлгийг бол явж байгаа. Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль бас өнөөдөр яригдаж байгаа асуудал биш нэлээн урт хугацаанд яригдаж байгаа. Тогтохсүрэн даргаар ахлуулсан ажлын хэсэг бас энэ хууль дээр нэлээдгүй бас ажилласан. Бид бас энэ хуулийг бас суурь болгож авч явсан. Үүгээр бас олон хэлэлцүүлгүүд болсон байж байгаа.

2 дугаарт, сая Улаанбаатарын бүсчилсэн хөгжлийн форум болоход яг уг асуудлыг шийдсэн. Улаанбаатарын асуудлыг шийдэхийн тулд засаг захиргааны шинэчлэл буюу эрх мэдлийг задлах ёстой юм байна.

2 дугаарт, энэ дэд бүтцийн бүтээн байгуулалтыг төр, хувийн хэвшлийн хүрээнд шийдэх ёстой юм байна. Үнэ тарифыг либералчилж өгөх ёстой юм байна. Энэ том төслүүдийг хэрэгжүүлж байгаа компаниуд нь хөрөнгийн зах зээл дээр IPO гаргадаг нэг талдаа эрчим хүчээ хэрэглэдэг байхын дээр нөгөө компаниас үр өгөөж хүртдэг тэр тогтолцоог бүрдүүлэх ёстой юм байна.

3 дугаарт, ерөөсөө хот гэдэг зүйл дээр ажлын байр буюу энэ ажлын байр буюу үүнийгээ дагасан хотынхоо зарим чиг үүрэг асуудлуудыг шийдье гэж байгаа юм. Жишээ нь хүнсний хангамжийн асуудлыг бид нар Аэро сити хотыг байгуулах замаар бас Улаанбаатарчуудын хүнсний аюулгүй байдлыг шийдье. Шинэ Зуунмод хот бол тэр чигтээ ажил олгох хот байгаа. 80 мянган ажлын байр бий болгоно. Хотод төлөвлөх боломжгүй болчихоод байгаа

маши олон үйл ажиллагаануудыг Шинэ Зуунмод хот дээр бүтээн байгуулалт хийе. Энэ ч гэсэн Төв аймгийнхаа хөгжил цэцэглэлтэд бас нэлээн жинтэй хувь нэмэр оруулна гэсэн байдлаар ингээд асуудалд хандаж байгаа.

Тэгэхээр үүнийг бас мэдээж Улсын Их Хурал дээр хэлэлцэх эсэхээ шийдвэл бас хэлэлцүүлгүүд хийж болох байх. Үүнийг бол хийх нь зөв байх гэж бодож байна. Ер нь бол хэлэлцүүлгүүд бас тодорхой үе шаттайгаар нэлээдгүй бас хийгдэж явсан гэдэг зүйлийг бас хэлье.

Эргээд энэ түгжрэлийн асуудал ч гэдэг юм уу энэ Улаанбаатарын тулгамдсан асуудлуудыг шийдэх гарц байж чадах уу гэдэг дээр бол би чадна гэж үзнэ. Мэдээж өргөс авчихсан юм шиг нэг дор шийдэж чадахгүй ч гэсэн энэ олон зүйлийн суурь тавьж өгнө. Өнөөдөр албан ёсны хот статустай нэгхэн байгаа. Улаанбаатар. Ерөөсөө л энэ рүүгээ тэмүүлээд л явж байна. Энд л бүх зүйл байна гэдгийг амьдралын чанар хайж, үр хүүхдүүдээ нэг гайгүй сургуульд сургачихъя. Нэг ажлын байр олчихъё ч гэдэг юм уу ийм зүйлээр хот руу тэмүүлж байгаа юм.

Тэгэхээр бид хэд энэ бусад аймгуудын төвүүд болон томоохон уул уурхайн бүс нутгуудад Цогтцэций, Ханбогд ч гэдэг юм уу. Ингээд нэгэнт л суурьшлын бүс буюу хотын дайтай хүн амын төвлөрөл, зах зээл бий болчихоод байхад энэ статусыг нь өгч, энд хот нийтийн аж ахуйг, төрийн үйлчилгээгээ энэ ойртуулж өгье гэж байгаа юм. Энэ өнөөдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар гол шийдэх гэж байгаа юм бол 20 минутын хотын концепт. 20 минут дотроо төрийн үйлчилгээ болон хот нийтийн аж ахуйг авч чадах юм бол энэ түгжрэлийг шийдэх энэ бололцоо бүрдэнэ. Эргээд яг энэ 20 минутын хотыг бүрэн шийдэх зорилго бол энэ Чингэлтэй, СБД-ийн нутаг дэвсгэр дээр дамнан орших Сэлбэ хотын асуудал байгаа. Энэ Сэлбэ хотын ТЭЗҮ, зураг төсөв хийгдэж, үүнийг олон улсын зах зээл дээр хөрөнгө

мөнгө босгож, энэ бүтээн байгуулалтын ажлыг бас хийхээр ИТХ маань бол дэмжсэн. Одоо Засгийн газарт бид нар сангийн ... /минут дуусав/

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн 1 минут.

М.Оюунчимэг: Энэ хууль яг бодитоор хэрэгжээд амьд жишээ болох хамгийн анхны үзүүлэлт нь яг Сэлбэ дэд төвийг тойрсон Чингэлтэй, СБД-ийн одоо 14 мянган айл өрхийг орон сууцжуулах. Тэрийг дагаад нөгөө 20 минутын хот гэдэг одоо яриад байгаа энэ бүх зүйлийг хэрэгжүүлээд чадчихвал энэ цаашаа явж болох юм байна гэдэг бас нэг үзүүлэлт болно гэж харж байгаа шүү.

Нөгөө талаасаа энд өөрөө та бүхэн маань бас санхүүжилт бол асар их хэрэгтэй болно. Тийм ээ, эрчим хүчний асуудал, нөгөө газар доорх энэ олон цахилгааны асуудлууд, нүүлгэн шилжүүлэх эргээд үүнийгээ бариад бүтэх гээд.

Тэгэхээр эхлээд нөгөө хөрөнгө мөнгө, нөгөө саалиа бэлдэхээр саваа бэлд гэдэг шиг санхүүжилтийн асуудлуудаа бас зэрэгцээд механизмаа маш тодорхой болгохгүй бол чухал хэцүү. Өмнө нь та сая хэлээд байна. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль ороод л ирэхээр дандаа хөдөөгөөс сонгогдсон, хөдөө амьдарч байгаад хотод орж ирсэн гишүүд ахалж явчхаад, хотын амьдралын юм бүгд таг зогсчихдог юм. Тэгэхээр хот өөрөө авч явж байгаа нь маш зөв. Гэхдээ БХБЯ-тайгаа сайн ... /минут дуусав/

Г.Занданшатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг бол концепцын хувьд дэмжиж байна. Нийслэл Улаанбаатарын хувьд, ер нь Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх, улсын хөгжлийг нэмэгдүүлэхэд энэ хотын асуудлыг бол үнэхээр яаралтай шийдэх шаардлагатай. Тэгээд энэ хуулийн төсөлд

олон нийтийн улс төрийн оролцоо, тэр дотроо орон нутгийн удирдлагад иргэдийн оролцоог нэмэгдүүлж байгаа тодорхой заалтууд орж байгаа нь их сайшаалтай байна.

Тэгээд тухайлан энэ төслийн 50.2 дугаар зүйлийн манай хотын гэдэг юм уу, тухайн тосгоны иргэдийн тодорхой асуудлаар иргэдийн санал хураалт явуулах эрх зүйн хэм хэмжээг оруулсан байна л даа. Тэгээд хүн амынхаа тооноос хамаараад тодорхой иргэдийн гарын үсэг бүхий асуудлаар санал хураалт явуулах юм байна. Тэгэхээр энэ хотын гэдэг юм уу, тухайн тосгоны иргэдийн энэ санал асуулгын үр дүн яг эрх зүйн ямар үр дүн байх ёстой, байх вэ? Жишээлбэл тодорхой асуудлаар тухайн санал асуулгын олонхоор шийд гарлаа. Энэ маань эцэслэсэн буюу эцсийн шийдвэр байх юм уу, эсвэл хотын зөвлөл юм уу, эсвэл хотын захирагч нь тухайн иргэдийн санал асуулгын дүнг дахин хэлэлцээж үзэх үү гэдгийг тодруулах шаардлагатай байна.

Ер нь бол энэ нутгийн удирдлага дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлж, аливаа асуудлаар иргэдийн саналыг авч байгаа нь асар тийм чухал зүйл байгаа.

2 дахь асуулт нь, энэ хотууд бол ер нь эдэлбэр газартай байна гэж байгаа. Энэ бол манай нийслэл Улаанбаатарын хувьд маш чухал асуудал байгаа. Нийслэлээс сонгогдсон гишүүд бидний хувьд жишээлбэл тодорхой бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт хийх гэхэд яг нийтийн эзэмшлийн газар олддоггүй. Тэгэхээр Улаанбаатар хотын хувьд эдэлбэр газрын маань хэмжээг хэр нэмэгдүүлэх боломжтой байгаа вэ? Үүнийг энэ хуулийн төслөөр гэдэг юм уу, ер нь энэ дээр ямар эрх зүйн боломж юунуудыг гаргаж өгч байгаа вэ?

Дээр нь дахиад нөгөө тодорхой хот болж байгаа орон нутгийн чанартай, улсын чанартай энэ хотуудын хувьд бол жишээлбэл өөр аймгийн гэдэг юм уу, өөр аймгийн сумын нутаг дээр байгаа хотууд

жишээлбэл, Эрдэнэт хот байна. Дархан хот ч гэдэг юм уу. Эдгээрийн газар нутаг, эдэлбэр газрын хэмжээг хэрхэн нэмэгдүүлэх вэ? Тухайлбал, нөгөө тухайн сум гэдэг юм уу, эсвэл тухайн аймагтай нь зөвшилцөх юм уу, эсвэл шаардлагатай тохиолдолд тухайн сумыг татан буулгаад, тэр хотын эдэлбэр газар луу оруулах уу. Энэ тал дээр ямар зохицуулалтууд гарах вэ гэдгийг асуумаар байна.

Г.Занданшатар: Пүрэвийн Сайнзориг.

П.Сайнзориг: Бас энэ удаагийн Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиас төрийн төлөөлөл гэх үү, давамгайлсан Засаг дарга бас тухайн коммунитыг удирдахаасаа илүүтэйгээр иргэдээс сонгосон захирагч бас иргэдээ төлөөлдөг, асуудлыг шийддэг, төрийн хууль тогтоомжийг бас тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлдэг ийм концепц руу шилжиж байгаа. Өөрөөр хэлэх юм бол, иргэдэд тэр улс төрийн эрхийг нь бас аваачиж өгч байна гэсэн үг.

Мөн тодорхой асуудлаар иргэдийн дунд бас зөвлөлийн санаачилгаар, иргэдийн хүсэлтээр бас санал асуулгыг явуулья гэж байгаа. Нэгдсэн энэ шийдвэрт хүрвэл тухайн асуудал нь шийдвэр болж, асуудлаа шийддэг ийм зүйлүүд байгаа. Жишээ нь тодорхой хотын хөрөнгөөр тоглоомын талбай санхүүжүүлэх, эсвэл ногоон байгууламжийг нэмэгдүүлж барих ч гэдэг юм уу. Ийм тодорхой шийдлүүдээр иргэд маань өөрөө асуудлаа шийдвэрлэх энэ бололцоог нь бас тодорхой түвшинд өгч байгаа гэдэг зүйлийг хэлье.

Энэ удаагийн Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль болон бусад хуулиар Улаанбаатар хотын эдэлбэр газар гэдэг юм уу, Улаанбаатарын хотын нийслэл гэдэг засаг захиргааны нэгжийнх нь хувьд ч тэр, Улаанбаатар хот гэсэн хотынх нь хувьд эдэлбэр газрын хэмжээнд ч гэсэн ямар нэгэн өөрчлөлт ороогүй. Бид уг асуудлыг одоогоор бол хөндөөгүй. Үүнийг

бас Газрын тухай хууль түрүүн ярьж байгаа, нэг мөр бас шийдэх нь зөв байгаад байгаа юм.

2 дугаарт, Улаанбаатар хотын энэ газрын гэдэг юм уу, Төв аймагтай маргаантай энэ асуудлыг нэг мөр бас Газрын хуулийг шийдсэний дараа тэр Эрдэнэ сумтай ч гэдэг юм уу, тодорхой асуудлуудаа ингээд яриад явах нь зөв гэж бид хэд бас үзэж байгаа учраас энэ хэсгийг бол хөндөөгүй.

Ер нь зүгээр энэ бүтээн байгуулалтын орон зайг бас шийдвэрлэх гарц бол ерөөсөө цэвэр газар чөлөөлөлтийнхөө асуудлаар л бид асуудлыг шийдээд явж байна. Ингээд жишээ нь Чингэлтэй, СБД дээр цааш Сэлбэ хот болгож хөгжүүлнэ гээд ТЭЗҮ, зураг төсөв нь хийчихсэн, олон улсын зах зээл дээрээс мөнгө босгох ажил хийж байна.

Ер нь бол Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр орон нутгийн эрхийг хязгаарлалчихсан байж байгаа. Бид энэ дэд бүтцийн буюу хэрэглэгч нь байгаа, үнэ тарифын зөв бодлого буюу үнэ тарифын чөлөөлөлт, либералчлал хийгээд өгөх юм бол цаашидаа энэ бизнес болгоод аваад явах маш олон зүйлүүд байна. Эрчим хүч, дулаан дээр. Энэ чиглэлдээ бас орон нутагт бас эрхийг нь өгөх ёстой гэсэн байдлаар бас холбогдох хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаан дээр танилцуулаад явж байгаа. Ингэж байж өөрөө эргээд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж чадахгүй байгаа зүйлүүдийг хувийн хэвшил маань хийдэг. Хувийн хэвшил маань бизнес болгодог, ажлын байр бий болгодог. Эцсийн дүндээ сая 700 мянган иргэд маань найдвартай инженерингийн дэд бүтцээр хангагдаж, бүтээмж дээшилдэг, амьдралын чанар дээшилдэг, сэтгэл ханамж дээшилдэг энэ концепцыг бол нийслэл Улаанбаатар хот бас барьж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье. Баярлалаа.

Г.Занданишатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

Ц.Мөнхцэцэг: Тухайн хот, тосгоны иргэдийн санал асуулгаар гарсан энэ шийдвэр эцсийн байх уу? Өөрөөр хэлбэл санал асуулгад оролцсон иргэдийн олонх нь тухайн асуудлыг шийдсэн тохиолдолд энэ шийдвэр эцсийн байх уу гэдэг дээр л хариулт авмаар байна.

Г.Занданишатар: Сайнзориг, 4 хариулъя.

П.Сайнзориг: Хуулийн төсөл дээр бол зөвлөл эцэслэн шийдэхээр байгаа. Мэдээж энэ зөвлөл маань иргэдээсээ сонгогдож байгаа, тодорхой асуудлууд дээр бас байр суурийн зөрөөтэй байдал ч гэдэг юм уу, ер нь зүгээр тодорхой иргэдээрээ эрэмбэлүүлэх асуудлаа шийдээд, эрэмбийн дээгүүрх зүйлүүдийг зөвлөл баталгаажуулаад, цаашаа явна гэсэн ийм байдлаар хуулийн төсөл дээр орсон.

Г.Занданишатар: Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна.

Дараа нь санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар тогтолцооныхоо өөрчлөлтийг хийсэн. Одоо бол эдийн засгийн реформоо хийнэ ээ гээд. Ингээд Улсын Их Хуралд суудалтай 3 намын удирдлагын түвшинд тохиролцоо хийсэн.

I дүгээрт, энэ Баялгийн сангийн асуудлыг явуулъя, эдийн засгаа тэлэх, хөрөнгө оруулалт хийх, мөн дотоод хуримтлалын энэ тогтолцоог бий болгоё гэсэн ийм байдлаар тохирсон.

Дараагийн нэг зүйл нь болохоор энэ хотын асуудлыг ярья. Өөрөөр хэлэх юм бол бүс нутгийн энэ бүсчилсэн хөгжлийн асуудлыг ярья. Хотыг статус, квотыг нь тогтоох асуудлыг ярья. Хотын эдийн засаг гэдэг ойлголтыг бий болгож, энэ

төв суурин газар зах зээл үүсгэх замаар энэ реформыг, эдийн засгийн реформыг хамтад нь хийе ээ гэсэн ийм байдлаар ярьж тохирсон. Тэгээд үүний хүрээнд бол Засгийн газраас оруулж ирж байгаа юм байна гэж ойлгож байна. Тийм.

Тэгээд энэ үеэр бол бас яригдсан, тохирсон зүйл нь юу байна гээд тэгэхээр энэ Засгийн газрыг бол нүүлгэх хэрэгтэй, яамдуудыг нүүлгэх хэрэгтэй. Улаанбаатар хотоос гаргах хэрэгтэй. Дэлхийн маш олон улсууд бол амжилттай жишээнүүд бол байгаа. Засгийн газар байдаг хот гэж тусдаа, шийдвэр гаргадаг хот гэж тусдаа, бизнес эрхэлдэг ийм хот гэж тусдаа байна гээд. Маш энгийн жишээ гээд тэгэхэд Австралид байна. Тийм ээ, Канбере гээд хот байна. Энэ ойрхон жишээ гээд тэгэхэд энэ Вьетнам байна. Ханой гээд бизнесийн Ханой гээд өөрийн хот байдаг тийм ээ. Гэтэл цаад талд нь ингээд бизнесийн хот байна.

Тэгэхээр ийм байдлаар явдаг. Америкт гэлээ гэхэд чинь мөн адилхан бизнесийн санхүүгийн төв нь болохоор Нью-Йорк гэж байдаг бол Вашингтон Дисси хот нь болохоор яг Засгийн газрын бүтцүүд нь байдаг. Ингээд ийм байдлаар ингээд хуваарилагдаад явж байна. Энэ нь болохоороо өөрөө үр дүнтэй байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол төвлөрлийг сааруулах, зах зээлийг бий болгох, тэгээд энэ шийдвэр гардаг бүтцүүд нь ингээд тусдаа байх ёстой байгаа юм гэдэг нь.

Нөгөө талдаа болохоор энэ Ерөнхийлөгчийн институцийг бол Өвөрхангай руу нүүлгэе ээ, Хархорин руу нүүлгэе ээ гэдэг. Ийм байдлаар бас Ерөнхийлөгчтэй ярьж тохирсон зүйл бас байдаг. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд. Тэгээд өөрөө ч гэсэн бас нүүгээд явах нь зүйтэй. Санхүүгийн эх үүсвэрийг шийдэхэд зөвлөгөө өгөөч ээ гэсэн ийм байр суурьтай бол байсан.

Тэгэхээр ийм байдлаар өөрчлөх хэрэгтэй. Улаанбаатар хотод бол парламентын байшинг үлдээх хэрэгтэй.

Монгол Улс бол парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улс юм. Тэгээд төрийн шийдвэр гаргадаг бүтэц бол парламент юм байгаа юм. Тийм болохоор бид нар парламентын аргачлалыг бэхжүүлнэ. 126 гишүүнтэй пропорциональ элемент гэдэг зүйлийг оруулж ирсэн.

Парламентын байшинд иргэд нь чөлөөтэй орж ирдэг байх ёстой, чөлөөтэй орж ирэх гэхээр энд нөгөө төрийн бүтцүүд нь байгаа болохоороо энд заавал ийм пиджактай, костюмтай, зангиатай ийм гуталтай байхыг шаардаад байдаг.

Яагаад вэ гээд тэгэхээр Засгийн газар нь энэ дотор байгаад байгаа байхгүй юу. 2 давхраа дүүргээд байгаа. 3 давхрын тал жигүүрийг нь болохоор Ерөнхийлөгчийн институц нь дүүргээд байгаа юм. Төр нь бүгдээрээ энэ нэг саарал байшиндаа чихцэлдээд байгаа болохоор иргэд нь орж чадахгүй байгаа юм.

Ингэсэн тохиолдолд энэ парламентын гадна байгаа энэ хашааг буулгах хэрэгтэй байгаа юм. Ногоон байгууламжаа нэмэх хэрэгтэй байгаа. Ингээд парламент нь парламентынхаа байшинд байдаг, иргэд нь чөлөөтэй орж ирдэг, хүүхэдтэйгээ орж ирдэг, түрдэг тэрэгтэй орж ирдэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь орж ирдэг, нохойтойгоо орж ирдэг байгаа. Дэлхийн парламент ийм л байдаг шүү дээ.

Ийм байдлаар ингээд нээлттэй парламентын засаглалаа бэхжүүлээд явах нь зүйтэй байгаа юм.

Тэгээд энэ агуулгаараа бол энэ тогтолцоог ингээд дэмжиж байгаа. Үүнийг харин зоригтой хийх хэрэгтэй байгаа юм. Тэгэхээр энэ хүрээнд бас ингээд 2, 3 асуудал байгаа юм. Юу вэ гээд тэгэхээр ... /минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэлчхэв үү. Эхлээд гол юмаа асуудаг байхгүй юу. Одоо

хүртэл туршилагажаагүй, тэгээд, тийм. Хамгийн гол юмаа эхний 5 секундэд.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн юм байна уу?

Дараа нь санал хураалттай. Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа.

ХҮН намын дарга Тогмидын Доржханд гишүүнийг нэмээд тасаллаа. Энэ 4 хүн үг хэлээд, дараа нь санал хураалт. Дэмжсэн, дэмжээгүйгээ тодорхой хэлнэ. Үндэслэлүүдээ тодорхой хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Яах вэ, Засгийн газар өргөн барьсан. Дээр нь бас нийслэлийнхэн ч яах вэ бас нэг энэ яаж нэг үйлчилгээгээ иргэддээ хүргэх вэ л гэж бодоод л, зүтгээд байгаа эд нарыг бодоод бол би дэмжиж байна гээд, дэмжье гэж ингэж бодож байгаа.

Зүгээр хэд хэдэн том асуудал байгаа юм. Дамдинням гишүүн ээ, би нэг яриадахъя. Наад хэдийг чинь сонсох хэрэгтэй юм байгаа юм.

Миний ойлгож байгаагаар бол ийм байхгүй юу. Нийслэлийн эрх зүйн байдал, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуультай холбоотой асуудлыг бол нийслэл санаачилж авч явах ёстой. Хотын асуудал, нийслэлийн асуудал болохоор чинь 2 шал өөр юм байхгүй юу. Онолын асуудал нь шал өөр юм байдаг байхгүй юу.

Манай энэ орон нутаг судалдаг, хот судалдаг хүмүүсийг нэгийг нь ч аваагүй, нэг нь ч алга байгаа юм. Тийм. Онол арга зүйн хувьд бол энэ буруу технологи явж байгаа юм. Наадах чинь яах вэ гэхээр хоттой холбоотой асуудал чинь нийслэл биш байхгүй юу. Монгол Улс Үндсэн хуульдаа заачихсан, одоо явж байгаа зарчим чинь ийм байхгүй юу. Нийслэлтэй холбоотой асуудал нь Нийслэлийн эрх зүйн байдлын хуулиараа явна. Хот тосгонтой л холбоотой асуудал Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиараа явна. Энэ 2-ыг нэгтгэсэн засаг

захиргааны холбоотой асуудал нь засаг захиргааны хуулиар явна. Яагаад хот, тосгоны хууль гарч байгаа юм гэхээр нийслэлээс бусад бүх хотуудтай харилцаа зохицуулж байгаа юм. Хот, тосгоны харилцааг.

Тэгээд нийслэл юугаар явах гэхээр ганцхан нийслэлийнхээ хуулиар явна. Өөр юмаар явахгүй байхгүй юу. Тэр өөрчлөлт оруулах, эрх мэдлээ нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлаа та нар нийслэлийнхээ хуулиар явах ёстой байхгүй юу. Гэтэл нийслэлийнхээ хууль дээр ийм юмаа огт оруулдаггүй, шал өөр юмаар оролдоод байгаа байхгүй юу. Зарчмын хувьд энэ буруу зүйл байгаад байгаа юм. 1 дүгээр асуудал нь.

2 дугаар асуудал юу байна вэ гэхээр би өглөө Байнгын хороон дээр асуусан. Та нар аймгийн төвүүдийг жаахан томруулъя. Том хот болгоё гэж байгаа бол хамгийн түрүүнд газар нутаг, эдэлбэр газрын асуудлыг шийдэх ёстой юм. Үүнийг шийдэхгүйгээр бид нар өөр юм яриад ямар ч хэрэггүй. Би өмнө нь төсөл боловсруулаад тодорхой Засгийн газарт өгсөн. 25-30 сумыг нийлүүлж, нэгдэж байж аймгийн төвүүд маш том хотууд болох юм. Тэр аймгийн төв чинь яаж хөгждөг юм гэхээр аж үйлдвэрийн аж үйлдвэр хөгжих газартай, газар тариалан хөгжих газартай, эрчимжсэн аж ахуй хөгжих газартай, ингэж байж явдаг болохоос биш зүгээр нэг хүн өөр аймаг, өөр сумын нутаг дээр газар олгодог тийм хот гэж байгаад урагшаа ахихгүй байхгүй юу. Энэ том концепцын асуудал огт орж ирээгүй, огт орж ирээгүй. Энэ 2 дахь энэ хууль нь нэг цаашидаа хэрвээ ажлын хэсэг гарч ажиллах юм бол үүнийг авч үзэх ёстой, 2 дахь том асуудал энэ.

3 дахь том асуудал. Түрүүн Доржханд гишүүн хөндөнө лээ. Энэ хэрэгжих хугацаатай холбоотой асуудал байхгүй юу? Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот, тосгонтой холбоотой асуудлыг нэг л циклээр явах ёстой юм. Энэ цикл зөрүүлж огт болохгүй байхгүй юу. Энэ хуулийг

хэрэв ингээд гайгүй шиг болгоод гаргаад явъя гэвэл 24 оны 10 дугаар сарын сонгуулиудтай яг бүгдийг нь хамтатгаж хийх ёстой. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгууль, дээр нь Хот, тосгоны захирагчийн болон зөвлөлийн сонгуулийн хамт хийж байж, энэ нэг циклээ очиж орох, зөв голдирол руугаа очиж орох ёстой юм байхгүй юу. Гэтэл энэ нь 26 онд хэрэгжинэ. Эд нар гэхээр 4 жилийн дараа хэрэгжих болж байгаа юм. 4 жилийн дараа хэрэгжих хуулийг бид нар ярих юм уу үгүй юү гэдэг асуудал байхгүй юу. Наадах чинь.

Дараагийн 4 дэх асуудал. Эрх шилжүүлэхтэй холбоотой асуудал байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2-т чинь чиг үүргийн шилжилт гэж байгаа болохоос хот, тосгоны шилжилт гэж юм байдаггүй юм шүү дээ. Гэтэл сая энэ Сайнзориг гэж нөхрийн яриад байгаа нь бараг л хот, тосгонд шилжих гэж байгаа юм шиг юм яриад, ямар сонин юм ярьдаг юм. Зөвхөн чиг үүрэг шилжихтэй холбоотой асуудал байдаг юм. Тэр чиг үүргийг чинь хуулиар нь шилжүүлдэг юм. Би өглөө ч асуусан. Та нар улсын зэрэглэлтэй хотод ямар эрх шилжүүлэх гэж байгаа юм бэ? Өнөөдөр байгаа аймаг, нийслэлийн эрх шилжүүлэх гэж байгаа юм уу, өөр юм шилжүүлэх гэж байгаа юм уу. Энэ тодорхой бус байгаа юм.

4 дэх юм нь дагасан хуулиуд дээр асуудал их байгаа юм. Тухайлбал Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиараа, би Богд хан уултай холбоотой асуудалтай холбоотой асуудлыг нийслэлд зохицуулалтыг нь хийе гэж байгааг бол зөвшөөрнө. Гэтэл бүх тусгай хамгаалалттай газруудын хуулийг аваад ирчихсэн байгаа юм. Та нар Орхоны хөндийн тусгай хамгаалалттай газартай холбоотой асуудлыг нийслэл шийддэг болох гэж байгаа юм уу, яах гэж байгаа юм? Хан Хэнтийн байгалийн цогцолбор газар тэр тусгай хамгаалалттай газрыг нийслэл шийддэг болох гэж байгаа юм уу, яах гэж байгаа юм. Тийм.

Тэгээд энд тэндхийн баахан сайд нарын эрх хэмжээний юмнуудыг бүгдийг нь энэ рүү аваад ирчихсэн, 38 хуулиар. Асуудлын гол нь энэ 2 хуульдаа биш дагасан хуульдаа байгаа байхгүй юу. Төсөв хөрөнгө, төрийн өмч, орон нутгийн өмч худалдан авахтай холбоотой 16 хууль байгаа юм. Газартай холбоотой 8 хууль байгаа юм.

Тийм, тэгэхээр энэ юмаа эд нар боловсруулахдаа бол та нар жаахан учиртай боловсруулж байх хэрэгтэй шүү дээ. Сая энэ Энх-Амгалан уурлаад байна. Үнэн шүү дээ. Боловсролын сайдын бүх юмнуудыг нь аваад ороод ирчихсэн ч байх шиг.

Тэгээд ийм байдлаар энэ цаашаа явна гэхэд хэцүү. Би бол ажлын хэсэг гаргаад маш сайн ахлуул, ажлын хэсгийн ахлагчаар Мөнх-Оргилыг гээд тавимаар байна. Ийм ... /минут дуусав/

Г.Занданшатар:

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор манай Их Хурлын гишүүд бол дор бүрдээ бас санаа оноогоо илэрхийлж байна. Энэ чиглэлээр бас ажиллаж байсан туршилагатай хүмүүс бий. Тухайлбал Төгтохсүрэн дарга бол энэ хот эрх зүйн байдал, орон нутгийн засаг захиргааны нэгжийн чиглэлээр бол олон жил ажилласан. Би ажлын хэсгийн түвшинд, хэлэлцүүлгийн түвшинд бол засаж залруулаад, дундын хувилбар гаргаад, оновчтой шийдэл гаргах ийм боломжтой гэж ингэж бодож байгаа юм.

Хуулийн төслийг дэмжиж байгаа. Дэмжиж байгаа үндэслэлүүдээ би түрүүн бас нэлээн сайн хэлсэн. Өнөөдөр Улаанбаатар хотын иргэд жаргалтай биш зовлонтой байна. Зундаа үерт автана, өвөлдөө утаанд, 4 улирал түгжрэлтэй, агаарын бохирдол, хөрсний бохирдол, ААН-үүд нь хөгжиж чаддаггүй, үйл ажиллагаагаа өргөжүүлэх

боломжгүй. Яагаад гэвэл тог цахилгаан нь хүрдэггүй, дулаан нь хүрэлцдэггүй, дарамт ихтэй, их зовлонтой байдлууд байгаад байгаа юм. Энэ асуудлуудыг шийдэх энэ боломжийг энэ хуулийн төслөөр бүрдүүлж өгч байгаа учраас би энэ хуулийн төслийг 1 дүгээрт, дэмжээд байгаа юм.

2 дугаарт, иргэд маань маш олон жил ярьж байгаа. Бид өөрсдийнхөө Засаг даргыг өөрсдөө сонгоё. Нам битгий оролцооч ээ, нам битгий хүнээ бидэнд шахаад тулгаад бай гэж олон жил ярьсан. Энэ хуулийн төслөөр сумын иргэд, дүүргийн иргэд, хорооны Засаг дарга байх юм уу. Би тэрийг сайн мэдэхгүй байна. Даргаа өөрсдөө сонгох боломж нь бүрдэж байгаа юм билээ. Олон жилийн дараа иргэд маань өөрийнхөө итгэсэн, тэдний төлөө ажиллах, тэр хүнээрээ удирдуулах энэ боломжийг энэ хуулийн төслөөр бүрдүүлэх юм байна.

3 дугаарт, хэлэх гэж байгаа зүйл, бид нар ер нь иргэдээ хотоос гаргах гэж төвлөрлийг сааруулах гэж их үзлээ дээ. Байшин барилга өгнө, цалин мөнгийг нь нэмнэ, татвараас чөлөөлнө гээд. Хотын иргэд явахгүй байна. Хэн ч гэсэн төв суурин газар амьдрахыг хүснэ. Тэгвэл энэ удаа иргэдээ яв гэж биш, дарга дарга нар, төр захиргааны байгууллагууд өөрсдөө явахаар шийдсэн байна. Энэ бас олон жилийн дараа гаргаж байгаа бол шийдэл шүү. Үйлчилгээ нь цахим болох юм байна. Аль болох хүнээс хамаарал багатай, хүнд суртал, авлига, хээл хахуулиас ангид байх, ингэж төрийн үйлчилгээг авах боломжууд нь бүрдэх юм билээ. Энэ мэтчилэн олон жилийн турш иргэдийн хүсэн хүлээсэн тэр боломжуудыг бүрдүүлж өгч байгаа хуулийн төсөл орж ирж байгаа юм байна. Мэдээж энэ хуулийн төслийг бид төгс төгөлдөр болчихсон. Үүгээр бүх зүйл сайн сайхан болно, бүх зүйл шийдэгдэнэ гэж үзэхгүй.

Гэхдээ одоогийн байгаа байдлаар бид явах ямар ч боломжгүй. Яагаад гэвэл сонгууль дөхөөд ирэхээр зэрэг л түгжрэл бууруулна, утааг 2 дахин бууруулна,

ажлын байр бий болгоно, дэд бүтцийг хөгжүүлнэ. Одоо энэ амлалтад хэн итгэх юм бэ. Ерөөсөө хийгдэхгүй байгаа. Тухайлбал 5 дугаар цахилгаан станц барина, эрчим хүчнийхээ хүчин чадлыг нэмэгдүүлнэ ээ л гээд л яриад л байна. Байхгүй. Тэгвэл бид нар энэ төвлөрлөөс арай тодорхой чиглэл рүү явснаараа дэд бүтцээ тухайн тухайн нэгждээ бий болгох боломж бүрдэх юм билээ. Нэг том станцыг хүлээж авах, хүлээхгүйгээр дагуул хот маань, улсын чанартай хотууд маань, орон нутгийн чанартай хотууд маань өөрсдөө шийдлээ гаргаад дэд бүтцээ хөгжүүлээд ААН-үүдээ дэмжээд явах бас боломж нь бүрдэнэ. Энэ мэтчилэн бол өнөөдөр энэ иргэдэд ээлтэй, олон нийтийн өмнө тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх ийм анхны хуулийн төсөл орж ирж байгаа учраас л дэмжээд байгаа юм.

Энэ чигээрээ явах юм бол Улаанбаатар хот маань өнөөдөр хүн амьдрах ямар ч боломжгүй, иргэдээ бухимдуулсан, эцсийн эцэст ер нь юунд ч хүрч мэдэхээр ийм нөхцөл байдал үүссэн гэдгийг өнөөдөр зөвхөн Улаанбаатар хотын иргэд биш, Улаанбаатарт ирж байгаа орон нутгийн иргэд, гадаадын, нийслэл хотод хөл тавьж байгаа хүн болгон мэдэж байгаа. Гадаадын иргэд ярьдаг юм байна лээ шүү дээ. Манайх түгжрэлтэй л дээ. Тэгэхдээ арай ч Улаанбаатар шиг биш ээ. Монголын түгжрэл бол үнэхээр гайхалтай юм байна. Ямар сайндаа л машиндаа хоол хийж байсан тохиолдол гараа биз дээ.

Тэгээд энэ нөхцөл байдлыг бид нар ер нь засах юм уу, засахгүй юм уу гэдэг л асуудал шүү дээ. Ямар нэгэн шийдэл гаргахаас өөр аргагүй болчихсон шүү дээ, өнөөдөр. Бодит байдлаа мэдэж байж ямар нэгэн шалтгаан гаргаад, энэ хуулиа дэмжихгүй байх боломж өнөөдөр байхгүй. Засаж залруулах зүйл бий. Үүнийг бол би ойлгож байгаа. Тэгэхдээ тэр боломж нь өөрөө хэлэлцүүлэх, 2 удаагийн хэлэлцүүлэг байж байна. Ажлын хэсэг байгуулагдана, өөр өөрийн байр

суурьтай байгаа гишүүд маань ороод ажиллах бүрэн бололцоотой.

Тийм болохоор өнөөдөр хуулийн төслөө дэмжээд, ажлын хэсэг хэлэлцүүлгийн түвшинд асуудлуудаа жигдлээд явъя гэсэн ийм саналтай байна.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тийм, нэг хэсэг маань хот суурины амьдрал руу шилжчихлээ л дээ. Тэгээд энэ улсуудын амьдралыг зөв зохицуулах үүднээс энэ хууль яалт ч байхгүй хэрэгтэй болчихоод байгаа юм. Тэгээд энэ талаас нь харахаар дэмжмээр байгаад байдаг. Ажлын хэсгийнхээ түвшинд нэлээн сайн судална биз дээ. Үндсэн хуулиасаа давж байгаа ч юм байна, цөмөрч гишгээж байгаа ч юм байна. Үүнийгээ харахгүйгээр боломгүй. Яг үнэнийг хэлэхэд бол параллельны, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжүүд байгуулах ийм эрх зүйн орчин бүрдүүлэх гээд байгаа үйл явц болоод байгаа байхгүй юу. Нэрийг нь сольчихсон. Үүнийгээ нэлээн бодмоор байна, гэж.

2 дахь зүйл, одоо байж байгаа аймгийн статустай хэд хэдэн улсын чанартай хотууд хотын хэлбэр лүүгээ шилжихэд хажууд нь байж байгаа өнөө одоогийн сумын ангиллаар яваад байгаа нь эрх зүйн хувьд юу нь дордчихож боломгүй байна л даа, ангилал нь. Тэгэхээр статус нь, үүнийгээ их тодорхой үзэж авч харахгүй бол боломгүй гэж. Нэг ийм зүйл байгаа.

3 дахь зүйл. Хот байгуулахдаа тухайлсан хууль гаргагдаа болимоор байна. Хот төлөвлөлт, хот байгуулалтын хуулиа нэг баталмаар байна. Энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиа нэг баталмаар байна. Энэ хоёртоо захирагдаж, хотууд нь байгуулагддаг юм л баймаар байна. Тэгэхгүй бол энэ чинь бие даасан хуультай хотууд байгуулаад байх юм бол болохгүй шүү дээ. Нийслэл бол яах аргагүй улсын нийслэл. Бүх үйл явц энд явагдаж байгаа учраас бие даасан

хуультай байхаас аргагүй. Тэгэхээр үүнийгээ бодож энэ дагуулж орж ирж байгаа хот байгуулж байгаа хуулийнхаа асуудлыг бол ажлын хэсэг дээрээ ярьж, татаж авах хэрэгтэй. Би бол тэгж ойлгож байгаа.

Ингээж л асуудлаа цогцоор нь ишидэх нь зөв болов уу гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн.

Дараа нь санал хураалттай, гишүүд чуулганы танхимд цуглая.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр энэ дахиад хэлье. Улс төрийн намуудын бас тогтолцооны үндсэн дээр хийгдэж байгаа болохоор зарчим нь бол зөв гээд. Бид бол дэмжиж байгаа, хэлэлцээд явах нь бол зүйтэй, зүйтэй. Гэхдээ асуудал байна. Манай нийслэл дээр бас асуудал байна. Ялангуяа тэр нийслэлийн иргэдийн төлөөлөл дээр бас асуудал байна. Энд тохирсон асуудал маань тэнд ишидвэр гаргахдаа буруу гараад байна шүү. Тухайлбал бид нар энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхийн тулд Монгол Улсын хөгжлийн төлөө кноподдог, бодлогоор өрсөлддөг улс төрчидтэй болъё гээд пропорциональ элемент оруулсан. Үүнийг биежүүлэхийн тулд бид нар ингээд тойргийг томруулаад бүсчилсэн, тийм биз.

Ингээд сонгуулиа хийнэ ээ гээд явсан. Гол нь ингээд нэг Монгол Улс 3,5 сая Монголчууд нэг зүг рүү хардаг байя. 30 жилийн энэ нэг бие биеийгээ шүүмжилдэг, дэгээ тавьдаг, үр дүнд нь ингээд хөгжлөө ингээд гацаадаг энэ нэг хөгийн популист улс төрийг ингээд зогсооё гэсэн ийм л байр суурь дээр байсан.

Тэгээд удирдлагууд нь ингээд гарын үсэг зураад, тохиролцоогоо хийсэн. Өнөөдөр МАН-ын дарга Оюун-Эрдэнэ, АН-ын дарга Гантөмөр бид нар бол ингээд тохиролцоогоо хийгээд явсан

байдаг. Гол зорилго нь юу юм. Хөгжлийн төлөө шүү дээ. Гэтэл өнөөдөр нийслэлийн сонгуулийн асуудал газрын зураг нь бол саяхан НИТХ-ын үеэр яригдсан байна. Ингээд яригдахдаа яг 2016 онд Хэнтийг яаж зурж байлаа, Увсыг яаж зурж байлаа, яг тийм зургийг манай эрх барьж байгаа Ардын намын нийслэлийн төлөөлөгч нар зурчихсан байна шүү. Бид нар энд концепцоо яриад байдаг, томруулна гэж яриад байдаг. Улаанбаатар хотыг бүр нэг тойрог болно гээд байхад тэнд БЗД-ийг ингээд 3 хуваачихсан байна. Дүүрэг, дүүргээр нь томруулах ёстой шүү дээ, энэ чинь.

Тэгээд ийм байдлаар зөвхөн бид нар ялна гэсэн байдлаар, сонгууль гэсэн байдлаар хандах юм бол Монгол Улс ялагдана. Ийм болохоор энэ дээр анхаарах хэрэгтэй, 1.

2 дугаарт, Тогтохсүрэн гишүүний хэлж байгаа өнцөг зөв. Би яг үүнийг асуух гээд байгаа юм. Нэгэнт ийм реформ хийвэл зоригтой хий л дээ. Нямбаатар дарга аа, нийслэл ээ, Сайнзориг дарга аа, зоригтой хийх хэрэгтэй. Одоо шууд эхэлчих л дээ. Заавал яахаараа 4 жилийн дараа үүнийг хийх гээд байгаа юм. 10 оны энэ 2024 оны 10 сарын сонгуулиар бид нар ингээд сонгуулиа хийчихсэний дараа энэ реформоо хийнэ ээ гэх юм бол 4 жил алдах гээд байна. Одоо хийчих. Одоо бид нар тэр олон үр ашиггүй дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн орон тоо бол хэрэггүй. Одоо энэ хотынхоо энэ 14 хотынхоо хүрээнд иргэдээсээ хотын даргаа сонгоод явчихъя, одоогоос эхэлчихье. Хуулиа ингээд батлаад явчихъя. Ингэх юм бол энэ зоригтой реформ болно. Ийм зүйл дээр бид нар улс төрийн намын удирдлагууд бол тохирсон. Энэ бол Монгол Улсын эрх ашиг юм. Ингээж байж хот чинь өөрөө хот шиг болно.

Өнөөдөр улс төрийн намуудын итгэх итгэл, иргэдийн итгэх итгэл уначхаад байгаа нь юу вэ гээд тэгэхээр энэ маань бүх түвшиндээ нам, нам, нам ингээд намын томилгоонууд яваад байхаар уначхаад байна шүү дээ. Гэтэл

парламент чинь энэ бодлогоороо өрсөлддөг мэтгэлцээний талбар байх ёстой. Тэнд тэр жижиг хотуудын удирдлагууд дандаа иргэдээсээ сонгогдоод явдаг байх юм бол энэ асуудал маань нөгөө тийшээ болчихно. Ингээд парламентын ардчилал маань бэхжих, иргэдийн итгэлийг авах, цаашаа ардчиллаа бид нар хамгаалах ийм агуулгаар энэ зөв болчихоод байгаа юм. Ийм болохоор нэгэнт реформ хийж байгаа бол зоригтой хийгээч. Сонгууль харж манай нам ялах, би ялах, эсвэл та ялах, танай нам ялах гэдэг асуудлаа хойшоо тавьж байгаад зоригтой хиймээр байгаа юм.

Тэгээд намын удирдлагуудын түвшинд ярьсан энэ ажил маань бодит байдал дээр ажил хэрэг болмоор байгаа юм, хэрэгжүүлмээр байгаа юм. Ийм болохоороо нэгэнт бид нар томруулна гэдэг концепц явж байгаа бол томруулах хэрэгтэй. Тэгээд үнэхээр зөв концепц байна гэх юм бол заавал 4 жилийн дараагаас биш өнөөдөр энэ ажлыг хийгээд явах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа юм.

Тэгээд хэлэлцүүлгийн явцад бас ажлын хэсэгт ороод ажиллаж гэсэн саналтай байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Гишүүд дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууссан.

Одоо санал хураалт явуулна. Санал хураалт.

Байж байгаарай. Энэ зүгээр бүртгэлийн санал хураалт явуулж байгаа шүү.

Энэ бүртгэлд орохгүй байгаа гишүүдийг тасалснаар тооц.

Байнгын хорооны саналаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт

өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гамигаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо, толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж,

ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хотын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон “Хот байгуулах тухай”, “Тогтоолд нэмэлт оруулах тухай”, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

30 гишүүн дэмжиж, 78,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцлоо.

Ингээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэхийн өмнө Улсын Их Хурлын даргын захирамжийг танилцуулна.

Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан санал болон Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг үндэслэж, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар

иргэдийг мэдээллээр хангаж санал авах, хуулийн төслүүдийн талаар иргэдээс гаргасан саналыг нэгтгэн тайлан мэдээг 05 дугаар сарын 13-ны өдрийн дотор Байнгын хороонд ирүүлэх зорилгоор гишүүд бас тойрогтоо ажиллаж, Улсын Их Хурлаар баталсан Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Уламжлалт МАА-д тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиудыг танилцуулах, хэрэгжилтийг хангуулах ийм ажил зохион байгуулах Улсын Их Хурлын даргын захирамж гарч байна.

Тэгээд энэ Үндсэн хуулийн 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 57.2 болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагатай хууль батлагдсан цогц өөрчлөлтийн дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг өнөөдөр өргөн барьж, хэлэлцүүлж байна. Энэ үндсэндээ 4 жил хэлэлцэж, судалж ажиллалаа. Өмнө нь Тогтохсүрэн даргаар ахлуулсан ажлын хэсэг бас нэлээн удаан ажилласан.

Тэгээд нийтээрээ нэг зүйлийг бас ойлгодог болох. Манай энэ хотын Үндсэн хуульд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдлыг хуулиар тогтооно гэж байсан юм, 57.2-т. Үүнийг дэлгэрүүлж, яах вэ манай Дархан, Орхон, бусад зарим аймгууд маань нутаг дэвсгэрийн нэгжийг эрхийг бас хамт эдлэх ийм сонирхолтой байсан учраас үүнийг Монголын нөхцөлд тохируулж гэдэг юм уу ийм өөрчлөлт оруулсан.

Хамгийн гол өнөөдрийн асуудлын шалтгаан нь бол Үндсэн хуулийн агуулга нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хүний төвлөрлийг хүн ам, эдийн засгийн төвлөрөл, улс төрийн төвлөрлийг бол хот гэж нэрлэнэ ээ гэж байгаа юм. Тэгээд энэ агуулгаар байсан юмыг 92 оноос хойш бүх аймгийн төвүүдийг баг, сум болгоод тэгээд хот гэдэг нэрийг нь алдагдуулчихсан. 90 оноос өмнө, 92 оны Үндсэн хуулиас өмнө бүх аймгийн төвүүд Архангай аймгийн төв Цэцэрлэг хот, Мөрөн хот. Ингээд хүн амын төвлөрөл

хот байсан юмыг ингээд задалчихсан. Чимэд гуай Үндсэн хуулийн тайлбар номдоо Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын талаар тайлбарлахдаа хэлсэн байдаг юм. Архангай нэг аймаг орж явна гэж яриад байдаг. Тэр аймаг явж байна, тэр аймаг. Тэгтэл тэр аймгийн төв буюу Цэцэрлэг хот руу, Мөрөн хот руу, Зуунмод хот руу явж байгаа. Зүүн нутаг дэвсгэр, аймаг гэдэг бол нутаг дэвсгэр, провинс буюу нутаг дэвсгэр бол тэнд байж байх ёстой. Тэгээд хотын олон 10 онол байна. Хамгийн анхны үүссэн онол бол ус дагаж хуучны бүх хотууд ус, том гол мөрөн дагаж байгуулагддаг байсан.

Дараа нь эдийн засгийн агуулга, одоо орчин үед технологийн агуулгатай ийм хотын хөгжил өөрийн онолтой байхгүй юу. Тэгээд энэ корпорэйт боди буюу ийм корпоративны шинж чанартай, корпорацын шинж чанартай байгууллага байгаа юм. Үүнийг нутаг дэвсгэртэйгээ хольж салгаад байдаг учраас л өнөөдрийн энэ асуудал байгаа юм. Ингэвэл аймгийн төвүүд илүү биеэ даасан, яг корпорацын шинж чанараар нийтийн эрх ашгийн төлөө ажилладаг байгууллага байх энэ зарчимтай нийцүүлж, философио ойлгохгүй бол энэ дээр маш олон судалгаа явагдсан.

Энэ дээрээ үндэслэж нийслэл дотор бол дүүрэг дотор хэдэн ч хот байж болно. Энэ 42 байх юм уу, 32 байх юм уу, 9 байх юм уу, 10 байх юм уу. Энэ яг энэ хотын онол дээрээ үндэслэгдээд хүн амын төвлөрөл, төрийн үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн энэ үйлчилгээнүүдийг тэгш хүртээмжтэй хүргэх энэ зарчимдаа нийцүүлж энэ дээрээ нэлээн сайн ажиллах хэрэгтэй. Энэ Тогтохсүрэн дарга болон олон гишүүд нэлээн бодитой саналууд ярьж байна. Энэ дээр бас Мөнх-Оргил гишүүн Тогтохсүрэн дарга 2 бас нэлээн удаан ажилласан. Энэ саналууд орох ёстой. Тэгээд Учрал гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулаад манай Мөнх-Оргил нарын гишүүд бас орж энэ чиглэлээр ажиллана.

Ингээд үүнийг бол богино хугацаанд хэлэлцүүлгүүдийг үр дүнтэй зохион байгуулж, Тогтохсүрэн дарга аа, нэн ялангуяа таны хэлээд байгаа тэр дагасан хуулиуд дээр, заримдаа хуулийн зөрчил чинь дагасан хуулиуд дээр нэн ялангуяа газрын харилцаа их эмзэг асуудал учраас үүнийг нь нарийвчлан үзэх хэрэгтэй.

Ингээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ. Ажлын хэсэгт шилжүүлэе.

Тийм учраас Төсвийн байнгын хорооны Тэмүүлэн дарга ажлын хэсэгт орж байгаа юм. Тийм ээ. Төсвийн байнгын хороо. Тийм, дагавар хуулиудаа дараа нь хэлэлцүүлдэг шүү дээ. Хэлэлцүүлэг хэлэлцэх эсэхэд. Бүгд холбогдох Байнгын хороодоор орно. Хуучин хууль тогтоомжийн хуулиар энэ дагасан хуулиуд, багц хуулиуд тус тусдаа үзэл баримтлалтай байдаг байсан юм. Одоо багц хууль нэрийн дотор бас хуулийн зөрчилтэй, хийдэлтэй олон юм яваад байгааг бас бол анхаарах шаардлагатай юм байна лээ.

14 цагаас Ерөнхий сайдын мэдээлэлтэй хуулиараа. Тэгээд Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай албан бичгийг танилцуулъя.

Албан ажлын зайлиггүй шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны ...

Ажлын хэсэг болсон. Анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байнгын хороонд шилжүүлсэн. Баярлалаа.

Албан ажлын зайлиггүй шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига, хүнд суртлын бууруулах чиглэлээр “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаарх Ерөнхий сайдын мэдээллийн товыг

хойшлуулж өгөхийг хүсье гэсэн албан бичиг ирсэн байна.

Ийм учраас Ерөнхий сайдын мэдээллийг хойшлууллаа.

14.35 цаг

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилэйн Даваасүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

Саяын захирамж батлагдсантай холбогдуулаад өнөөдөр бүх асуудлаа хэлэлцэж дуусна. Гишүүд гарч явахгүй. Зарим нэг гишүүд цүнхээ бариад гараад явж байна шүү. Энх-Амгалан гишүүн суу.

Ц.Даваасүрэн: Эрхэм Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ, Нийслэл Улаанбаатар хотын хөгжил, хүн амын өсөлт нь хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий болох, замын хөдөлгөөнд хэт түгжрэл үүсэх, орчны бохирдол нэмэгдэх зэргээр эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч байгаатай холбоотойгоор бүс нутгийн тэнцвэржсэн хөгжлийг хангах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоох, хотын бүтээн байгуулалт, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Шинэ Зуунмод хотыг олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байгуулах бөгөөд хотын эдэлбэр газрын хэмжээ нь 32 мянган га байна. Засаг захиргааны хувьд

Улаанбаатар хотын дагуул хот статустай байх бөгөөд Төв аймагтаа бүхий л талаар хөгжлийн интеграцад орж, хотын эдийн засгийн үр ашгийг хамт хүртэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн засаглал, эдийн засгийн тогтолцоог бий болгоно.

Шинэ Зуунмод хот нь амралт, аялал жуулчлалын, олон нийт, худалдаа үйлчилгээний, засаг захиргааны, оюутны хотхон, судалгаа шинжилгээний, тээвэр ложистик, олон улсын нисэх онгоцны буудал, агаарын карго, аж ахуйн нөөц зэрэг 9 бүстэй байхаар зааж, бүсчлэлийн хуваарийг зөвхөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлно.

Тухайлбал амралт, аялал жуулчлалын бүсэд Интегретэд ресорт, олон улсын хурал зөвлөгөөн, арга хэмжээний цогцолбор, морин тойруулга, бооцоот тоглоом, музейн цогцолборыг байгуулах, хотын төв, засаг захиргааны бүсэд төрийн зарим байгууллагыг нүүлгэхээр төлөвлөж байна.

Шинэ Зуунмод хот нь иргэдэд зориулсан ногоон хөгжлийг дэмжсэн ирээдүйн хотын олон улсын концепцын дагуу нэгдсэн төлөвлөлтийн тогтолцоотойгоор байгуулагдахаар тусгасан. Тодруулбал оршин суугчдын оршин суугаа газраас 20 минутын газарт, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн тээврийн үйлчилгээний буудал, цэцэрлэгт хүрээлэн, худалдаа үйлчилгээний газартай байх зэрэг шаардлагыг тавина.

Хотын хөгжлийн болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэн, ААНБ-д газар ашиглах эрх олгох асуудлыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэх ба төсөл болон сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд тавигдах шаардлага, төсөл шалгаруулах журмыг Засгийн газар батална.

Шинэ Зуунмод хотын удирдлага нь хотын оршин суугчдаас сонгогдсон хотын зөвлөл, захирагч болон Ерөнхий

архитектор, хотын хөгжлийн корпорацаас бүрдэх ба зохион байгуулалтын хувьд хороонд хуваагдана. Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацыг Төв аймаг болон нийслэл хамтран байгуулж, хотын газар хөгжүүлэлт, бизнес хөгжүүлэлтийг хариуцаж, хөрөнгө оруулагчтай төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

Шинэ Зуунмод хотын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, бие даан хөгжих баталгаагаар хангах нь төр, нийслэл хот, Төв аймгийн үүрэг байх бөгөөд хуульд заасан тодорхой дэмжлэг үзүүлэх юм. Тухайлбал төрөөс бүтээн байгуулалтын явцад татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, улсын төсөвт дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг тусгаж батлах, төрийн байгууллагыг нүүлгэн шилжүүлэх гэх мэт. Нийслэл, Төв аймгийн хувьд орон нутгийн төлбөр хураамжаас хөнгөлөх, өөрийн өмчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах, төрийн үйлчилгээг шуурхай, нэг цонхоор хүргэх, хяналт шалгалтыг давхардуулахгүй байх, дагуул хот, хотын бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлнэ.

Хот нь төсөвтэй байх ба тухайн хот дахь татварын орлогын 80 хувийг шинэ Зуунмод хотод, 20 хувийг Төв аймагт хуваарилж зарцуулна. Хууль батлагдсанаар дараах үр дүн гарна гэж тооцож байна. Үүнд:

Дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх хүрээнд хөрөнгө оруулалт татварын таатай орчин бий болно.

Шинээр ажлын байр бий болж, дотоодын нийт бүтээгдэхүүн болон гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Тээвэр ложистикийн нэгдсэн төвийг байгуулж хөгжүүлснээр орон нутгийн болон бүсийн цаашилаад олон улсын ложистикийг сайжруулна.

Орон сууцжуулах төсөл хэрэгжүүлж, орон сууцын хангамж нэмэгдэж, нийслэлээс иргэд шилжин суурьших, төрийн байгууллага, их, дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны байгууллагуудыг нүүлгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Бус нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх бодлогын хүрээнд Шинэ Зуунмод дагуул хоттой Төв аймаг нь эдийн засгийн интеграцид нэгдэж, тогтвортой хөгжих нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх гэж, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-д нийслэл хот нь дагуул хоттой байна гэж, 34 дүгээр зүйлийн 34.1-д нийслэл хотын дагуул хот нь нийслэл хоттой эдэлбэр газар, хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, тээвэр ложистикийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, газар зүйн байрлал болон нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач

холбогдолтой хот бүрдүүлэгч дэд бүтэц бүхий төвлөрсөн суурин газар мөн гэж, 34.2-т дагуул хотыг нийслэлийн болон бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид эсхүл хэд хэдэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид дамнан байгуулж болно гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтын 9.5.3-д Хөшгийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлийг даган байгуулагдах Шинэ Зуунмод шинэ хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ гэж тус тус заасан байгаа.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлэх зорилтын хүрээнд нийслэл хотын төвлөрлийг задалж, замын хөдөлгөөний түгжрэл, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, орон сууцны хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Мөн бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээг кластераар хөгжүүлж, иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлнэ гэж үзэж, хуулийн төслийг боловсруулсан байна.

Мөн нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, үйл ажиллагаа идэвхжихийн зэрэгцээ төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх зэрэг олон сөрөг асуудлын улмаас нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл үүсэж, иргэдийн ая тухтай амьдрах эрх зөрчигдөж байгаа тул дээрх асуудлуудыг шийдвэрлэх үүднээс Улаанбаатар хотын төвлөрлийг задалж, дэд бүтцийг тэлэх зорилгоор

Шинэ Зуунмод хотыг байгуулах шаардлагатай байна гэж үзжээ.

Хуулийн төслийг Ди парламент.мн цахим хаягт байршуулж, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Хуулийн төсөлд Шинэ Зуунмод хотыг олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байгуулах, Шинэ Зуунмод хотын эдэлбэр газар нь амралт, аялал жуулчлал, олон нийтийн худалдаа, үйлчилгээний, засаг захиргааны, оюутны хотхон, судалгаа шинжилгээний тээвэр, ложистик олон улсын нисэх онгоцны буудал, агаарын каргоны бүстэй байх, хотын эдийн засаг нь бие даасан байх ба аялал жуулчлал, тээвэр ложистик, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлд үндэслэх, олон улсын жишигээр Шинэ Зуунмод хот дүрэмтэй болж, хууль тогтоомжоор зохицуулагдаагүй хотын амьдрал, үйл ажиллагаатай холбоотой асуудлаа оршин суугчид, иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэж, хот оршин суугчид, хотын удирдлагаа сонгодог болох зэрэг зохицуулалтуудыг тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн нийслэлийн дагуул хот бүр бие даасан хуультай байх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа хилийн цэсийн маргааныг тус хуулиар зохицуулах эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ганболд Шинэ Зуунмод хотын нэршлийн талаар болон газар эзэмших өмчлөх эрх нь хөндөгдөж байгаа орон нутгийн иргэдэд нөхөн олговор олгох болон иргэдэд давуу эрх олгогдож байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын иргэдтэй нэгдсэн зөвшилцөлд хүрсэн эсэх, Шинэ Зуунмод хот нь бие даасан хотын статустай байх боломжтой эсэх талаар асууж, хариулт авсан болно.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын

тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63,6 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний ишлжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын ажлын хэсгийн гишүүд түрүүчийн хуулийн ажлын хэсэгт овог нэр, ажил, албан тушаал нь нэг адил. Протоколд түүгээр тэмдэглэе.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Тасаллаа. Түрүүн зөндөө ярьчихсан даа.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Жигжидийн Батжаргал гишүүн нэмлээ. Жигжидийн Батжаргал гишүүн орохгүй байна гэж байна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Шинэ Зуунмод гэсэн ийм эрх зүйн байдлын

Хотын эрх зүйн байдлын тухай хууль байгаа юм. Тэгээд би ийм л зүйл асуух гээд байгаа юм.

Ер нь бие даасан хот байгуулахтай холбоотой асуудал байгаа юм. Бид нар ер нь 3 хуулиар л бүх харилцаагаа зохицуулж байх шаардлагатай л гэж би боддог юм.

1 дүгээр асуудал нь, энэ Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуультай холбоотой асуудлаар бол нийслэлийнхээ асуудлыг, нийслэлийнхээ дагуул хотын асуудлыг бол энэ хүрээндээ л шийдэж байх ёстой. Бид ноднин баталсан, Их Хурал баталсан Нийслэлийн эрх зүйн байдлын хууль нь дагуул хот гээд хийгээд өгчихсөн. Нэмэх шаардлагатай, өөрчлөлт оруулах шаардлагатай эд нар юм байвал уул нь тэрийгээ л дагуулж явмаар байгаа юм.

2 дахь асуудал, энэ хот байгуулах, өөрчлөхтэй холбоотой, хилийн цэстэй холбоотой асуудал байгаа бол Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиараа л зохицуулна. Өөр хуулиар зохицуулахгүй.

3 дахь нь, Хот байгуулалтын хууль гэж хуулийг бид нар ер нь гаргахгүй хойшоо л яваад байгаа нэг хууль бий. Тэр Хот байгуулалтын хуулийг харин шинэчилж, гаргаад тэр төлөвлөлт нь ямар байх юм, хэн хэрэгжих юм гэдэг гол гол харилцаануудыг нь зохицуулдаг ийм л 3 хууль байх ёстой. Тэгээд би юу гэж хэлэх гэж байгаа юм гэхээрээ заавал нэг хот байгуулахаар л ингээд цаашдаа хууль гаргаад явах уу гэдэг л асуудал байгаа юм.

Дархан, Эрдэнэтийн хууль гээд л гарах нь л байна л даа, дараа нь. Дараа нь Хархорины хууль гээд л гарна. Тийм, тэгээд заавал ингэж хууль гаргах шаардлага байгаа юм уу. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль дотроо дагуул хот гэдгээр энэ жил дагуул хотын хууль гээд байгаа шүү дээ. Дагуул хот гэдэг юмаа ингээд өөрчлөөд, түүнийгээ үнэхээр өөрчилмөөр байвал өөрчлөөд явчхаж

болохгүй байгаа юм уу гэдэг асуудал байгаа юм.

2 дахь асуудал нь, Төв аймагтаа. Төв аймгийн хөгжлийн төлөвлөлт, Шинэ Зуунмод хотын хөгжлийн төлөвлөлт 2-ын хоорондын уялдаа холбоо ямар байгаа юм бол оо. Тэгээд энэ хоорондох газрын хилийн цэстэй холбоотой асуудлууд гээд олон асуудал байгаа байх. Энэ дээр хамгийн чухал юм бид нар иргэдийн саналыг сонсох ёстой. Тийм учраас бол энэ Төв аймгийн яг энэ газар нутагт орж байгаа тэр сумдын иргэд, төрийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллагын саналуудыг авсан юм уу, үгүй юү гэдэг асуудал байгаа юм.

3 дахь асуудал нь, энэ шатлалтай холбоотой асуудал түрүүний хууль дээр уг нь яригдах байсан юм. Би асуух гэж байгаад тэгээд чадаагүй юм. Бид чинь 2 шатлалтай л болгочхож байгаа шүү дээ, хотыг. 2 шатлалтай болох нь сайн тал бий. Иргэддээ үйлчилгээ хүргэх эд нар гээд сайн тал бий. Хороо, хот гэдэг хоёрхон шатлалтай болгочхож байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь хууль санаачлагдаа Дархан, Эрдэнэт эд нар нөгөө 2, 3 сумтай газруудыг татан буулгахдаа шатлалгүй болгочхож байгаа юм. Тэрийг нь өөрсдийнх нь бодвол зөвшөөрсөн л байдаг л байгаа даа гэдэг ийм 3 зүйлийг тодруулъя гэж бодож байна.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд хотын захирагч.

Х.Нямбаатар: Тогтохсүрэн дарга аа, Дархан, Эрдэнэт 2 шатлалтай байж болно гээд сая өргөн барьсан хуулийн төсөл дээр улсын зэрэглэлтэй хотуудыг дагуул хоттой байна, хороотой байна гээд ийм 2 шатлалтай байхаар оруулж ирсэн шүү дээ, 1 дүгээрт.

2 дугаарт, Тогтохсүрэн гишүүний саяын надаас асууж байгаа асуулт бид бол энэ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар шүү дээ. Энэ тэр Хот байгуулалтын

хуулийг бол Монгол Улсын ЗГХЭГ энэ тэрээс асуух нь зөв байх. Тийм. Энэ Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль гээд яагаад оруулж ирсэн бэ гэвэл Улсын Их Хурлын тогтоолоор Засгийн газрыг Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулж оруулж ир ээ гэдэг ийм үүрэг чиглэл өгсний дагуу Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд дурдагдсан дагуул хот байгуулах, тэр дундаа хэд хэдэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг дамнасан ийм дагуул хот байгуулах энэ эрх зүйн үндэслэлийн хүрээнд бид нар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулж, оруулж ирж байгаа.

Шинэ Зуунмод хотын энэ эрх зүйн байдлын тухай хуулийн эрх зүйн үндэс тавигдахаас бараг 13, 4 жилийн өмнө одоогийн энэ 31 мянган га газар нутгийг улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргаад, үүн дээр Барилга, хот байгуулалтын яам ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгээд, 2020 оноос хойших Барилга, хот байгуулалтын сайдын багцаас дэд бүтцийнх нь асуудлыг татаад, одоо ингээд шинээр энэ эрх зүйн байдал нь тодорхой болоод, шинээр захирагч нь томилогдоод, Ерөнхий архитектор нь томилогдоод, зөвлөл нь байгуулагдаад, төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон бусад харилцааны үндсэн дээр Шинэ Зуунмод хот ингээд хөгжлийнхөө гарааг эхлүүлэхэд бүх юм нь бэлэн болчихсон байгаа гэдгийг би Тогтохсүрэн гишүүнд хэлье.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Энэ хууль батлагдаад ингээд Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын ажлууд эхэлнэ ээ гэж ойлгож байгаа. Ер нь яг хэзээнээс эхлээд явах вэ. Та хэдийн төлөвлөж байгаагаар хамгийн богино наад тал нь хэдэн он гэхэд ер нь эхний бүтээн байгуулалтын ажлууд явагдаад үр дүн гарах вэ гэдгийг 1 дүгээрт асууя.

Би уг нь яг Ерөнхий сайдыг байхад л уг нь асуулт асуух гэж л дарсан юм л даа. Түрүүн Ерөнхий сайд нэг ийм юм ярьчихлаа л даа. Засгийн газрын ордныг нь Номтын ам гэнэ үү, Төв аймгийн энд байгуулах зураг төсөв нь бараг хийгдэж байгаа юм шиг юм ярилаа. Тэгэхээр энэ шийдвэрүүдээ парламент энэ нэг шийдвэрүүдээ эцэслэхгүй бол Шинэ Хархорин хот гээд Хархоринд Ерөнхийлөгчийн ордон барих юм шиг. Төв аймагт ингээд Засгийн газрын ордон барих юм шиг, парламент нь энд үлдэх гэж байгаа юм шиг. Ингээд 3 газар ингээд 3 тусдаа юм байх юм шиг л ойлголт төрүүлээд байна л даа. Энэ шийдвэрийг ер нь эцэслэж ер нь хэн гаргах юм бэ? Үнийгээ нэг цэгцэлж, цэгцлэхгүй бол энэ чинь тус тусдаа нэг юм ярьдаг, Ерөнхийлөгч тусдаа нэг юм ярьдаг, Засгийн газар бас тусдаа нэг юм ярьдаг нэг ийм юм руу яваад байна. Үүнийг Занданшатар дарга Их Хурлын дарга нэг хариулт өгөөч. Би уг нь түрүүн энэ Нямбаатар дарга эд нараас хариулт авчихсан л даа. Тэгээд би Ерөнхий сайдыг байвал уг нь энэ хариултыг авъя гэж ингэж бодож байсан юм. Их Хурлын дарга яг ямар бодолтой байгаа вэ гэдгийг.

Би тэгээд түрүүн асууж байсан дахиад бас асууя л гэж бодоод байна л даа. Яг нэршилийн хувьд би Шинэ Зуунмод хот гээд, тэгээд Зуунмод гэдэг нь яг ямар нэршилтэй юм гэсэн. Түрүүн Нямаагийн Энхболд дарга л нэг 1 хэсэг модтой газар байсан тэгээд Зуунмод гээд нэрлэчихсэн л гэсэн л утгатай л юм тайлбарлаж байна лээ л дээ.

Тэгээд дэлхийн улс орнууд бол шинэ хот байгуулахдаа түүхэн улс орныхоо түүхэн хэв маягийг, уламжлалыг, ингээд тэр үеийнхээ том юу гэдэг юм алдартны ч гэдэг юм уу, их гүрнийхээ нэрээр нэрлэдэг. Тэгж байж гадаад, дотоодын хүмүүсийн анхаарлыг татдаг. Түүнээсээ шалтгаалж хотын загвар, дизайн, загвар дизайн нь яг тэр тэр лүүгээ чиглэж, зураг төсөв нь хийгдэж явдаг. Ийм зүйл рүү ер нь анхаарлын төвийг татах дээр бид нар энэ хуулийн төслийг хэлэлцээд явах үед нь

нэршил дээр нь ингээд зарчмын зөрөөтэй санал гаргаад, нийгмийн хэлэлцүүлэг өрнүүлээд, нэршил хотын загвар, дизайн дээр ер нь өөрчлөлт оруулаад явах боломж ер нь байгаа юу? Тэгээд ийм л зүйлүүдийг асууя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Батбаяр.

Тэгээд надаас ямар асуулт асуусан юм. Тэр та чинь Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн биз дээ? Намайг байхгүйд та чинь тийм тогтоол баталчихсан байна лээ шүү дээ. Тэгэхээр та өөрөөсөө асуух ёстой юм биш үү?

Засгийн газарт чиглэл өгөх тухай гээд нүүлгэн шилжүүлэх тухай гээд. Засгийн газрын ордныг. Ямар ч байсан энэ Төрийн ордноос гараад энэ парламентын ордон хэвээрээ үлдэнэ. Энэ бол 126 гишүүнтэй болсноос болж парламентын ордон хэвээрээ үлдэнэ. Энэ саяын баталж байгаа 3 хуулийг дагаад болон Төрийн ордны тухай хууль буюу Парламентын ордны тухай хууль батлагдах ёстой юм.

Ингээд түүнтэй нийцүүлээд “Засгийн газарт чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсан. Төрийн байгуулалтын байнгын хорооноос тодорхой чиглэлүүд өгсөн. Түүн дээр энэ парламентын ордон эндээ үлдэнэ. Парламентын ордноос бол тодорхой хэмжээгээр ЗГХЭГ ч юм уу, Ерөнхийлөгчийн Тамгын газрууд шилжүүлэх тухай тийм чиглэл өгсөн тогтоол батлагдсан байгаа.

2 номер.

Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын захиргааны дарга Батбаяр байна.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Батбаяр Хөшигтийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга.

М.Батбаяр: Гишүүний асуултад хариулъя. Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх энэ төлөвлөгөөний дагуу энэ бүс нутагт 2,1 сая хэтрүүлэхгүйгээр байх ийм төлөвлөлттэй. Түүнийхээ 440000-ыг нь энэ хаяа дагуул хотууддаа суурьшуулахаар төлөвлөсөн байгаа. Тэгвэл Богд хан уулын урд өвөрт 150 мянган хүнийг суурьшуулах ийм төлөвлөлттэй. Энэ бол яагаад гэвэл хот, суурин байгуулахад цэвэр усныхаа нөөц дээр тулгуурладаг. Энэ утгаараа бол 150 мянган хүн суурьшихаар байгаа юм.

2020 оны 55 дугаар тогтоолоор Шинэ Зуунмод хот байгуулах шийдвэр гарснаас хойш бүтээн байгуулалтын захиргаа байгуулсан. Мөн түүнчлэн БХБЯ дээр хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, 2022 онд Засгийн газраар баталж, түүнийхээ дагуу өнөөдрийн байдлаар 2 сайдын багц дээр дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг 22 оноос хойш эхлүүлсэн. Энэ хугацаанд бол хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу бол гол шугам сүлжээний зураг төслүүдийг хийсэн. Үүний дагуу нийт 497 тэрбум төгрөгийн хяналтын төсөвтэй ус, дулаан, цахилгаан холбоо, үерийн далан сувгийг байгуулахаар бол төлөвлөсөн. Түүний дагуу өнөөдрийн байдлаар гэхэд 162 тэрбум төгрөгийн ус хангамж, цахилгаан хангамж, үерийн далан суваг гэсэн энэ ажлууд бол эхлээд өнөөдөр 50 гаран хувьтай явж байна.

Ингэснээрээ мөн энэ 25 оны улсын төсөв дээр хамгийн чухал дэд бүтцүүдийн нэг болох дулааны асуудлыг шийдэх ёстой. Хэрэв ингэж чадаад ингээд 25, 26, 27 онд санхүүжилтийг нь үе шаттайгаар сайн шийдэж чадвал, 27 онд бол энд бүтээн байгуулалтын ажлууд тууз хайчлах боломжтой буюу ус, дулаанаар хангагдах боломжтой. Үүнийг унтаж зохион байгуулалтыг хийх ёстой буюу 25 оноос эхлээд эхний төслүүдийг бол хэрэгжүүлж эхэлнэ ээ гэж ингэж төлөвлөж байгаа.

Энэ бүс нутагт бол цахилгаан, эрчим хүчний хувьд зөвхөн Шинэ Зуунмод хотыг хангахаас гадна Төв аймаг, Төв аймгийн энэ бүс нутаг, Сэргэлэн энэ бүс нутагт эрчим хүчний найдвартай эх үүсвэр бас хангагдаж байгаа гэдгийг хэлье. 2 жилийн хугацаанд цахилгааны асуудлаа маш сайн шийдэж авсан. Сэргэлэн дэд станцын ажил Улаанбаатар хотын баруун талаас эхлээд 76,8км Цахилгаан дамжуулах агаарын шугамыг татсан.

Мөн 2 Аэро сити болон Хөндий дэд станцуудыг байгуулсан. 24 онд гэхэд тухайлбал энэ бүс нутагт бүтээн байгуулалтын ажил эхлэх ийм цахилгааны эх үүсвэртэй болж байгаа. Мөн цэвэр усны эх үүсвэрээ энэ онд бас шийдэж байгаа. Тэгэхээр бүтээн байгуулалтын ажил ийм явцтай явж байна. Дэд бүтцийн хувьд.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Үгүй ээ, энэ хууль орж ирчхээд байгаа юм. Би учрыг нь олохгүй байна. Яг ний нуугүй үнэнийг хэлэхэд. Олон улсын нисэх буудлыг дагуулж хот байгуулах шийдвэр аль эрт гарсан. Төлөвлөлт бүх юм хийгдсэн. Тэр дагуу дэд бүтцийн ажлууд явчихсан. Тэгээд ер нь бид цаашид хот байгуулна гэвэл тэр хот байгуулалт, төлөвлөлт, байгуулалтынхаа хуулийг нэг харах ёстой.

2 дугаарт нь, байгуулагдсан хот нь энэ Хот, тосгоны эрх зүйн байдлынхаа тухай хуулиар зохицуулагдах ёстой. Их Хурал хот байгуулах тусгайлсан шийдвэрээ л гаргах ёстой. Түүнээс хот байгуулах болгондоо ингээд хууль гаргаад байж боломгүй байгаад байгаа юм. Тэгэхээр үүнийгээ ер нь хэдүүлээ юу гэж ойлгож цаашаа явах юм бэ гэдэг нэг ийм асуудал байгаад байгаа гэж.

2 дахь асуудал. Төв аймаг өөрийнхөө хөгжлийг шинэ нисэхтэйгээ уялдуулаад төлөвлөлт, бүх тооцоолол

юмнуудаа хийчихсэн байдаг. Одоо энэ хуульд орж ирэхээрээ дандаа Улаанбаатар хоттой шүтэлцсэн юмнууд орж ирээд байдаг. Тэгээд хажууд нь байж байгаа Зуунмод тэр бүс нутгийн хөгжил энэ хоттой чинь уялдах юм уу, уялдахгүй юм уу. Энэ дотор бол хэллэгт нь байхгүй шүү дээ. Дандаа нийслэлийн тусгай бараг чиг үүргийг хэрэгжүүлэх тухай л юм орж ирээд байгаад байгаа.

Тэгэхээр хэдүүлээ бүсчлэлийн асуудал, шинэ хөгжлийн тухай асуудал ярьж байгаа бол яг тэр хүрээндээ асуудлуудаа харж үзмээр ийм зүйлүүд байгаад байдаг. Үүнийгээ юу гэж ойлгож, энэ хуулийн төсөлдөө үзэл баримтлалаа тусгаж оруулав гэдэг ийм зүйл байна.

Мэдээж энэ хотыг дагасан таталцал, хөгжлийн асуудлууд бол мэдээж тодорхой гарч ирнэ. Үүнийг нь дагуулаад нэлээдгүй олон судалгаа, тооцооллууд хийгдчихсэн байдаг юм. Тэр эдийн засгийн чөлөөт бүсээс авхуулаад, шинжлэх ухаан технологийн парк хүртэл тусгайлсан асуудлууд дандаа яригддаг. Угаасаа анхны хийгдэж явсан төлөвлөлтөд бол эдгээр асуудлууд бүгд тусаж орж явсан. Одоо энэ хуулийг хэдүүлээ батлахдаа 6 үндсэн бүсчлэл, мужлалтайгаар оруулж ирээд байгаа юм билээ. Газар нь тэр 32 мянган га газар нутгийнх нь ангиллыг. Түүн дотор чинь шинжлэх ухаан, технологийнх нь чиглэлийн тэр паркуудын юм чинь ороогүй байгаад байна шүү дээ. Үүнийгээ юу гэж ойлгоцгоох ёстой юм бэ? Үйлдвэр технологийн паркийнх нь асуудал. Үүнийг юу гэж ойлгох вэ гэж.

Зүгээр техникийн маягтай алдаанууд гараад байгаа юм билээ. Энэ дотроо тэр 13.3-ыг энэ тэр та хэд үзээрэй. Би хотын зөвлөл гэхээр зэрэг энэ чинь бараг эрх бүхий байгууллага нь байх юм байна гэж ойлгоод байгаа шүү дээ. Гэтэл хотын захирагч нь хотынхоо зөвлөлийг томилохоор орчихсон байгаад байна лээ шүү дээ. Энэ 13.3 дээрээ. Тэгж болох юм уу энэ чинь. Уул нь хотын зөвлөл нь хотынхоо дүрэм журам, бүх юмыг

баталдаг, хотын захирагчийнхаа тайлан, юмнуудыг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгдөг. Ийм байхаар Хот, тосгоны эрх зүйн байдлын хуульдаа орж ирчхээд байдаг. Гэтэл энэ Шинэ Зуунмодын хуульд болохоор зэрэг хотын зөвлөлөө 3-ыг нь хотын худалдаа, аж үйлдвэрийн танхимаас том хөрөнгө оруулагч нараа оруулаад гаргах, цаад 6-г нь хотын захирагч томилохоор ингээд эрх зүйн зохицуулалт хийгээд оруулаад ирж байгаа нь болох юм уу, болохгүй юм уу энэ чинь. Ийм асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар дарга хариулъя. Хотын дарга.

Х.Нямбаатар: Энэ Батжаргал гишүүн та энэ юуг нөгөө ингэж зориуд буруу хараад байгаа юм уу, эс үгүй бол бид нар танд буруу юм тараачихсан юм уу. Хотын гишүүдээс 6-г нь сонгоно л гэж байгаа шүү дээ. 3-ыг нь Хотын үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийг оролцуулъя, харилцан ийм төлөөлөлтэй байя л гэж байгаа шүү дээ.

2-т гэвэл Батжаргал гишүүн би өглөө танд Байнгын хороо дээр ч гэсэн таны асуултад хариулсан. Улсын Их Хурал 2020 онд 52 дугаар тогтоолоор Алсын хараа 2050 гээд Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийнхээ 9 дээр Улаанбаатар хотыг амьдрахад таатай, байгаль орчинд ээлттэй, хүн төвтэй, ухаалаг хот болгон хөгжүүлэх зорилтынхоо хүрээнд хаяа дагуул хотыг хөгжүүлнэ ээ гээд ингээд заачихсан.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө дээр энэ Шинэ Зуунмод хотын дагуул хотын талаар ингээд маш тодорхой дурдсан. Улаанбаатар хотын цаашидаа хөгжлийн тэлэлт, суурьшлын бүс бол гарцаа байхгүй Төв аймагтай интеграцад орж цаашаа хөгжинө л гэсэн ийм агуулгатай дурдагдсан.

Дээр нь Төв аймгийн хөгжлийн бодлого, Монгол улсын хөгжлийн

бодлогын нэгээхэн хэсэг. Тэр утгаараа Улаанбаатар хотыг хөгжүүлэх 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Төв аймгийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө 2 хоорондоо харилцан интеграцад орно.

Дээр нь нэмээд Төв аймгийн нутаг дэвсгэр дээр хот, сууринууд сүндэрлэхийн хэрээр ажлын байр, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, татварын бааз суурь гээд олон зүйл энэ 2 засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хөгжилд дэмтэй гэдэг агуулгаар энэ хөгжлийн бодлогын урт хугацааны баримт бичигт дурдчихсан байгаа шүү дээ. Тэгээд би үүнээс илүү өөр юу хэлэх вэ дээ. Энэ Их Хурал бид нарыг Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хуулийг оруулж ир гэж Засгийн газарт үүрэг өгсөн. Түүний дагуу л оруулж ирж байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Үгүй ээ, үгүй би адармаалаад бариад байгаа юм байхгүй. Зүгээр энэ надад тарсан материал нь тэгвэл буруу материал тарчхаад байгаа юм байлгүй дээ. 13.3 дээр чинь яг л тэгээд заачхаад л байгаад байгаа зүйл шүү дээ. Тэгээд бас ийм материал ирчихсэн учраас л би зориуд тодруулж асууж байна. Нэг.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байна уу. Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн үг хэлнэ.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Нэг үгээ өнөөдөр 3 давтах болоод байна. Шаардлагатай үед тэгээд ярихаас өөр аргагүй. Өнөөдөр энэ Улаанбаатар хотын нөхцөл байдал маань маш хүнд болсныг би түрүүн хэлсэн дээ. Жаргалтай Улаанбаатар гэж олон жил ярилаа шүү дээ. Улаанбаатар чинь зовлонтой байгаа шүү дээ. Ямар ч жаргал байхгүй. Зуны үер

юу болж байгаа билээ, өвлийн утаа яадаг билээ. Халтиргаа, түгжрэл, энэ үйлчилгээ, хүний төвлөрөл, аж ахуй нэгжүүд хөгжих боломжгүй. Түрүүн би хэлсэн тийм ээ. Тэгээд ийм нөхцөл байдал байгаа учраас бол бид нар энэ хуулийн төслүүдээ бол дэмжихээс өөр аргагүй.

Би тэгээд өөрт чинь хэлээгүй ээ, Ганболд гишүүн ээ, яалаа гэж өөрт чинь хэлэх вэ, тийм. Тэгээд энэ иргэдийн их олон жил хүлээсэн асуудлуудыг шийдвэрлэх ийм заалтууд, ийм шийдлүүд хуулийн төсөлд орсон байгаа юм билээ. Бид бол дэмжиж байж, өнөөдөр энэ улсынхаа нийслэл Улаанбаатар хотынхоо тулгамдсан асуудлуудыг 1 дүгээрт шийдвэрлэх.

2 дугаарт, хот суурин газар ажиллаж амьдрах, суралцах, аж ахуй эрхлэх ийм хүсэл эрмэлзэлтэй байгаа залуу хүн амаа дэмжих ийм давхар бодлого явж байгаа. Батжаргал гишүүн их чухал зүйл хэлээд байна лээ. Өөр хүсэл эрмэлзэлтэй болчихсон нэгэн үеийнхээ асуудлыг бид нар орхигдуулаад ирсэн учраас өнөөдрийн энэ асуудлууд бас үүсээд байгаа юм. Энэ асуудлыг шийдэхэд энэ хуулийн төсөл бол ач холбогдлоо өгнө. Гэхдээ бас эргэж харах, ажлын хэсгийн түвшинд ярилцах, засаж залруулах юм байна гэдэг ийм зүйлүүдийг ярьж байгаа юм.

Үүнийг бол би хууль санаачлагчид задлан эсэргүүцээд байгаа зүйл байхгүй л гэж бодож байгаа. Бид нар том эрх ашгаа харахгүй бол Улаанбаатар хот маань энэ чигээрээ цаашаа явах ямар ч боломжгүй гэдгийг хүн болгон мэдэж байгаа. Тийм болохоор хуулийн төслөө бүгдээрээ хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, тэгээд түрүүний яриад байгаа асуудлуудаа бол хамтраад шийдвэрлэх бүрэн бололцоо байгаа. Бид бол чадна гэж би ингээд итгэж байгаа.

Өнөөдөр Хэвлэлийн эрх чөлөөний өдөр. Манай Улсын Их Хурлын гишүүд бас мэндчилгээ дэвшүүлж байна. Миний хэлэх гэж байгаа зүйл бол мэндчилгээ гэхээсээ

илүүтэй Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр Монгол Улс хэвлэлийн эрх чөлөөний индексээрээ ухарчихсан нөхцөл байдалтай энэ өдөртөө нүүр тулж байгаа нь өөрөө маш харамсалтай. Тийм учраас бол улс төрчид, тэр дундаа Улсын Их Хурал энэ нөхцөл байдлыг засах шаардлагатай. Засагцаая гэж би та бүхнийг энэ өдөр уриалж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

Н.Энхболд: Байнгын хороонд энэ түрүүн би ярьсан юм. Энэ хэд хэдэн аймгууд, хэд хэдэн сумдын одоо оршин сууж байгаа иргэдийн эрх ашгийг бас тодорхой хэмжээгээр тэдний эрх ашигтай зөрчилдсөн шийдвэрүүд гарна. Үндэслэл дээрээ бол бид нар ямар ч тийм асуудалгүй гэсэн байна лээ. Тэгэхдээ бас нэлээн хэдэн жил яригдаж байгаа, энд оролцож ирсэн байдал, хүмүүсээс гарч ирсэн санал энэ тэрийг харахад тийм асуудлууд гарна. Тэгэхдээ тэрийг шийдэх боломжууд бол байгаа гэж харж байгаа. Одоо энэ би тэгээд ямар нөхцөлтэйгөөр үүнийг хэлэлцэх эсэх асуудлыг нь дэмжих гэж байна гэхээр тухайлбал Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумдыг газраас аваад нэлээн том бүтээн байгуулалтын ажилд энэ том төслийн хэрэгжих үндсэн суурь нь тэр хавьд бий болох юм байгаа юм. Зуунмод, Сэргэлэн, Алтанбулагийн. Тэгээд энэ ялангуяа энэ сумдын иргэдийн энэ үйл ажиллагаанд хамрагдаад яг одоогийн байдлаа амьдралын хэв загвар бусад зүйл нь өөрчлөгдөж байгаа энэ улсуудад нөхөн төлбөр олгох, эрх ашгийг нь ямар нэгэн бодол хэмжээгээр бодолцох арга хэмжээг хэлэлцүүлгийн явцад нэмж тусгах боломж байгаа гэж бодож байгаа. Жишээ нь дагаад гарах Засгийн газрын тогтоол дотор энэ асуудлыг тусгайлан бичиж болно, саналаа бичээд өгнө. Жижигхэн ч гэсэн юмнаас болж энэ дэмжлэг нь бас нэмэгдэнэ л дээ. Эргээд ч тэр хүмүүст хэрэгтэй юмнууд гарна. Энэ одоогийн сумдын байгаа газар дээр хот байгуулаад, тэр хот нь нөгөө хот, хөдөөгийн амьдралын ялгааг арилгасан,

илүү их иргэдэд хүртээмжтэй, ашигтай үйлчилгээ үзүүлдэг ийм нөхцөл байдал нь тэр хотуудад үүсэхээр тэр үйлчилгээг авдаг эрх, түүний харьяанд байдаг иргэдийн асуудлыг бодох хэрэгтэй. Бүр амархнаар хэлбэл жишээ нь Алтанбулаг, Сэргэлэнгийн иргэдийг энэ хотын Шинэ Зуунмод хотын уугуул иргэдээр бүртгэж авах хэрэгтэй. Хүсвэл өөрснөө. Магадгүй хөдөө нь байгаа тэндээ амьдар гэж болно л доо.

Тэгэхдээ би Шинэ Зуунмод хотын иргэн баймаар байна. Үүнийг дагаад хотоос авч болох бүх үйлчилгээг авч баймаар байна. Гэхдээ амьдралынхаа хэв загвар, хөдөлмөр эрхэлж байгаа хэлбэр нөхцөл байдлаа өөрчлөхгүйгээр малаа хариулаад, Сэргэлэнгийн урд талдаа ч арай өөр газар ч юм уу шилжээд байж болно. Гэхдээ би энэ хотын иргэн байна гэсэн тохиолдолд тэрийг ямар нэгэн нөхцөл болзолгүйгээр бүртгэж аваад, энэ хүмүүст бас тэр амьдралын хэв загвар нь өөрчлөгдөж байгаа, тодорхой хэмжээгээр ямар нэгэн байдлаар эрх ашиг нь зөрчигдөж байгаа ийм зүйлүүдийг нь заавал тусгах ёстой шүү гэж үзээд хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байна. Ажлын хэсэг гарна, үүнийг бас анхаараарай гэж ажлын хэсгийнхэнд хэлэх байна.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна

Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт явуулъя.
Анхааралтай байгаарай. Санал хураалт.

20 гишүүн дэмжиж, 54,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ.

15.14 цаг

Дараагийн асуудалд орно.

2 хуулийг яс сууж байгаад хэлэлцэж батална шүү.

Цэргийн албан хаагчийн энэ чинь. 2-т байсан хуулийг хойшлуулчихсан.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна.

Ажлын хэсгийг оруулъя.
Содбаатар даргыг индэрт урьж байна.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ. Мөн зүйлийн 1 дүгээр хэсгийн 5-д өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд

төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөн тусламж авах эрхтэй. 19 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасан байдаг.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулиар зэвсэгт хүчин, хил ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч нар тэтгэвэрт тэтгэмж тогтоож олгохтой холбоотой олон салбарын албан хаагчдын нийгмийн хамгаалал, эрх зүйн байдалтай холбогдох харилцааг зохицуулж байна.

Түүнчлэн эдгээр албан хаагчдын нийгмийн хамгаалал, эрх зүйн байдалтай холбогдох харилцааг салбарын хуулиудаар тусгайлан зохицуулж ирсэн юм. Тухайлбал Гамигаас хамгаалах тухай хуулиар онцгой байдлын байгууллагын албан хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн албан хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож, түүнийг гэр бүлд нэг удаа олгоно.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 38.4-д иргэн улсын хилд албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт явдлын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ хуулийн 39.8-д заасан цалингийн дунджаар тооцсон 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

Цагдаагийн албаны тухай хуулийн 86.1-д цагдаагийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын

улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн албан хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож, түүний гэр бүлд нэг удаа олгоно зэрэг тогтоосон байна.

Иймд Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн 10 дугаар зүйлд цэргийн албан хаагчийн хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авах нөхцөл, шалтгааныг зааж өгсөн бөгөөд салбарын бусад хуультай уялдуулан Цэргийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэж яваад, гэмт халдлагад өртөх, гэмт халдлагыг таслан зогсоох, онц байдлын үед хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авах эрхийг нэмж тусгах, түүнчлэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасан шалтгаанаар нас барсан цэргийн албан хаагчийн ар гэрт олгох тэтгэвэр, тэтгэмжийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд цэргийн албан хаагч байлдааны талбар, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, террорист үйл ажиллагааны сөрөг тусгай ажиллагаанд оролцох, байлдааны галт хэрэгслээр буудлага хийх, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай, хорт бодистой үүргийнхээ дагуу харьцах, хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагад өртөх, гэмт хэргийг таслан зогсоох, онц байдал, гамшиг, онцгой нөхцөлийн байдалд ажиллах, улсын хил, онц чухал объектыг хамгаалсны улмаас нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд олгох тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадваргүй гишүүний тооноос үл хамааран 100 хувиар тогтоохоор.

Түүнчлэн тухайн цэргийн албан хаагчийн гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин нэмэгдүүлсэнтэй

тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгохоор тусгалаа.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хот болон орон нутагт 3 өрөө орон сууцын талбайд 60 м²-аас 150 м²-аас хүртэл байх бөгөөд түүнчлэн Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолоор баталсан Орон сууцын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журмын 2 дугаар зүйлийн 2.1.4-д нийт талбайн хэмжээ 80м²-аас ихгүй байхаар зохицуулсан тул 3 өрөө орон сууцын талбайн хэмжээг 80 метр байхаар тооцож орууллаа.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж, санал авсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлыг хүлээн авч, төсөлд тусгасан болно.

Түүнчлэн хуулийн төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын цахим хуудсанд байршуулан иргэд олон нийтийн саналыг авсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын албан хаагчдын гэр бүлд олгох тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэж, нийгмийн баталгаа сайжирч, нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн

бодлогын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч цэргийн алба хаагч байлдааны талбар, энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, байлдааны галт хэрэгслээр буудлага хийх, албан үүргийнхээ дагуу дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай хорт бодистой харьцах, онцгой нөхцөлд ажиллах, хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагад өртөх, гэмт хэргийг таслан зогсоох, онц байдлын үед улсын хил, онц чухал объектыг хамгаалсны улмаас нас барсан цэргийн албан хаагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэжээгчээ алдсаны тэтгэврийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний тооноос үл хамааран 100 хувиар тогтоохоор, түүнчлэн тухайн цэргийн албан хаагчийн гэр бүлд 80 м²-аас доошгүй талбай бүхий орон сууцыг нэг удаа олгохоор ийнхүү олгох орон сууцын үнийн дүнгийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын албан хаагчдын гэр бүлд олгох тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэж, нийгмийн баталгаа сайжирна.

Хуулийн төслөөр иргэн, хуулийн этгээд ямар нэгэн үүрэг хүлээлгээгүй, төрийн байгууллагад нэмэлт чиг үүрэг үүсэхгүй бөгөөд албан үүргээ гүйцэтгэж аваад амь насаа алдсан цэргийн алба хаагчийн гэр бүлд олгох нийгмийн хамгааллын дэмжлэгийг сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулснаар хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгаа сайжирна гэж төсөл санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг Ди парламент.мн цахим хуудаст байршуулан иргэд, олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг хуулийн төсөлд амь насаа алдсан албан хаагчдын ар гэрт олгох тэтгэмжийн санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Идэрбат хилийн анги, салбар, заставт алба хааж байгаа болон бусад ажилчдын цалингийн нэмэгдлийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 77,8 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Жоохон шуурхайлна. Дараа 4 хууль байгаа, бүгдийг нь хэлэлцэнэ. Ирэх 7 хоногт хэлэлцүүлгүүд зохион байгуул гээд хэлчихсэн шүү, та нар.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн гишүүдийг протоколд тэмдэглүүлж танилцуулах ёстой.

Янугийн Содбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Рагчаагийн Батрагчаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх, Дашицэдэнгийн Баасандамба Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан

хамгаалахын бодлогын зөвлөх, Сүнрэвийн Ганбямба ЗХЖШ-ын дарга, хошууч генерал, Хожгорын Лхагвасүрэн Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хилийн цэргийн командлагч, хошууч генерал, Гомбожавын Ариунбуян ОБЕГ-ын дарга, хошууч генерал, Дангаасүрэнгийн Отгонжаргал Сангийн яамны Төсвийн бодлогын газрын ахлах шинжээч, Дангаасүрэн биш Отгонжаргал биш, Мижиддоржийн Санжаадорж Төсвийн бодлогын газрын дарга байна.

Санал хураалт явуулна. Асуулт тасалчихсан шүү дээ.

Адьяаа гишүүн байхгүй байсан. Эндээс харагдахгүй байна. Надад эндээс бол харагдахгүй байна.

Санал хураалт. Асуух юм уу, дэмжсэн үг хэлэх юм уу?

Ганболд гишүүн асуулт асууя. Ганболд гишүүнээр тасаллаа.

Г.Ганболд: Би зүгээр ганцхан асуулт асууя. Уг нь асуудал нь тодорхой учраас. Үүнийг бол дэмжиж байна. Тэгээд угаасаа энэ нөгөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин нэмэгдүүлнэ гэхээр 330 сая байхгүй юу, тийм ээ. Тэгэхээр энэ заавал 80 метрээс доошгүй гэж тавих ямар албатай юм. Хэдийг ч авч болно шүү дээ, тэр хүмүүс цөөн ам бүлтэй гайгүй шиг газар чанартай байр авъя гээд 70м²-ыг авах эрхийг нь яагаад нээж өгөхгүй байгаа юм? Заавал нэг 80 метрээс дээш гээд нэг хямдхан шиг хороололд ав гэсэн үг шүү дээ, энэ чинь. Тэгэхээр, үгүй ээ, харин тийм доошгүй. Тэгэхээр чинь доошийг авч болно шүү дээ. 60 м²-тай маш өндөр зэрэглэлийн байранд яах вэ, нэгэнт насны юм гэж бодоод 330 саядаа цөөн ам бүлтэй байх юм бол 60 м²-ыг авч болно шүү дээ. Хамгийн сайн байрлалтай газар, тийм ээ. Тэгэхээр заавал ингээд хямдхан байр 80-аас дээшийг авах ёстой гэж байгаа юм шиг юм болчхоод байна шүү дээ. Тэгээд үүнийг ерөөсөө мөнгөн дүнг нь тавьчихсан юм чинь 70-ыг авна уу, 100-

гаа авна уу, 30-ийгаа авна уу. Тэр ерөөсөө л заавал тэд гэхийн шаардлага байхгүй. 330 саяд нь л тэр хүн өөрөө яваад л, болно биз дээ, энэ чинь. Хамгийн гайгүй шиг барьж байгаа энэ Хүннү хорооллууд ч гэдэг юм уу, гайгүй шиг байранд би тэр мөнгөндөө тааруулаад л 60 метрийг би авъя гэх юм бол болохгүй гэх гээд байна шүү дээ. Чи заавал 80-ыг олж ирэх гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр би үүнийг нээж өгөөд, ерөөсөө 80м² гэдгийг зүгээр л тэр 330-д нь багтаагаад л нээлттэй орхивол яадаг юм бэ? Тэгээд энэ дээр нэг хариулт авъя.

Энэ чинь үнэтэй байр авахыг л хязгаарласан юм шиг болчхоод байна шүү дээ.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? 4 номерын микрофон, Содбаатар дарга.

Я.Содбаатар: Гишүүний асуултад хариулъя. Энд бид нар энэ удаагийн юугаар 3 юм зохицуулж өгч байгаа. Ер нь бол энэ нийтийн эрх ашгийн төлөө ард түмний амь нас, эрүүл мэндийг хамгаалаад, улс орны чухал объект юуг хамгаалаад, ингээд төрийн цэргийн байгууллагын албан хаагчид нас барсан тохиолдолд 1 дүгээрт, бол нас барсан тохиолдолд тэр ар гэрт нь нэг удаа 10 жил, 5 жил гээд хуульд заасан тэр цалинг нь өгч байгаа юм. Нэг удаа.

2 дугаарт, тэр тэжээгчээ алдсан буюу хүүхдээр нь бодох юм бол хамгийн бага хүүхэд нь 18 нас хүрч, тэр хөдөлмөрийн чадварт хүртэл нь 100 хувь цалинг нь олгодог болгож байгаа юм.

3 дахь нь болохоор бол таны хэлдэг 80 м²-аас доошгүй байр өгдөг болъё гэж байгаа юм. Тэгээд энэ бол өмнөх тохиолдолд нь бол янз бүрээр ингээд байр өгнө гэдгээ л тэгээд нэг 2 өрөө, 1 өрөө байр өгсөн ингээд нэр зүүгээд янз бүр болдог байсан юм байна лээ. Тэгэхээр хэрвээ таны хэлж байгаа 60-ыг авъя, 50-ыг авъя гэх юм бол бэлэн мөнгөө буюу тэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500

дахин нэмэгдүүлсэн мөнгөө авах эрхийг нь давхар нээж өгч байгаа юм.

Тэгэхээр заавал бага авъя гэх юм бол 80-аас доошгүй л юм өгөх ёстой. Тэгэхдээ 60-ыг авъя, 50-ийг авъя, эсвэл байртай айл бид нар мөнгөний өөр хэрэгцээтэй байна гэх юм бол энэтэй тэнцэх мөнгөн хэмжээ буюу 330 сая төгрөг одоогийн ханшаар, мөнгийг авах эрхийг нь нээж өгч байгаа юм. Тэгээд энэ нь бол аль аль боломжтой яаж байгаа. Үнэхээр тушаал биелүүлээд, тэгээд энэ үүрэг гүйцэтгэгч явж байгаад, энэ төрийн цэргийн албан хаагчид нас барж байгаа энэ тохиолдлыг бид нар онцгой авч үзэх ёстой гэж ингэж Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Ерөнхийлөгч үзэж энэ хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсан юм. Баярлалаа.

С.Одонтуяа: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууна. Байхгүй юм уу. Энэ дээр байсан юм.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Дэмжсэн, дэмжээгүй 3 гишүүн.

Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Оюунчимэг гишүүн санал хэлнэ.

М.Оюунчимэг: Хуулийн төслийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Тэгээд саяын хэлээд байгаа ер нь зөрүү, тэр тоо хувь хэмжээ, эдийн засгийн тооцоо, судалгаанууд дээрээ бол нэлээд анхаарч бас ажиллах байх. Энэ ажлын хэсэг гараад хэлэлцүүлгийн явцад бид нар ч гэсэн бас анхаарна. Энэ удаад бол цэргийн албан хаагчидтай холбоотой энэ асуудлаар орж ирж байгаа. Би Байнгын хороон дээр Содбаатар даргаас бас нэг зүйлийг энэ хаврын чуулганаараа оруулж батлах дээр анхаараарай гэж хэлсэн. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн барьсан тэр 4 ба түүнээс дээш хүүхэдтэй ээжүүд, тэдний нөгөө алдарт эх олгохтой холбоотой асуудал дээр зарим нэгэн гэр бүл, ээжүүд нөгөө 4 ба түүнээс

дээш хүүхэд гаргасан ч гэсэн явцын дунд бас 1, 2 нь эндсэн тохиолдол байдаг. Тэгээд тийм ээжүүд, тийм гэр бүл олон байдаг. Тэгээд иргэдтэйгээ уулзаж байхад энэ ээжүүд, энэ гэр бүл төрүүлсэн нь үнэн юм чинь яагаад бид нарыг ингэж ялгаварлаад Алдарт эхийн одонгоо хүртэх энэ асуудал дээр ингээд эгнээнд нь орж чаддаггүй юм бэ, энэ асуудлыг шийдэж өгөөч ээ гээд маш олон хүсэлтүүд ирж байсан. Одоо ч гэсэн уулзахаар ярьдаг. Амьдрал баян юм чинь нээрээ л төрүүлсэн нь үнэн юм чинь энэ тохиолдлыг бас анхаарч үзээд асуудлыг шийдэж өгөөч ээ гээд хүсэлт их тавьдаг.

Тэгээд эмэгтэй гишүүд энэ дээр бас Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бас санаачилга гаргаад ингээд явж байсан. Монгол Улсын Ерөнхийлөгч харин энэ санаачилгыг гаргаад өргөн барих гэж байгаа гэж бид нар ойлгож байгаа. Тэгэхээр энэ хуулийг цаг алдалгүй уг нь хэлэлцээд явчихвал бас хэрэгтэй юм даа. Ийм хүмүүс олон байдаг юм байна лээ. Уулзалт болгон дээр ярьдаг. Тэгэхээр энэ тэр хуулийн төслийг энэ хаврын чуулганаар багтааж оруулж ирэх бололцоо байгаа болов уу гэсэн ийм асуулт байна. Энэ оруулж ирсэн төслийг бол дэмжиж байна.

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн үг хэлнэ.

Б.Энх-Амгалан: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн барьж байгаа Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа.

Ер нь цэргийн албан хаагчид бол тушаалаар явдаг хүмүүс байдаг. Тэд нар мэдлээ, гүйцэтгээ гээд эх орныхоо хэрэгцээтэй газар гал, усны гашуун зовлонд орж явдаг, дайн байлдаанд орж явдаг, энхийг сахиулах үүрэг гүйцэтгэдэг, онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг. Тийм учраас энд эх орныхоо төлөө үүрэг гүйцэтгэж явж байгаад амь насаа алдсан ийм цэргийн албан хаагчийн, ийм онцгой

байдлын байгууллагын албан хаагчийн, ийм цагдаагийн албан хаагчийн, ийм тусгай чиг үүргийн байгууллагын албан хаагчийн ар гэрт олгох тэтгэмжийн асуудлыг бол дэмжиж байгаа юм.

Дээр нь энэ дээр нь бас олон хүүхэдтэй бол 1 хүүхдийг нь төрөөс зардал сургадаг бас асуудал байвал бүр их зүгээр байгаа юм. Тийм учраас энэ цаг үеэ олсон ийм хуулийн төсөл. Тэгээд үүнийг бас дэмжиж байгаа гэдгээ энд бас хэлье.

Цаашидаа энэ эх орны төлөө явж байгаа, тушаалаар ажилладаг, томилогдсон газраа очиж ажилладаг ийм хүмүүсийн ар гэрийн асуудлыг анхаарах, нийгмийн асуудлыг анхаарах, албандаа итгэх итгэлийг нь дээшлүүлэх, нийгмийн баталгааг нь хангах ийм үүрэг бол төрийн чиг үүрэг. Тэгэхээр үүнийг, энэ хуулийг дэмжиж хурдан батлах нь зүйтэй гэж бодож байна.

Г.Занданшатар: Гишүүд дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууслаа.

Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн түрүүн асуулт асуугаад байсан. Тэр наана байсан Цэдэвийн Сэргэлэн сайд ажлын хэсэг хаачсан. Байсан гишүүд асуулт асуучаад гараад явчихаар дуудаж байгаа юм. Ганболд гишүүн суудалдаа сууя. Санал хураалт явуулъя.

Санал хураалт. Бүртгэлийн санал хураалт. Энэ бүртгэлийн санал хураалт шүү, томъёололгүй.

Энэ бүртгэлийн санал хураалт байсан юм. Энэ дэмжээгүй улсуудыг. Энэ улсуудыг тэмдэглэж аваарай.

Ингээд Байнгын хорооны саналаар Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

21 гишүүн дэмжиж, 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Байнгын хороон дээр тэр цолнуудын ялгаа гарчихсан байгааг л нэг анхаармаар байна. Генерал цолуудтай дэмж гэдгийг больчихсон.

15.34 цаг

Дараагийн асуудалд орно.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин бид 2 санаачилж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна.

Ашигт малтмалын тухай хууль батлагдсанаас хойш нийтдээ 30 гаруй удаа өөрчлөлт орж, 300 гаруй зүйл заалт өөрчлөгдсөн байна. Тэгээд 2019 онд Ашигт малтмалын тухай хуулийг Засгийн газраас өргөн барьж, өөрчлөлт орсноор ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлгүй өөрийн ордоггүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүд баяжуулсан бол боловсруулсан бүтээгдэхүүнээ экспортлоход давхар АМНАТ авдаг болсноос хойш нийтдээ 30 гаруй үйлдвэр 50 гаруй тэрбум төгрөгийн өрөнд орж, 1500 гаруй хүн ажилгүй болж, 20 гаруй үйлдвэр энэ баяжуулах болон

боловсруулах үйлдвэрийнхээ төслийг зогсоосон байна.

Үндсэн хуульд заасны дагуу ашигт малтмал бол төрийн нийтийн өмч тул нэг удаа ашигт малтмалын нөөц ашигласны татварыг авах нь зүй ёсны хэрэг ээ гэдгийг онцлон хэлмээр байна. Тэгэхээр энэ хуулийг өргөн барьсаар барьснаар дараах 2 зарчмыг баримталж энэ хуулийг өргөн барьсан.

Тэгэхээр 1 дүгээрт нь, манай улс бол АМНАТ буюу роялтиг олборлолт, баяжуулалт, боловсруулалтын шат бүрд ноогдуулдаг болсон алдааг засаж, олборлолт, баяжуулалт, боловсруулалтыг нь зөвхөн нэг шатад бол ноогдуулдаг болгосон.

2 дугаарт нь, Монгол Улс цаашид нүүрсээ хагас кокс, металлургийн кокс, хий, шингэн түлш, төмрийн хүдрээ хорголжин ширэм, ган, жоншийн хүдрээ баяжмал, кальцийн фтор болгож үйлдвэрлэдэг зөв суурийг тавих ёстой. Эдгээр үйлдвэрлэлийг дэмжсэнээр нэг хүнд ноогдох ДНБ-ийн хэмжээг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Хуулийн төсөл батлагдсанаар агуулга багатай төмрийн болон жоншны хүдэр, нүүрс эдийн засгийн эргэлтэд орж валютын орлого нэмэгдэнэ. Яг өнөөдрийн байдлаар бол бага агууламжтай нүүрс овоолго болоод шатаад, эргэлтэд орж чадахгүй байгааг та бүхэн бүгдээрээ мэднэ. Ажилгүйдлийн тоо буурна. Улсын болон орон нутгийн төсвийн орлого нэмэгдэнэ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, баяжуулах, боловсруулах чиглэлд хөрөнгө оруулалтыг хийж эхэлнэ. Хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн үндэсний хөтөлбөр, Ерөнхийлөгчийн олборлолтоос боловсруулалтад уриалга хэрэгжих үндэс суурь тавигдах юм.

Мөн Шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилтийг дэмжлэг болох төдийгүй бүсчилсэн хөгжилд чухал хувь нэмрээ оруулах юм. Монгол Улсад хүнд үйлдвэр хөгжиж, иргэд нь орлоготой,

төсөв нь татвартай, ажилгүйдлийг шийдэх, хувийн хэвшилээ дэмжсэн тус хуулийг дэмжинэ гэдэгт Улсын Их Хурлын гишүүн та бүхэнд гүнээ итгэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж нарын 2 гишүүн 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2024 оны ,5 дугаар сарын ,2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төсөл санаачлагч АМНАТ-ийг бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинээс хамаарч, хүдэр баяжмал, бүтээгдэхүүний аль нэг давхар тагтуулахгүйгээр ноогдуулах нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал гараагүй болно.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Баагаагийн Баттөмөр гишүүнээр тасаллаа. Болдын Жавхлан сайд асууна.

Б.Жавхлан: Пүрэвдорж гишүүн ээ, үүнийгээ их сайн судалсан биз дээ. Хаанахын юун лоббид орчхов оо. Би таныг их л тулхтай, их сайн, олон талаас нь юмыг хардаг ийм гишүүн гэж бодож явдаг юм шүү дээ. Энэ аягүй том тогтолцооны суурь асуудал шүү. Одоо таныхаар хэрвээ ингэх юм бол наадах чинь бид нар АМНАТ авч чадахаа болино, бүр. Энэ Үндэсний баялгийн сан гэдэг юм чинь бүр утгагүй болж ирнэ. 1 төгрөг ч авч чадахгүй болж ирнэ. Жишээ нь зүгээр би жишээ шүү. Жишээ нь Оюутолгой жишээ нь хажуудаа нэг жижигхэн боловсруулах үйлдвэр тавьчихна. Лиценз байхгүй. Тэгээд тэр лүүгээ түүхий бүтээгдэхүүнээ хүдрээ аваачаад цаашаа баяжуулаад гарахад бид нар АМНАТ авч чадахаа болино. Жишээ нь, зүгээр л жишээ нь.

Тэгэхээр энэ АМНАТ-ыг их сайн ойлгох хэрэгтэй шүү. Энэ чинь ашигт малтмал нөөц ашигласны төлбөр байхгүй юу. Татварын нэг хэлбэр, төлбөр. Ашигтай ч ажиллана уу, алдагдалтай ч ажиллана уу үнийг ард түмэнд төлж байх ёстой ийм төлбөр байхгүй юу. Хэрвээ алдагдалтай ажиллаад байвал хойш нь тавьж байгаад сайн технологи гаргаж ирж байгаад тэр үед нь дахиад л ухаж болно. Тийм зарчмаар шүү дээ. Өөрөөр хэлбэл тэр англи үгийг нь ч гэсэндээ харсан. Роялти гэдэг маань энэ нөгөө хаандаа өргөдөг ийм төлбөр байдаг. Түүнийг нь яг л ийм агуулгатай байхгүй юу. Монгол Улсад бол ард түмэн хаан.

Тийм учраас энэ болохгүй шүү, үүнийг манайх бол дэмжихгүй гэж ингэж өгсөн байгаа. Тийм учраас энэ чинь та давхар гээд байх юм. Тэр чинь суутгаад

суутгаад зөрөөнөөс нь нэмж төлөөд явдаг юм шүү дээ. Тийм, түүнээс энэ давхардсан ойлголт ерөөсөө огт биш.

Тийм учраас үүнийг хэлэлцэж болохгүй ээ, тийм. Бүр батлах нь битгий хэл хэлэлцэж болохгүй.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултад хариулна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яг энэ хуулийн гол концепт бол ямар зүйл рүү явж байна гэхээр 1 дүгээрт, өөрсдөө ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй, өөрийн ордоггүй энэ компаниуд тодорхой жишээ нь Эрдэнэс Тавантолгойгоос бага агууламжтай нүүрс аваад түүнийгээ угаагаад аль эсвэл баяжуулаад гаргалаа гэхэд энэ дээр ямарваа нэгэн тийм коксжуулаад гаргалаа гэхэд ямарваа нэгэн тийм давхар АМНАТ авч байгаа нь бол өрсөлдөх чадварыг бий болгож чадахгүй байна гэж үзэж байгаа юм. Жишээ нь манай Эрдэнэс Тавантолгойгоос Баяннуур аймаг дахь 10 үйлдвэр шууд нэг удаа АМНАТ төлчхөөд түүнийгээ шууд цаашаа гаргаад тэндээ угаагаад кокс болгоод цаашаа явуулаад байгаа юм. Гэтэл Монголд дотооддоо хажуу талд нь нэг Эрдэнэс Тавантолгойн хажууд байгаа нэг угаах үйлдвэр энэ АМНАТ-ыг давхардуулж авах дээр тэр өрсөлдөх чадвар нь ерөөсөө байхгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр одоо энэ асуудал дээр би нэг зүйлийг хэлэхэд жишээ нь Оюутолгой дээр та бол энэ энэ асуудал дээр Эрдэнэт юм уу, энэ дээр бас яг энэ дэлхийн хэмжээний үйлдвэрүүд бол 1 дүгээрт, ийм бохир зүйлийг 1 дүгээрт, хийдэггүй. 2 дугаарт, бол энэ яг энэ хэлэлцүүлгийн явцад ийм үйлдвэрийг байгуулах замаар татвараас зайлсхийх асуудлыг нь бас тодорхой хэмжээнд цэгцэлнэ. 2 дугаарт нь. 3 дугаарт нь бол энэ татвараас зайлсхийх тухай асуудал. Татварын хуулиар бол хангалттай хариуцлага тооцох ийм боломжийг нь бүрэн авчихсан байж байгаа.

Тийм учраас яг энэ асуудал дээр хэлэлцүүлгийн явц дээр Сангийн яамны бас тодорхой саналуудыг оруулаад, аль болох татвараас зайлсхийх, энэ хуулийн заалтаар өөр бусад зүйлийг бохир зүйлийг хийх тэр зүйлийг хааж өгнө гэсэн ийм хариултыг хэлье.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Энэ хуулийн төслийг би бас нэг өргөн барих гэж оролдсон юм. Тэгээд Засгийн газраас энэ дээр бас нэлээн тодорхой асуудлуудыг ярьсан учраас бид нар өргөн барихаасаа татгалзсан юм л даа. Танд яг Засгийн газраас яг ямар хариу ирсэн бэ? Энэ хуулийн төслийг өргөн барихын өмнө. Тэр хариуг нэг надад нэг уншаад өгөөч. Гишүүдэд эсвэл ингээд өөр ялгавартай хандаад байна уу гэж би хараад байгаа юм.

Ер нь та бүхэн АМНАТ-аа ер нь яг ойлгож байна уу, Пүрэвдорж гишүүн ээ. Энэ бол АМНАТ бол лиценз эзэмшигч АМНАТ. шууд экспортод гаргах юм бол АМНАТ төлөгдөнө. Дотоодын худалдан авалтад АМНАТ төлөгддөггүй юм. Дотоодын эрчим хүчний нүүрс гэж жишээлэх юм бол дотоодын компаниуд АМНАТ-гүй авчхаад тэгээд баяжуулаад гаргах дээр зэрэг энэ ерөөсөө огт АМНАТ-гүй явчих гээд байгаа учраас тэрийг жишээлэх юм бол Тавантолгойгоос Эстрато гэдэг компани АМНАТ-гүйгээр нүүрс аваад, баяжуулж гаргаад байсан учраас аль нэг талд нь ер нь АМНАТ төлөх ёстой гэдэг агуулгаар энэ анх тавигдсан юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр таны хэлээд байгаа наад давхар АМНАТ гэдэг юм чинь огт байхгүй байгаад байгаа байхгүй юу. Давхар биш, аль нэг нь төлнө. Давхар АМНАТ огт биш. Наадах төлчхөөд тэр баяжуулж байгаа үйлдвэр төлж байгаа юм огт байхгүй байгаад байхгүй юу. Дотоодын эрчим хүчний нүүрс дээр АМНАТ төлдөггүй. Жишээлэх юм бол Баянтээгийн уурхай ч гэдэг юм уу нүүрс дээр АМНАТ төлдөггүй байхгүй юу. Шууд экспортод гаргаж

байгаа бол АМНАТ төлнө. Тэгэхээр энэ давхар АМНАТ гэдэг юмаа ойлголцлоо зөв болгохгүй бол тэгээд яваад байгаа байхгүй юу тийм ээ. Тэгэхээр энэ давхар АМНАТ биш. Тэгэхээр зэрэг та үүнийг ерөөсөө оруулж ирдэг нэг талаасаа буруу болчихоод байгаа юм.

Би яагаад больсон гэхээр зэрэг яг тан шиг ингэж бодож оруулах гээд тэгээд үүнийг учрыг нь олоод, энэ аягүй бол аль ч талдаа АМНАТ авахгүй юм байна гэж ойлгоод больчихсон юм. Тэгэхээр та үүнийг нэг маш сайн судлаад, энэ дээр нухацтай хандаарай. Бүр тодорхой жишээ бий шүү. Ямар компани хаанаас дотооддоо АМНАТ-гүй авчхаад тэгээд баяжуулаад гаргаж байсан бэ гэдэг энэ ерөөсөө 1 ёсондоо давхар биш шүү.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Их Хурлын гишүүн бол өргөн барьсан хуулийнхаа асуудлаар бол Засгийн газраас бас тодорхой хэмжээний санал авдаг. Энэ санал дээр бол хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн байгаа. Тэгэхдээ би энэ Их Хурлын гишүүн бол өргөн барьсан хууль дээр Засгийн газар зөвшөөрсөн эсэхээс үл шалтгаалан хэлэлцүүлэх өөрийн эрхтэй.

Тэгэхээр би танд нэг ганцхан л зүйлийг хэлье. Жавхлан сайд ч гэсэн бас сонсох нь зүйтэй. Жишээ нь, жишээ нь жоншны үйлдвэр байна. Бид нар хэрвээ энэ жоншоо хүдрээр нь гаргахад бид нар 600 мянган тонн хүдэр гаргадаг юм. Тэр 600 мянган тонноо өнөөдөр бид нар хорьхон сая доллароор зарж байгаа. Гэтэл үүнийг хилийн цаах нь талд Эрээн дээр 2 жоншны баяжуулах үйлдвэр байгаа. Тэд нар баяжуулаад цаашаа 120 сая доллароор зарж байгаа. Түүнийг нь Шинжяньд аваачаад кальцийн фтор болгоод 1,2 тэрбум доллар болгодог. Гэтэл тийшээ хүдэр гарахдаа бид нар нэгхэн удаа АМНАТ авч байгаа. Гэтэл дотооддоо өөрийн ордоггүй нэг ААН

баяжуулах үйл үйлдвэр дээрээ тэр жоншны хүдрийг авлаа гэхэд 5 хувийн АМНАТ дахиж төлж байгаа. Тэгэхээр нөгөө өрсөлдөх чадвар байхгүй болчихоод байгаа юм.

Яг энэтэй адилхан Эрээн дээр жоншны 2 баяжуулах үйлдвэр байна. Баяннуур дээр нүүрсний 10 гаруй угаах болон коксжуулах үйлдвэрүүд байж байна. Энэ рүү болохоор ямар ч тийм давхар АМНАТ-гүй ганцхан удаа АМНАТ төлөөд гардаг. Гэтэл манай дотооддоо угааж байгаа, баяжуулж байгаа тэр үйлдвэрүүд бүгдээрээ давхар АМНАТ төлөөд байгаа байхгүй юу даа. Тэгэхээр энэ дээр бол тодорхой, мэдээж юу байдаг юм ялангуяа зэс дээр. Зэс дээр бол нэг АМНАТ-ын асуудлыг бас энэ сайн авах нь зүйн хэрэг. Энэ дээр бол мэдээж юу байдаг юм, дахиад Эрдэнэт үйлдвэр, мөн түүнчлэн Оюутолгой үйлдвэр дээр яг энэ хажуудаа нэг хамаарал бүхий нэг өөр ААН байгуулчхаад тэндээсээ баяжуулах үйлдвэр байгуулчхаад, тэгээд тэндээсээ АМНАТ-гүйгээр гаргах тийм асуудал гаргаж магадгүй юм. Тэгэхдээ энэ дэлхийн хэмжээний үйлдвэрүүд ийм зүйлийг хийдэггүй, 1 дүгээрт.

2 дугаарт, энэ нь татвараас зугтаах тийм нөхцөл байдал руу илэрхий очих юм бол манай Татварын хуульд бол үүгээр бүрэн зохицуулах боломжтой ийм хуультай байгаа.

Тийм учраас яг энэ асуудал дээр хэлэлцүүлгийн явц дээр тодорхой хязгаарлалтуудыг бас хийж өгөх боломжтой гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Манай Пүрэвдорж гишүүн их олон хууль, оновчтой хууль санаачилдаг. Тэгэхдээ энэ бол болохгүй ээ, Пүрэвдорж гишүүн. Энэ өөрөөр хэлбэл эдийн засгийн хувьд агуулгагүй. Энэ сая яг тэр роялти гэдэг яг тодорхойлолтыг сая Жавхлан сайд хэлчихлээ л дээ. Тэр эзэн хаандаа барьдаг юу гэдэг юм төлбөр гэж.

Манайх бол нэг Үндсэн хуулийн 6.2-оороо энэ чинь ард түмэнд очиж байгаа. Баялгийн сангийн Ирээдүй өв сан бол энэ АМНАТ-ын роялтигийн 65 хувиар байгуулагдана шүү дээ. Тэгээд энэ болохгүй ээ. Цаг үе нь ч биш байна, 1 дүгээрт.

2 дугаарт, Улсын Их Хурлын гишүүд энэ Татварын хууль санаачлаад ингээд явдаг нь тийм их зохистой биш. Эдийн засгийг бол татвар бол эдийн засгийг зохицуулдаг. Энэ утгаараа юу вэ гэхээр Монгол Улсын сан хөмрөг өнөөдөр дутагдалтай байна, ард иргэдийн амьдрал бас ядуу байна. Ядуурлын хэмжээ бол буурахгүй байгаа. Яг энэ үед ингэж орж ирдэг нь буруу гэж мэдэж байгаа.

Үүний оронд бол бид юу хийх ёстой вэ гэхээр энэ Худалдааны хуулиа гаргах ёстой. Бид өнөөдөр дэлхийн зах зээлийн үнэд хүргэж, бараа бүтээгдэхүүнээ худалдаж чадахгүй байгаа шүү дээ. Худалдааны хуульд уншаад байдаг, уншаад байдаг байдаггүй. Энэ баялаг бол тухайн хүн лицензээр эзэмчихээд гаргаж байгаа болохоос биш энэ чинь ард түмэнд очдог шууд үр өгөөж нь ард түмэнд очдог юу шүү дээ.

Тийм учраас энэ дэмжигдэх боломжгүй байгаа. Засгийн газар бол дэмжээгүй. Төсвийн байнгын хороо дэмжээд ороод ирж байхад гайхаж байна. Яагаад ингэсэн юм бол. Энэ чинь 24 оны төсөв батлагдаад хэрэгжээд явж байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр би Тэмүүлэн даргаас асууя. Энэ хууль батлагдсанаар энэ төсөвт ямар өөрчлөлт гарах вэ. Та нар тооцсон уу? Ер нь тухайн энэ роялти гэдэг чинь тухайн бүтээгдэхүүнээсээ төлсөн роялтигаасаа хасагдаад, хасагдаад л явж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ дэмий юм болно. Яг үүнийг дагаад төсөвт энэ ер нь энэ төсөв бүрдэх үйл ажиллагаа роялтид цоорхой үүснэ. Үүнийг бол өөр байдлаар шийдэх нь зүйтэй.

Боловсруулалт хийхийг бүх түвшинд дэмжих ёстой. Тэгэхдээ ард түмэнд шууд очдог энэ роялти гэдэг юмыг хасах байдлаар ингэж зохицуулах нь бол буруу гэж үзэж байна.

Г.Занданшатар: Асуулт нь Тэмүүлэн гишүүнээс асууя. Төсвийн байнгын хорооны дарга. Байнгын хорооноос асууж болно.

Г.Тэмүүлэн: Уг нь хэлэлцэх эсэх дээр хууль санаачлагч л асуудалд нь хариулах ёстой. Дээрээс нь яах вэ нэмэлт тодорхой тооцоо, судалгаа, асуудлуудыг хууль санаачлагчийн хуулийн төсөлтэй холбогдуулж, Сангийн яам өөрсдөө бас энэ дээр тайлбар мэдээллүүдийг бол өгөх байх гэж харж байна.

Манайд бол дээрээс Их Хурлаас энэ асуудал цохогдоод орж ирсэн. Хэлэлцэх эсэхийг нь бол Төсвийн байнгын хороо олонхынхоо шийдвэрээр асуудлаа хэлэлцсэн. Хэрэв Улсын Их Хурал дээрээс хэрэв хэлэлцэх эсэхийг нь дэмжих тохиолдол бол бид нар цаашид холбогдох тооцоо, судалгаа, юмнуудыг бол үзэж хараад ингээд судлаад явна л гэдгийг Баттөмөр даргын хувьд хариулах байна. Та бас өөрөө Байнгын хорооны дарга. Хэлэлцэх асуудал дээр байнгын хороо олонхоороо л асуудлаа шийдээд явдаг гэдэг л хүн байна.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, хууль санаачлагч.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр мэдээж роялти буюу эзэн хааны татвар гэж яригддаг энэ татварыг бол дэлхийд бүгд авдаг. Үүнийг бол нэг удаа л авдаг юм. Дахин дахин авдаг тохиолдол бол ерөөсөө манай Монголд л байгаа. Дэлхийд ганцхан улсад байгаа. Ийм учраас ер нь бол яах вэ, татварын цоорхой үүсэх вий гэж асууж байх шиг байна.

Тэгэхээр энэ 2019 оноос өмнө энэ давхар АМНАТ авдаггүй байж байхад нийтдээ улс, орон нутгийн төсөвт 50 гаруй тэрбум төгрөгийн татвар

хураамж төлөөд явдаг байсан. Гэвч өнөөдөр энэ байхгүй болсон байгаа. Нийтдээ 30 гаруй үйлдвэр, 50 гаруй тэрбум төгрөгийн өрөнд орчихсон байж байгаа. Та бас яг Дархан-Уул аймгаас сонгогдсон хүний нэг. Дархан-Уул аймгийн Засаг дарга Азжаргал гэдэг хүн энэ давхар АМНАТ авдаг болсноос хэдэн үйлдвэр бүгдээрээ хаагдаад аймгийн, орон нутагт ордог төсөв бүгдээрээ байхгүй болчихлоо гэж халаглаж сууж байгаа.

Ийм учраас энэ өөрөөр хэлбэл энэ давхар АМНАТ-аас болоод өрсөлдөх чадваргүй болсны үндсэн дээр олон олон үйлдвэрүүд хаагдаад байна. Дахиад 8, 9 үйлдвэр ашиглалтад ороход бэлэн, төслөө асаахад бэлэн. Гэвч энэ давхар АМНАТ-аас болоод тэртээ тэргүй өрөнд орно гэдэг ийм байдлаар төслөө эхлүүлж чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ асуудал дээр бас та бүхэн энэ хуулийг дэмжээд, хэлэлцэх эсэх асуудал дээр нь ярилцаад, бас тодорхой Сангийн яамны саналуудыг оруулаад, хэлэлцэх нь зүйтэй. Жавхлан сайд аа, та бас яг тэр Азжаргал даргаасаа бас асуугаарай. Яг Дарханаас сонгогдсон хүний хувьд. Яг энэ орон нутаг дээр ямар нөхцөл байдал бий болоод байгаа юм бэ гэдэг нь.

Дээрээс нь та нарын энэ юун дээр төсөв дээр цоорхой үүснэ гэдэг ийм зүйл чинь ерөөсөө байхгүй. Харин үйлдвэрүүд ашиглалтад орсноор, ажиллаж эхэлснээр, харин төсөвт ордог орлого чинь хамаагүй илүү нэмэгдэнэ ээ гэсэн ийм л зүйлийг хэлье.

Г.Занданшатар: Гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооноос асуулт асууж дууслаа.

Одоо дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу. Энэ 3 гишүүнээр

тасаллаа. Болдын Жавхлан гишүүн үг хэлье.

Б.Жавхлан: Яах вэ, Пүрэвдорж гишүүний санаа нь үйлдвэрүүдээ дэмжье гээд байх шиг байгаа юм. Боловсруулах үйлдвэрүүдээ дэмжих, баяжуулах үйлдвэрүүдээ дэмжих бид нарт өөр татварын маш олон төрөл боломжууд байгаа. НӨАТ-ыг нь хойшлуулж байна, тоног төхөөрөмжүүдийг нь бүгдийг нь гаальгүй болгож байна. Өөр зах зээлтэй нь холбож өгөх бидэнд өөр маш олон тусалж болох, дэмжиж болох боломжуудаа ашиглаад явж байгаа.

Харин тэр нэр доор үйлдвэр гэж байгаа тэр нөхдийн энэ бүр ийм захиалгаар ч юм уу, ийм лобби ч юм уу, энэ хэд хэдэн удаа орж ирж байсан юм. Өмнөх 4 жилд ч гэсэн нэг удаа орж ирээд ингээд Их Хурлын босго даваагүй. Үүнийг ерөөсөө хэрхэвч болохгүй. Өсөн нэмэгдэж байгаа АМНАТ гээд та тэрийгээ өөрөө сайн ойлгохгүй байх шиг байна. Энэ чинь ингэнэ шүү дээ. Би танд бүр маш ойлгомжтой хэлье. Таныхаар бол дотооддоо ингээд гэрээгээр зараад явчхаж болно. Тэр чинь аягүй хямдхан зарагдчихна. Тэндээсээ ганц удаа АМНАТ төлөөд дахиж ерөөсөө АМНАТ-гүй нэг үйлдвэрээр туг тойруулаад л ямар ч АМНАТ-гүй цаашаа гараад явчихна. АМНАТ гэдэг чинь өөрөө ард түмэнд төлж байгаа төлбөр.

Тэгэхээр аль болох ард түмэнд энэ төлбөрийг төр өндөр л авч өгөх хэрэгтэй. Үүрэг зорилго нь өөрөө тийм. Өөр тусламж үзүүлье гэж байгаа бол татварын өөр маш олон боломжууд байж байдаг. Одоо энэ хууль хэрвээ ингээд батлагдаад хэрэгжээд явах юм бол маргаашаас нь л тал АМНАТ байхгүй болно. Энэ жилийн тал АМНАТ-ын орлого байхгүй болно. Ирээдүй өв сангаа бид санхүүжүүлж чадахгүй болно. Нөгөө Баялгийн сан гэдэг юм чинь ерөөсөө огт байхгүй болчихно. Баялгийн сангийн гол суурь ойлголт нь энэ АМНАТ шүү дээ. Гэтэл АМНАТ-аа больё, авахаа больё, дотооддоо зарагдсан жишиг хамгийн

бага үнээр гэрээний үнээр авдаг больё гэсэн ийм санаа. Ерөөсөө огт болохгүй. Үүнийг огт бид нар хэлэлцэж ч болохгүй. Дэмжихгүй байна.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ хуулийн төслийг бол би зарчмын хувьд бол дэмжиж байгаа юм. Пүрэвдорж гишүүн, Энхтүвшин гишүүд ингээд санаачилсан. Энэ хууль чинь их олон жил яригдаж байгаа шүү дээ. Маш олон үйлдвэрүүд чинь яг үүнээс болоод хаалгаа барьсан байхгүй юу. Олон үйлдвэрүүд хаалгаа барьсан, олон хүн мянган хүн ажилгүй болсон. Тооцоогоор бол 1500 гаруй хүн ажилгүй болсон юм байна. Ер нь ирж байгаа гомдол бол тийм шүү дээ, энэ Засгийн газар хувийн хэвшилээ дэмжихгүй байна л гэдэг шүү дээ. Та нар ЖДҮ-г нь ч дэмжихгүй, томыг нь ч дэмжихгүй, боловсруулах үйлдвэрийг нь ч дэмжихгүй байгаа. Тэгэхээр энэ дээр энэ гишүүдийн дунд нэг жоохон ойлголтын зөрөө байх шиг байна.

Тийм учраас сая бас бүлгийнхэнтэйгээ зөвлөлдлөө. Бүлгийн дарга намайг өмнөөсөө үг хэлээд энэ хууль дээр АН-ын бүлгээс 5 хоногийн завсарлага авч байна.

Г.Занданшатар: Ирэх 7 хоногт чуулган хуралдахгүй, энэ чинь. Завсарлагааг дараа нь өгье.

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Энэ давхар АМНАТ-ын асуудлыг өнөөдөр шийдэх ёстой. Өнөөдөр нэг юмнаас 2 татвар авдаг ийм тогтолцоо Монголоос өөр байдаг юм уу? Инээх юм бол байхгүй шүү, Тогтохсүрэн дарга аа. Та энэ Жавхлан та 2 ингээд л энэ бүгдийг мэддэг юм шиг битгий ингэ ээ. Ер нь эцсийн эцэст энэ нэг юмнаас 2 татвар авдаг, тэгээд 1 бол та нар ингэчих. Улаанбаатарт 1 татвар, Дарханд 1 татвар тавьчих. Зөвшөөрөх үү? Зөвшөөрч чадахгүй шүү дээ.

Өнөөдөр ийм байдлаар улсын төсөв үнэ бүрдүүлж байна гэдэг нэрийн доор ийм муухай нугалаа битгий хий. Пүрэвдоржоос өөр хүн энэ хуулийн төслийг өргөн барьсан бол та нар яаралтай горимоор оруулж ирээд, бүгд энд ярс хийтэл гараа өргөх байсан юм. Ингэж улс орныхоо эрх ашгийн төлөө, сөрөг хүчнийхээ гишүүдийн оруулсан юмыг зөв байсан ч л эсрэг дардаг. Буруу байсан ч эсрэг дардаг энэ юм чинь явцгүй шүү. Үүнийг та бүгдээрээ Монгол Улсынхаа эрх ашиг, нийт Монгол Улсын эрх ашгийн төлөө л энд ажиллана гэж гарч ирсэн. Тэгэхээр Пүрэвдоржид дургүй байж болно. Тэгэхдээ Монгол Улсынхаа энэ эдийн засгийг, Монгол Улсынхаа энэ татварын бодлогыг, энэ үйлдвэрлэлээ дэмжье, Шинэ сэргэлтийн бодлого гэж ярьж байгаа биз дээ. Тэгэхээр энэ дээр ийм зарчимгүй, ийм байдлаар ажиллахаа больцгооё оо л гэж бодож байгаа.

Сангийн сайд ойлгохгүй биш, ойлгохын дээдээр ойлгож байгаа, ойлгохыг хүсэхгүй байгаа, эсэргүүцэхийн тулд эсэргүүцэж байгаа. Ийм л бодолтой байна. Энэ хуулийг дэмжиж батлах нь Монгол Улсын эдийн засагт, Монгол Улсын татварын бодлогод, үйлдвэрлэлээ дэмжье, сэргээе гэдэг танай Засгийн газрын бодлого чинь л хэрэгжих үндэс суурь болно шүү гэдгийг л хэлье.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

АН-ын бүлэгт ажлын 5 өдрийн завсарлага өглөө.

Сая ерөнхийд нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зөв зүйтэй татварын бодлого цогцын ийм реформ хийх нь зүйтэй. Энэ дээр Тэмүүлэн даргаар ахлуулсан ажлын хэсэг, энэ НӨАТ, ер нь аж үйлдвэрийн сэргэлтийг дэмжих, татварын реформын ажлын хэсэг байгуулагдаад төсөл бэлэн болчихсон байгаа. Тэр хүрээнд бас хамтраад хэлэлцэж болно.

Тэгээд Адьшаа гишүүнд бас нэг захиж хэлэх зүйл байна. Үүнийг ард иргэдээс захисан юм. Маш олон ард иргэд. Жишээлбэл Архангай аймгийн Булган сумын иргэн Ням гуай шиг санаж байна. Ням гэж хүн ингэж захиж байна лээ. Сөрөг хүчин гэж битгий нэрлэж байгаач ээ, ингээд л бүх юмыг сөрөхийн нэр юм шиг. Тэгээд сөрөөд байхаар чинь энэ чинь юм чинь батлагдахгүй. Үгүй ээ, та өөрөө сөрөг хүчин гээд хэлчихсэн байхгүй юу. Үндсэн хуулийн нэр томьёо нь олонх, цөөнх гэж байгаа юм. Олонх цөөнх гэдгээрээ л явж байх нь зүйтэй шүү, Тийм, тийм.

Ингээд ажлын 5 хоногийн завсарлага.

16.01 цаг

Дараагийн асуудалд орно.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд танилцуулна.

Н.Энхболд: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Энхболд, Адьшаа, Батжаргал, Бат-Эрдэнэ, Баделхан, Баттөмөр, Бейсен, Дамдинням, Учрал, Мөнхцэцэг, Одонтуяа, Пүрэвдорж, Цэрэнпунцаг нарын 14 гишүүнээс Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, 2024 оны 05 сарын 02-ны өдөр улсын их өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Уг хуулийн төслийг санаачлан боловсруулах хууль зүйн болон практик шаардлагуудын талаар танилцуулъя.

1 дүгээрт, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хүн амын бүлгүүд, тухайлбал,

ахмад настан хагас цагаар гэртээ зайнаас ажиллах уян хатан зохицуулалтыг бий болгох, мөн ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээний нэгдсэн цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг тусгасан байдаг.

2-т, 2017 онд шинэчлэн найруулсан ахмад настны хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа. Жишээ нь ахмад настанд зөвлөгөө өгдөг, явуулын үйлчилгээ болон өдрөөр эмчилдэг, асран сувилах үйлчилгээ зэрэг шинэ төрлийн үйлчилгээг бий болгож иргэн, ААН, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэхээр тусгасан ч, энэ чинь 17 онд шүү дээ. Санхүүжилт дутмаг, хэрэгжилтийг хангах зохицуулалт сул байгаагаас болоод ахмад настанд дээрх үйлчилгээнүүд хүрэхгүй байна.

3 дугаарт, хүн ам зүйн өөрчлөлтийн улмаас нийт хүн амын дунд ахмад настнуудын эзлэх хувь их хурдацтай өсөж байгаа. Энэтэй уялдаад иргэдийг насжилтад бэлтгэх, ахмад настанд үзүүлэх урт хугацааны цогц тусламж, үйлчилгээний болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг сайжруулах шаардлага тулгараад байна. ҮСХ-ноос 2020 онд гаргасан судалгаагаар нийт хүн амын 10, 5 хувь буюу 10 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс нааш настай хүн байна, 22 оны байдлаар. 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох магадлалтайг ингээд тооцоолсон байж байгаа. Үүнийг бас харгалзаж үзэх хэрэгтэй байна.

Сүүлийн жилүүдэд ахмад настны эсрэг энэ хүчирхийлэл нэмэгдэж байна. 20-22 оны байдлаар Хүчирхийллийн үндэсний төвд хандсан энэ ахмад настны эсрэг үйлдэж байгаа хүчирхийллийг хэлбэрээр нь авч үзвэл, эдийн засгийн хүчирхийлэл бараг 40 хувийг нь эзэлж байгаа, 36 гаруй хувь. Энэ, энэ олон зүйлүүдийг харгалзаж үзээд бид нар ахмад настны цогц урт хугацааны тусламж, үйлчилгээний тогтолцоог

бүрдүүлж, хөгжүүлэх, санхүүжилтийг нь тодорхой болгох, ахмад настан бүр нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих, энэ олон талтай бодлогыг баталж хэрэгжүүлэх, ахмад настныг хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд буруутай этгээдэд үзүүлэх Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн шийтгэлийг тодорхой болгох шаардлагатай гэж үзэж энэ хуулийн төслийг нь 14 гишүүн санаачилсан. Одоо та бүхнээр хэлэлцүүлэх гэж байна.

Энэ хуультайгаа холбогдуулаад Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг 10 гаруй хуулийн төслийг боловсруулсан. Энэ хуулийн төслүүдэд юуны өмнө ахмад настанд үзүүлэх ахмад настны цогц үнэлгээ, тэдэнд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ, ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээнүүд, асрамжийн үйлчилгээ, сэргээн засах үйлчилгээ ийм тусламж үйлчилгээний мэргэжлийн удирдлага зэрэг нэр томъёонуудыг шинээр тодорхойлж оруулсан.

2 дугаарт, ахмад настны цогц үнэлгээ, тусламж үйлчилгээний заавар, үйлчилгээний үнэ тариф болон үйлчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон ахмад настны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүдтэй хамтран батлах, санхүүжилт үйлчилгээтэй холбох зардлыг Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсөв, ахмад настнуудын сайн дурын оролцоотойгоор бас санхүүжүүлэхээр тусгасан байгаа.

3-т, төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжийг ашиглаад Ахмадын өргөө, Ахмадын төв, Сэргээн засах төв, Идэвхтэй насжилтыг дэмжих төв, дасгалын клубүүд, олон нийтийн төв ажиллуулах юм бол тухайн барилга, байгууламжийн барилга байгууламж,

хөдлөх хөрөнгийн ус, дулаан, цахилгаан зэрэг ашиглалтын зардал, мөн засварын зардлыг нь орон нутгийн төсвөөс хэсэгчлэн эсвэл бүрэн хариуцан санхүүжүүлэхээр хуульчилж тусгаж байна.

4 дүгээрт, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд жилд 1 удаа олгодог үйлчилгээнүүд. Үүний дотор түлш худалдан авах, орон сууцын хөлс төлөхөд дэмжлэг үзүүлэх, протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг 5 жилд 1 удаа үзүүлж байгааг 3 жил болгох. Ахмад настан зөвхөн рашаантай цөөн хэдэн сувилалд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр сувилуулж байгаа одоогийн байдлыг өөрчилж, магадлан итгэмжлэгдсэн сувиллууд болгон нэмэгдүүлэх зэргээр ахмад настны нэн тэргүүний хэрэгцээ, тэдний саналд үндэслэсэн энэ заалтуудыг тусгасан.

5-д, ахмад настны асрамжийн үйлчилгээний нэр төрийг нарийвчлан зааж өгч байна. Тэдгээр үйлчилгээг нь иргэн, ААН, төрийн болон ТББ-аар дамжуулан төлбөртэй, эс үгүй бол бага төлбөртэй, төлбөргүй зэрэг олон хэлбэрээр үзүүлж болохоор түүний санхүүжилт үйлчилгээний удирдлага зохион байгуулалтын зохицуулалт, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний хөдөлмөр ачааллыг үнэлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх заалтуудыг тусгалаа.

Түрүүн хэлсэн тэр ахмад настны эсрэг гэмт хэрэг, түүний дотор эдийн засгийн гэм гэмт хэрэг, хүчирхийлэл нэмэгдэж байгаатай холбогдуулаад энэ хэлбэрийг нарийвчилж тодорхойлоод, тэгээд энэ түүний төлөө хуулиудад хариуцлагын заалтуудыг нь тодорхой болгож тусгалаа.

Ахмад настны орлогын тогтвортой эх үүсвэр хангах зорилгоор ахмад настнуудын тэтгэвэртээ гарсны дараа хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах,

ахмадууд болоод ахмадууд өөрийнхөө ур чадварыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах боломжийг бүрдүүлэх, мэргэжил, туршилага, ур чадварт түшиглээд залуу үеэ сургах чиглэлээр тодорхой ийм хэрэгжиж болохуйц энэ заалтуудыг тусгаад энд нь ахмадын байгууллагууд ямар статустай чиг үүрэг, санхүүжилттэй орох талаар тодорхой заалтуудыг тусгасан.

Энэ хуулийн төслүүдийг боловсруулахдаа бид нар Хөдөлмөр, нийгмийн халамжийн яам, энэ чиглэл дээр судалгаа хийдэг хуулийн төсөл дээр ажиллаж үзсэн хуулийн компани, ахмадуудынх нь өөрсдийнх нь оролцоо, ахмадуудад үйлчилгээ үзүүлдэг төрийн болоод бусад төрийн бус байгууллагуудтай олон удаа санал солилцох, хэлэлцэх ийм зүйлүүдийг хийсэн, саналуудыг авсан. Улсын Их Хурал дээр 27 хүнтэй Лобби бүлэг байгуулаад, тэд нараасаа саналыг нь авч тусгаж, нэмэрлэсэн ийм хуулиуд болсон гэдгийг хэлье.

Ингээд та бүхэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэн хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын гишүүн Энхболд, Адъяаа, Баделхан, Батжаргал, Баттөмөр, Бат-Эрдэнэ, Баярсайхан, Бейсен, Дамдинням, Мөнхцэцэг, Одонтуяа, Пүрэвдорж, Учрал, Цэрэнпунцаг нараас 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын

байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын хүн ам зүйн бүтэц сүүлийн 10 жилийн хугацаанд хурдацтай өөрчлөгдөж, тэр дундаа ахмад настнуудын тоо өсөж байгаатай холбогдуулан ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, эрүүл, урт удаан, ая тухтай амьдрах нөхцөл бүрдүүлэх, хуримтлуулсан мэдлэг, ур чадвараа хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг нэмэгдүүлэх, шаардагдах санхүүжилтийг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар ахмад настны урт хугацааны асаргаа, үйлчилгээ, эрүүл насжилтыг дэмжиж, эрүүл мэнд, нийгмийн оролцоо сайжирч, улмаар эмнэлэгт хэвтэх, эм худалдан авах зэрэг Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний зардал аажмаар буурах эерэг нөлөөтэй юм.

Мөн иргэн, ААН, ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх үйлчилгээг дэмжсэнээр ахмад настны болон мэргэжлийн байгууллагуудын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засагт сайнаар нөлөөлж, ахмад настан өөрийн сонголтоор олон төрлийн төлбөртэй үйлчилгээг сонгож болохоор тусгасан байна.

Энэ хүрээнд ахмад настанд төрөөс үзүүлэх дэмжлэг, үйлчилгээнд хамрагдах хүний тоо өсөж 43,6 гаруй тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгө шаардагдана гэж төсөл санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг Ди парламент.мн цахим хуудаст байршуулан иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Идэрбат хуулийн төсөлд Ахмад настны герентологийн үндэсний төвийн асуудлыг хэрхэн зохицуулах, Ахмад настны тухай хуульд ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор ААНБ-ын төсөв, үйл ажиллагааны орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр тооцож, ахмадын сантай байна гэж заасан боловч аудитын байгууллагаас акт тавьдаг асуудлыг хэрхэн зохицуулах талаар, орон нут нутагт ахмадын чөлөөт цагаа өнгөрүүлэх байрны асуудлыг тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сонсох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг хуулийн төсөлд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн эрхлэлтийн асуудлыг хэрхэн тусгасан талаар, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хэрхэн уялдуулж байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Чинзориг хуулийн төсөлд хүнийг ахмад болсны дараа асран халамжлах биш ахмад болоход нь бэлтгэх талаар тусгах, Ахмад настны тухай хуульд ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор ААНБ-ын төсөв, үйл ажиллагааны орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр тооцож, ахмадын сантай байна гэж заасан боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг анхаарч, ахмад настнуудыг ажил хөдөлмөр эрхлэх боломжоор хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн хуулийн төсөлд ахмадуудад сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг тусгах талаар, тэтгэвэрээрээ ая тухтай асрамжийн цогц үйлчилгээг авдаг байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа хуулийн төсөлд ахмад настны судалгааны байгууллагыг байгуулах, чанартай насжилтыг нэмэгдүүлэхийг тусгах талаар, ахмадууддаа асрах үүргээ

биелүүлээгүй иргэдэд хуулийн хариуцлага хүлээлгэх эсэх талаар саналаа хэллээ.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 88,9 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Аубакир гишүүнээр тасаллаа. Ганибалын Амартүвшин гишүүн асуулт асууя.

Г.Амартүвшин: Баярлалаа. Би хууль санаачлагчаас нэг асуулт тодруулъя. Өнгөрсөн 7 хоногт, энэ 7 хоногт би Хан-Уул дүүргийн бүх хороодын

ахмадуудын төлөөлөлтэй уулзсан юм. Тэгээд маш олон зүйл ярьж байна. Мэдээжийн хэрэг тэтгэвэр, тэтгэмж нэмсэн талаар бол аягүй сайн сайнаар хандаж байна. Зүгээр ийм асуулт тавиад байгаа юм. Ахмадууд бид нар 30, 40 жил төрд ажилласан ч байдаг юм уу, ер нь ажил эрхэлж байгаад тэтгэвэртээ гарсан. Одоо гэхдээ бид нар мэргэжлийнхээ дагуу үргэлжлүүлээд ажиллах сонирхолтой байна. Бид нарын залгамж халаа гэдэг юм чинь бас алдагдчихаад байна. Бид нар өөрийнхөө туршилагаасаа амьдралын туршилага, ажлын туршилага, мэргэжлийн боловсрол энэ бүхнээсээ бас хуваалцаж, бусад залуу үедээ бид нар бас манлайлал үзүүлэх тийм боломж үзүүлээч. Тийм ажил эрхлэлт хийх боломж байна уу? Тэгэх юм бол бид нар бас зүгээр гэртээ суугаад байхгүй, ажил хийж, хажуугаар нь бас тэтгэврийнхээ гадуур нэмэлт орлого олох, НДШ-ээ төлөх тийм боломж байна уу гэдэг ийм асуултууд бас нэлээн асууж байна лээ шүү. Энэ талаар та нар нэг тодорхой хариулт өгнө үү? Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг танилцуулъя. Протоколд тэмдэглүүлнэ.

Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Болдын Ундрал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын зохицуулалтын газрын дарга, Юрагийн Отгонбилэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, Сэмбэдоржийн Жаргалсайхан Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын шинжээч, Нэргүйн Энхбат Юзисан партнерс хуулийн фирмийн зөвлөх хуульч.

3 номер. Ажлын хэсгийн 3 номер. Хэн билээ? Нэрээ хэлээд.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны шинжээч Отгонбилэг байна. Амартүвшин гишүүний асуултад

хариулъя. Энэ Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр энэ 9 дүгээр зүйл дээр нэлээн хэдэн заалт нэмсэн байгаа. Ахмад мэргэжилтний яг зөвлөгөө өгөх үйлчилгээ гэдэг энэ үйлчилгээ бол яг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийн хүрээнд явагдаж байгаа. Үүнээс гадна Хөдөлмөрийн сайд холбогдох сайд нартай хамтраад ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, дээрээс нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг нэмэгдүүлэх заалтууд тусгасан. Тийм. Тэгэхээр таны асуусан асуултууд энэ хуулийн төсөлд үндсэндээ туссан байгаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Энэ хууль бол маш чухал хууль орж ирж байна. Үүнийг бид нар хэлэлцэж батлах нь зүйтэй гэж. Бидний сайн сайхны төлөө зүтгэж явсан ахмадууд өнөөдөр хамгийн бага тэтгэвэр авч байгаа. Тэгээд дээрээс нь сая илтгэлд гарч байна. Танилцуулгад. Хүчирхийлэлд маш их өртдөг юм байна. Ялангуяа эдийн засгийн хүчирхийлэл 40 хувь гэж байна шүү дээ. Энэ чинь аймшигтай тоо шүү дээ энэ чинь. Тийм ээ. Тэгээд сая 1 судалгаа гарсан байсан. Манай ахмадуудын бараг 21 орчим, 21, 2 орчим хувь нь сэтгэл гутралын тийм эмгэгтэй болсон гэж байгаа. Тэгээд энд их олон учир шалтгаан байдаг байх л даа. Тэгээд энд бол тэр ар гэр, үр хүүхдүүдийнх нь асуудал гээд янз бүрийн л юмнууд нөлөөлдөг байх. Нийгмийн энэ халамж үйлчилгээтэй ч холбоотой янз бүрийн юмнуудаас болж энэ гутралууд үүсдэг байх гэж бодож байна.

Тийм учраас энэ сэтгэл гутрал гээд энэ тэ танай яаман дээр судалгаанууд байна уу. ЭМЯ дээр судалгаанууд байна уу? Энд хариулаач. Энэ нэг эмч нар энэ дээд сургуулийн багш нар яг нэг ид хүнд мэдлэг өгдөг, хүнд хүнийг авардаг тэр насан дээрээ

тэтгэвэрт нь хөөгөөд гаргачихдаг байхгүй юу. Ялангуяа эмч нарын хувьд бол. Насаараа мэс засал хийсэн эмч нар, тэгээд насаараа оюутнуудад хичээл заасан багш нар яг тийм алт шиг цаг дээрээ тэтгэвэрт гарч байгаа юм л даа. Гаргачхаж байгаа юм л даа. Тэгээд энэ их харамсалтай л байгаа юм л даа. Энэ ер нь дэлхийд энэ ахмад улсууд засаглаж байна шүү дээ. Америкийн Ерөнхийлөгчид өрсөлдөж байгаа энэ 2 хүнийг та нар насыг нь мэдэж байгаа шүү дээ, тийм ээ.

Тэгэхээр энэ мэдлэг гэдэг чинь туршилага, мэдлэг гэдгийг чинь мэдлэг гэдэг чинь бас сонголт хийх чадвар гэж байгаа шүү дээ. Тэгэхээр хамгийн их туршилагатай, сонголт хийх чадвартай хүмүүс энэ ахмадууд байгаа шүү дээ. Тийм учраас энэ ахмадын энэ хөгжлийг дэмжих энэ маш чухал зүйл. Энэ чинь бэлэн туршилагууд байна шүү дээ. Тухайлбал бид нарын маш их очдог энэ Солонгос улс чинь таксины жолооч нар нь тэр чигээрээ ахмад хүмүүс байж байгаа шүү дээ. Европын орнууд чинь энэ харуул, хамгаалалтын үүргийг чинь ахмадууд гүйцэтгэж байна шүү дээ. Азийн зарим орнууд энэ гудамж хөдөлгөөний тэр хүүхдүүдийг гудамж нэвтрүүлэх энэ ажлыг чинь ахмадууд хийж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ энэ тэрийг зохицуулах барих юунууд дээр нь ямар бодлого байдаг юм бэ? Яах вэ, хууль орж ирж байна. Яам ер нь ямар бодлоготой байна. Энэ дээр хариулт өгөөч.

Г.Занданшатар: 5. Ажлын хэсгийн 5.

Гишүүний асуултад хариулъя. Ахмад настны

Г.Занданшатар: Өөрийгөө танилцуул, протоколд тэмдэглэгдэж байгаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яамны Халамжийн газрын дарга Ундрал гишүүний асуултад хариулъя. Ахмад

настны сэтгэл зүйн дэмжлэгийг хууль дээр ямаршүү байдлаар оруулсан бэ, ахмад настны үзүүлэх үйлчилгээнүүдийн төрлийг бид нар нэмэгдүүлсэн байгаа. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн 10 төрлийн үйлчилгээндээ ахмад руу чиглэсэн өдрийн үйлчилгээ болон бид нар Ахмадын өргөө, ахмадын танхим, ахмадын гэсэн 513 байгууллагаар дамжуулаад, энэ олон төрлийн үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр хуулийн заалт дээр шинээр оруулсан.

Өдрийн үйлчилгээ болон асран хамгаалах, асаргааны үйлчилгээ гэх зэргээр дагаж мөрдөж байгаа үйлчилгээгээ бид нар арай нээлттэй болгож байгаа. ААН болон төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх хэлбэрээр нэлээдгүй бас зохицуулалтыг дэлгэрэнгүй оруулж байгаа.

Дээрээс нь бас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр бид нар 2 жилийн хугацаанд 3 аймаг, орон нутгуудаар ахмад настны энэ ахмадын үйлчилгээг олон улсын түвшинд 3 төрлөөр нэмэгдүүлсэн энэ 2 жилийн туршилтын хугацаагаар нэлээдгүй дэвшилттэй үйл ажиллагаануудыг нэвтрүүлсэн байгаа. Үүнийгээ бид нар шинэ хуулийн зохицуулалтаар зохицуулаад ажиллаж байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Тэр сэтгэл гутралтай холбоотой асуулт асуугаад хариулт аваагүй байна. Тэрийгээ хэлчхээрэй, товчхон юм байвал.

2 дугаарт, нь энэ ахмадын хөгжлийн төв гээд манай Дархан-Уул аймагт бид нар хийсэн. Энэ бол Монгол Улсад үлгэр жишээ ажиллаж байгаа. Ахмадууд тэнд ирж чөлөөт цагаа өнгөрүүлж байгаа, эмнэлгийн урд талын үйлчилгээг үзүүлж байгаа, гэрээр нь очиж эмнэлгийн үйлчилгээ эмнэлгийн урд талын үйлчилгээнүүдийг үзүүлж байгаа. Үүнийг бүх аймгуудад л хиймээр байгаа юм,

ахмадуудад зориулж. Тэгээд энэ чиглэлээр ямар юм байдаг юм бэ.

2 дахь асуулт энэ Азийн хөгжлийн банкны юу зээлээр тэр хөгжлийн бэрхиээлтэй хүний төвийг бас Дархан-Уул аймагт нээсэн. Бас их сайн ажлын эхлэл их сайн явж байгаа. Тэгээд үүнийг бас ингээд цаашидаа үргэлжлүүлээр байна. Энэ хөгжлийн бэрхиээлтэй иргэд дотор чинь ахмадууд их байдаг. Тийм учраас энэ чиглэлээр та нар ямар бодлого байна, товч хэлээч.

С.Одонтуяа: Хэддүгээр микрофон хариулах вэ? 3 дугаар микрофон.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Отгонбилэг шинжээч Адьшаа гишүүний асуултад хариулъя. Уучлаарай Баттөмөр гишүүний асуултад.

Тэгэхээр юу яагаад Ахмад настны хөгжлийн төвийн асуудал дээр яг энэ Дархан-Уул аймаг болон бусад газар ингээд туршилтаар хэрэгжүүлж байгаа энэ үйл ажиллагааг цаашид ингэж улсын хэмжээнд өргөжүүлэх зорилгоор яг энэ хуулийн төсөлд энэ төвүүдийг дэмжих, санхүүжилтийг нь оруулах, дээрээс нь үйл ажиллагааны журам дүрмийг нь Эрүүл мэндийн болон Нийгмийн хамгааллын сайд хамтарч батлахаар бол тусгаж байгаа. Тийм.

Тэгэхээр бол яг энэ төвүүдийг бол цаашид үлгэр жишээ болгоод бусад газруудад хэрэгжүүлээд, тогтвортой ажиллуулах боломжийг нь энэ хуулиар бол зохицуулж өгсөн гэсэн үг.

Өмнө нь асуусан тэр нөгөө эмч, багш нарыг цаашид тогтвортой ажиллуулах гэдэг дээр энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт 9.1.4, 9.1.5 гээд Хөдөлмөрийн сайд, Боловсролын сайдтай хамтран тэтгэвэрт гарсан багш нарыг ажиллуулах, насан туршийн боловсрол олгох, бусад хөтөлбөр, арга хэмжээнд татан оролцуулах чиглэлээр бол хөтөлбөр боловсруулах, мөн эрүүл мэндийн асуудал

дээр ч гэсэн хамтарч ажиллах асуудлуудыг тусгасан байгаа.

Сэтгэл гутралын асуудлаар одоогоор судалгаа хийсэн асуудал дээр бол мэдээлэл алга байна. Тийм. Тэгэхдээ ерөнхийдөө бол ахмад настнуудын хувьд ганцаардал, тийм чиглэлийн асуудал бол өндөр байгаа. Энэ дээр бол тэр олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, өдрийн үйлчилгээг хөгжүүлснээр бол бас нийгмийн амьдралд оролцох оролцоог нь дэмжих чиглэлийн үйлчилгээнүүдийг өргөжүүлэхээр тусгасан байгаа юм.

С.Одонтуяа: Одоо Тлеуханы Аубакир гишүүн асуултаа асууна.

Т.Аубакир: Баярлалаа. Энэ хууль санаачлагчдад бас талархлаа илэрхийлье. Нямаагийн Энхболд дарга, манай Баделхан гишүүн энэ тэр бас ахмадууд руугаа чиглэсэн маш дэвшилттэй ийм хууль санаачлаад ажиллаж байгаа юм.

Би энэ хуулийг дэмжиж байгаа. Ганц 2 асуулт байна. Ний нуугүй хэлэхэд манай улсын хувьд тэтгэвэртээ гараад л үндсэндээ ахмадууд маань нийгмээс шахагдчихдаг, ажил эрхлэх боломж байхгүй. Ингээд физический байдаг ч юм уу моральный улам хурдан хөгшрөлтөд өртдөг. Эдгээр хүмүүсийнхээ мэдлэг, туршилагыг бид нар энэ манай улс маань эргээд ашиглах хэрэгтэй л дээ. Энэ хууль дээр заалт бол явж байна. Гэхдээ тодорхой биш байна. Зарим нэг ахмад настнаар гүйцэтгүүлж болох төрлийн ажлыг энэ ахмад хүнээр гүйцэтгүүлэх ийм энэ боломжийг тэр тухайн төрийн байгууллагынхаа хэдэн хувь гэдэг юм тийм ээ. 1-2 хүн заавал ажиллуулах ийм эрх зүйн зохицуулалт болгож оруулж болох уу? Жишээлбэл Япон улсад аэрофорт дээр буунгуут тэр нисэх буудлын ойр зуурын хүний хөдөлгөөнийг ахмад настнууд гүйцэтгээд зогсож байдаг шүү дээ. Яг ийм байдалтай энэ төрийн албаны нэгээс доошгүй 2 орон тоог заавал ахмад хүнээр гүйцэтгүүлнэ ээ

гэсэн байдалтай оруулж өгч болдоггүй юм уу?

2 дахь асуулт маань Засгийн газраас хэрэгжүүлж байгаа энэ ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр ер нь яг ямар байдалтай явж байгаа вэ. Манай яамныхан хариулж өгөх үү? Энэ ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр маань яг ямар байдалтай үргэлжилж байна. Энэ ер нь үр дүнгээ өгч байгаа юу гэсэн ийм 2 асуулт байна.

1 дүгээрт, яг энэ төрийн байгууллагууд дээр яг ингэж зоож өгч болох уу?

2 дугаарт, энэ ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр маань яг ямар хэмжээнд явж байна вэ гэсэн асуулт байна. Энхболд дарга хариулах уу?

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Хууль санаачлагч Нямаагийн Энхболд хариулна.

Н.Энхболд: Энэ хуулийн яг тодорхой заалтуудыг нь бүгдээрээ ингээд цогцоороо үйлчлэхээр яг таны саяын асууж байгаа энэ асуултуудад хариу болох юм байгаа юм. Жишээ нь 9.1.7-д 7.1-д заасан үйлчилгээг ахмад настан, ахмадын байгууллага, ахмад настны холбоо, сан, хоршоо, ахмадын оролцоотой байгууллагууд гэрээлэн гүйцэтгэхийг дэмжинэ. Энэ чиглэлээр хувиараа ажилласан ахмад настны цалин, хөлсийг ажилласан цагаар нь, өдрөөр нь, сараар тооцоод гэрээний дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн дагуу бусад холбогдох сангаас санхүүжүүлэх гээд заасан.

Ажил олгогч хөдөлмөрийн гэрээ, гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.3.4-д заасан тэтгэвэр авагч өөрөө хүсвэл ажил олгогчийн цалин, хөлсний сан түүнтэй адилтгах орлогоос тэтгэврийн даатгал

төлөх шимтгэл 8,5 хувийг Нийгмийн даатгалын санд төлөхгүй.

Төрийн албаны тухай хуулийн 2.7.4-д заасан нөхцөл үүссэн бол төрийн жинхэнэ албанд ажиллаж байсан ахмад настны хуулийн 3.1, 3.2 дахь хэсэгт заасан иргэнийг мэргэжил, ур чадварыг нь харгалзаад томилон ажиллуулж болно.

ААНБ нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн 5.1-д заасан насанд хүрсэн ахмад настныг өөрөө хүсэлт гаргаагүй байхад нь тэтгэвэрт гарахыг шаардах энэ үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн гэрээ цуцлахыг хориглоно.

Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай ААНБ нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлтэй л биш юм ажлын байранд нь ажиллуулна гэсэн ийм заалтууд байгаа юм. Энэ сая таны хэлсэн зүйлүүдийг хариулт болно гэж бодож байна. Тийм.

Яамнаас товчхон.

С.Одонтуяа: 4 номер. Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт ахмадуудын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бас 3 хөтөлбөрийг манай яамны тухайд бол бас хэрэгжүүлээд явж байгаа. Энэ дээр 1-д, ахмад настанд эргэн төлөх нөхцөлтэйгөөр хөнгөлөлттэй санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа.

2-т, ахмад настны зөвлөх үйлчилгээ, хүүхэд хамгаалагч үйлчилгээ гэсэн 3 үйлчилгээ дээр бол манайх дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа.

23 оны байдлаар 2100 ахмад настанд 5,6 тэрбум төгрөгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлсэн байгаа. Үүний 4,7 тэрбум нь бол хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн гэсэн ийм үйлчилгээнүүдийг үзүүлээд явж байгаа.

С.Одонтуяа: Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу. Үг хэлэх гишүүд алга байна.

Байнгын хорооны саналаар Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

1 хуулийг нь үлдээчхэж, уучлаарай. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт.

Үгүй ээ, би кнопоо дарж чаддаггүй. Занданиатар дарга бид 2-ын кноп ингээд хоёулаа дэмжих дээр. Тийм миний юуг өгчих үү?

Уучлаарай Аубакир гишүүн горимын санал гаргая.

Т.Аубакир: Сая дэмжиж санал өгсөн боловч аппарат ажилласангүй. Дахиж санал хураалт явуулж өгнө үү.

С.Одонтуяа: Аубакир гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт.

51,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул. Тийм шүү дээ, нээрээ, саяынх чинь горимын санал байсан.

Тэгэхээр түрүүний миний уншсан нийтдээ 11 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

59,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

16.34 цаг

Гишүүд ээ, одоо ганцхан хууль байгаа шүү.

Г.Занданиатар: Бүгдээрээ байж байгаарай.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их

Хурлын гишүүн Тэмүүлэн гишүүн танилцуулна. Индэрт урьж байна. Төсвийн байнгын хорооны дарга.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 10 гишүүн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хорооны 2023 оны 18 дугаар тогтоолоор хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллалаа.

Төсвийн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс төслийн 1 дүгээр зүйлийн чихрийн агууламж орсон хийжүүлсэн болон хийжүүлээгүй ус, ундаа гэснийг чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа ус гэж өөрчлөх. Мөн хуулийн хэрэгжих хугацааг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх нь зүйтэй гэсэн санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Онцгой албан төрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан

талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Онцгой албан төрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй 5 санал байгаа.

Эдгээр 5 санал Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн 4 дүгээр зүйлд, доор дурдсан агуулгатай 4.1.5 дахь хэсэг” гэснийг “хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт” гэж, 4.1.5 дахь заалтын дугаарыг “4.1.6” гэж тус тус өөрчлөн, мөн заалтыг төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт:

4.1.6.чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус.

Тайлбар: “төрөл бүрийн ундаа, ус” гэдэгт үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар ашиглах байгалийн гаралтай өтгөрүүлсэн шүүс, нунтаг баяжмал хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

23 гишүүн дэмжиж, 60,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 7 дахь заалт:

7	Чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус	1 литр
---	--	--------

Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Жавхлан сайд аа, энэ татвар нэмж байгаа юмнуудыг чинь.

3. “3/6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг:

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй 5 санал байгаа.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1. Төслийн нэрийн “; өөрчлөлт” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Хүрэлбаатарын Булгантуяа, Ганзоригийн Тэмүүлэн, цаашид “ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт.

61,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. 60,5.

6.9. Энэ хуулийн 4.1.6-д заасан чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/
-----	--	-----------	--

			2027 он	2028 он	2029 он ба түүнээс дээш
1	Чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус	100 мл-т агуулагдах чихэр, чихэр орлуулагч 0-5 гр	1 литр	0	0

		100 мл-т агуулагдах чихэр, чихэр орлуулагч 5 гр-с дээш	1 литр	500 төгрөг	525 төгрөг	550 төгрөг
--	--	--	--------	------------	------------	------------

Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

5. Төслийн 4 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөн, мөн зүйлийн “2024 оны” гэснийг “2027 оны” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

16.41 цаг

Улсын Их Хурлын гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүд ээ, анхаарч мэдээлэх 3 зүйл байна.

60,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Өмнөх санал ч гэсэн 60,5 хувийн саналаар санал дэмжигдсэн.

Бүх саналууд 60,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

1 дүгээрт, нь Улсын Их Хурлын даргын захирамж гарч, мөн холбооны хууль болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудыг сонгогчдоор иргэдээр хэлэлцүүлж, санал дүгнэлтийг хөдөөд, Малчин өрхүүдийн нэгдсэн холбооны тухай хуулийг хэлэлцүүлэх, хот болон бүх суурин газруудад Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэлэлцүүлнэ. Энд идэвхтэй зохион байгуулаад санал, дүгнэлтээ тайлан, дүгнэлтээ Байнгын хороондоо ирүүлнэ.

2 дугаарт, нь сүүлийн үед энэ ашигт малтмалын лицензийн олголттой холбоотой олон асуудал хөндөгдөж байгаа. Ийм учраас Ашигт малтмалын

хяналт шалгалтын түр хороо үйл ажиллагаагаа идэвхжүүлэх хэрэгтэй байна. Ашигт малтмалын одоо явж байгаа орон нутагт ажиллаж байхдаа ашигт малтмалын холбоотой санал, гомдлуудыг авчирч ашигт малтмалын хяналт шалгалтын түр хорооны хурал нээлттэй сонсголыг 5 дугаар сарын 20-ноос 25-ны хооронд зохион байгуулна. Энэ бэлтгэлийг хангах хэрэгтэй.

Мөн ногоон автобус хяналт шалгалтын түр хорооны нээлттэй сонсголуудаа газрын энэ нээлттэй сонсголуудыг яаравчлах, түргэвчлэх талаар Улсын Их Хурлын гишүүд санаачилгатай ажиллаж, ирцээ бүртгүүлж, хяналт шалгалтын түр хороод хуралдахгүй байгааг ирэх 7 хоногт дуусгана шүү. Үүнийг онцгой анхаармаар байна. Энэ асуудал онцгой чухал асуудал болоод байна.

Бас Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийн мэндчилгээ дэвшүүлж, олон гишүүд маань үг хэлсэн. Тэгээд сэтгүүлчиддээ Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийн мэндчилгээ дэвшүүлэе. Жил бүрийн 5 дугаар сарын 03-ыг дэлхий даяараа тэмдэглэж байхаар НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас шийдвэрлэсэн. 93 онд тунхагласан. Энэ өдөр бол Хэвлэлийн эрх чөлөөний хэрэгжилтэд улс орон бүрт үнэлэлт, дүгнэлт өгдөг. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл сэтгүүлчдийн хараат бус байдлыг сахин хамгаалж, арга хэмжээг өрнүүлж, эрх чөлөөгөө боомилуулсан сэтгүүлчдэд хүндэтгэл үзүүлдэг. Түүнчлэн хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд заасан иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрх чөлөөг хүндэтгэж, сахих шаардлагатайг улс орнуудын төр засгийн удирдлагуудад сануулдаг өдөр юм. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дугаар дахь заалтад итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй хэмээн заасан байдаг.

Ийм учраас иргэдийнхээ өөрийн гэсэн үзэл бодол, итгэл үнэмшилтэй

байж, түүнийгээ илэрхийлж, үг хэлэх, жагсааж цуглах, хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах, мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх болсон нь Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөө эрх зүйн хувьд бол Үндсэн хуулиараа бүрэн хангагдсан гэсэн үг юм. Түүнчлэн төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргах, төрөөс мэдээлэлд хяналт тавих, төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулиар хориглосон. Манай парламент ч гэсэн төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэнийхээ мэдээлэл эрж хайх, хүлээн авах, мэдэх эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баталсан.

Иргэдийнхээ үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах зорилгоор олон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нээлттэй сонсгол, байнгын хэлэлцүүлгүүд бол иргэдийнхээ мэдэх эрхийг хангахад чиглэсэн ийм цогц өөрчлөлтүүдийг хийсэн. Ингээд Монгол Улс бол хэвлэлийн эрх чөлөөг эрхэмлэн дээдлэхээ хуулиараа тунхагласан хэдий ч элдэв цензур, дарамт, сэтгүүлчдийн дуу хоолой хаахыг оролдох, айлган сүрдүүлэх, нэр төрийг нь гутаах, хүчирхийлэх зэрэг эрсдэлүүд гарсаар байна.

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний 2023 оны индексээр Монгол Улс боломжит 100 онооноос 59,3 оноо авч, дэлхийн 180 орноос 88-д бичигдсэн. 2022 оныхоосоо бол 2 байр ахисан байгаа юм. 2021 оныхоосоо бол 20 байр ухарсан байгаа юм. Энэ бол хэвлэлийн эрх чөлөөг нийт нийгмийн үнэ цэн болгох үйл явц манай улсад бол дунджаас доогуур түвшинд олигтой ахиц гарахгүй байсаар байгааг харуулсан үзүүлэлт юм.

Иймээс энэ чиглэлээр хэвлэл, мэдээллийн ажилтнууд, бодлого боловсруулагчид, нам, улс төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд олон

нийтийн хамтын ажиллагааг тууштай дэмжих нь нэн чухал гэж Улсын Их Хурал үзэж байна. Цаашид хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийх, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын арга механизмуудыг хэвшүүлж, сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх эрхээ эдэлснийх нь төлөө шийтгэдэг байдлыг халж, иргэний няцаах эрхийг хангадаг шинэ тогтолцоо бүрдүүлэх нь чухал байна. Эдгээр болон бусад тулгамдсан асуудлуудаа энэхүү хэлэлцүүлгүүдээрээ ярилцаж, ажил хэрэгч бодитой санал санаачилга гаргана гэдэгт итгэлтэй байна.

Хараат бус, хариуцлагатай, ёс зүйтэй, чөлөөт хэвлэл мэдээлэл бол Монголын сайн сайхан нийгмийн бас баталгаа юм. Тиймээс ирээдүйн сайн сайхны төлөөх үйл хэргийн төлөө хамтарч зүтгэж байхыг уриалж байна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд Улсын Их Хурлын ашигт малтмалын лиценз, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ер нь энэ газрын харилцаатай холбоотой асуудлаар, ашигт малтмалын газрын харилцаатай асуудлаар хяналт шалгалт хийх түр хороо үйл ажиллагаагаа идэвхжүүлж, ойрын хугацаанд бүх мэдээллүүд дээр дүгнэлт хийж, ингээд нээлттэй сонсгол явуулах, ногоон автобус бол энэ хяналт шалгалтын түр хороод идэвхтэй ажиллуулахыг үүрэг болгож байна.

Зарим энэ асуудлыг хянан шалгахтай зэрэгцээд зарим аймгуудад тухайлбал Баянхонгор аймагт лиценз олгосон байсан асуудлуудыг хэдийгээр цуцлуулсан боловч дахиад зарим лицензийн харилцааг үүсгэж байгаа ийм хариуцлагагүй үйл явдал байгаад холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох шаардлагатай гэж үзэж, энэ хяналт шалгалтын түр

хорооны сонсголоор авч хэлэлцэнэ гэдгийг бас мэдэгдэж байна.

Нэг дэхэд энэ хяналт шалгалтын түр хороогоо идэвхжүүлээрэй, Энх-Амгалан гишүүн ээ. Та бас байнга ...

Бас нэг асуудал байгаа нь энэ өнөөдөр Төрийн албан хаагчдын төрийн албаны нийгмийн баталгааг хангах, шилэн ажиллагааны тухай мэдээлэл сонсох байсан. Тэгэхээр төрийн албан хаагчид бол энэ Монгол төрийн гол тулгуур багана. Төрийн албан хаагчдынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах замаар төрийн албан хаагчид маань шударга, хариуцлагатай ажиллах нөхцөлийг бүрдүүлж байж л бас энэ нийгмийн сайн сайхан төрийн бодлого амжилттай хэрэгжинэ.

Тийм учраас энэ төрийн албан хаагчдыг бас хүндэлдэг, дээдэлдэг, төрөө дээдэлдэг энэ хуучин уламжлал, ёс заншлаа сэргээж, энэ төрийн албаны ёс зүйн сахилга хариуцлагын хуулийг чанд мөрдөж, төрийн албан хаагчдын амьдралын баталгааг хангах, элдэв дарамт шахалт улс төрөөс ангид байлгах, гагцхүү төрийнхөө төлөө өргөсөн тангарагтаа үнэнч ч байж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллах шаардлагатай. Энэ чиглэлээр ТАЗ-ийн мэдээллийг бас ирэх 7 хоногт сонсох ийм чиглэлийг оруулсан байгаа гэдгийг мэдэгдье.

Тэгэхээр ирэх 7 хоногт бол төрийн албаны нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр ажлын хэсгүүд байгуулагдаж ажиллана. Тэгээд ирэх 7 хоногт ажиллаад энэ үр дүнгээ танилцуулах хэрэгтэй. Төрийн албан хаагчдаа хамгаалдаг байх хэрэгтэй. Тэдний нэр төрийг нь өргөдөг байх хэрэгтэй. Тэгэхгүй бол төрийн албан хаагчид руугаа дайрч давшилсаар байгаад нөгөө төрийн нэр хүнд чинь өөрөө унаад байгаа байхгүй юу. Тийм ээ.

Тийм учраас үүнийг бол хаана хаанаа их онцгой анхаарах ёстой юм

*байна шүү гэдгийг хамтатган
анхааруулж хэлье.*

*Ингээд өнөөдрийн чуулганы
нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд
өндөрлөсөн тул чуулган өндөрлөснийг
мэдэгдье.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

П.ОЮУНГЭРЭЛ